15.3	МУТХҮБ-2030- ын 2.2.2. Зорилт 4, ТЭМТББ-ын 2.4.1, 3ГУАХ-ийн 3.1.12 заалт	Зонхилон тохиолдох Халдварт өвчиний тандалт, сэргийлэлтийг сайжруулж, өвчиний тохиолдлыг бууруулах 2.4.5, дахь	Эрүүл хүүхдийн түвшин, промилль	16.0-гаас ижүй
15.4	МУТХҮБ-2030- ын 2.2.2. Зорилт 1 ТЭМТББ-ын	Эрүүл мэндийн уйлчилгээний нэмэгдүүлж, тэр, хувийн хэвшлийн туншлэлийг өргөжүүлэх	100000 ногдох эхийн эндэгдлийн түвшин, промилль	25-аас ижүй

	2.4.4, 3ГҮАХ-ийн 3.1.9, 3.1.17	2.4.6, 3.1.16, дахь			сан
	ТЭМТБЕБ-ын 2.4.5, 3ГҮАХ- ийн 3.1.22	Даахь заяалт	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнээс үудэлтэй эрдэлээс урьдчилсан сэрийлэх	Шинээр ашиглалтад орох сумын эрүүл мэндийн 8 төвийн тоо Шинээр ашиглалтад орох Хоёрдугаар шатлалын 5 нэгдсэн эмнэлэг, эмнэлэгийн тоо 2	Шинээр ашиглалтад орох сумын эрүүл мэндийн 8 төвийн тоо Шинээр ашиглалтад орох Хоёрдугаар шатлалын 5 нэгдсэн эмнэлэг, эмнэлэгийн тоо 2
	15.5			Шинээр ашиглалтад орох Гуравдугаар шатлалын 4 эмнэлэгийн тоо Чанарын хяналт баталгаажуулалтад 100 хамрагдах тоног төхөөрөмж, хувиар	Шинээр ашиглалтад орох Гуравдугаар шатлалын 4 эмнэлэгийн тоо Чанарын хяналт баталгаажуулалтад 100 хамрагдах тоног төхөөрөмж, хувиар
				Нэг удаагийн хэрэгслийн нийт хангамж, хувиар Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангалт, их засварын ажил	Нэг удаагийн хэрэгслийн нийт хангамж, хувиар Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангалт, их засварын ажил
Зорилт 16. Хүн амын хөгжил, нийтийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.					
16.1	МУТХҮБ-2030-ын 2.2.1. Зорилт 2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зохион болон хувь хүний ур чадварт тушиглэсэн ажлын байр бий болгох	Бий болох ажлын байрны тоо, Мянга Төсөл, хөтөлбөрт хамрагдах хүний тоо, Мянга	45.0-аас доошгүй Төсөл, хөтөлбөрт хамрагдах хүний тоо, Мянга	30.0 ХЭДС, ХНХЯ 20.0 Гадаад эх үүсвэр

16.2	ЗГУАХ-ийн 3.3.3 дахь заалт	“Гэрээт малчин” төсөл хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг ажилтai, орлоготой болгох	Төсөлд хамрагдах гэрээт малчин өрхийн тоо	1000 орчим	2.0 ХЭДС	ХНХЯ
16.3	ЗГУАХ-ийн 3.3.6 дахь заалт	Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадын ажиллагчдын тоог бууруулах	Гадаад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгох урьдчилсан зөвшөөрлийн тоог бууруулах, хувиар	20.0	-	ХНХЯ
16.4	ЗГУАХ-ийн 3.4.9 дэх заалт	MCYT, Политехник коллежид элсэн суралцагчдын тоог Нэмэгдүүлж, төгсгөгчдөд мэргэжил, ур чадварыг эзэмшигүүлэх	Мэргэжил, ур чадварыг эзэмшигүүлэх Төгсгөгчийн тоо, мянга	20.0	-	ХНХЯ
16.5	МУТХҮБ-2030-ын 2.4. Зорилт 2, ЗГУАХ-ийн 3.3.23 дахь заалт	Төрийн албан хаагчдын ажлын ачаалал, ур дүн, хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, инфляцийн цалинг түвшинтэй уялдуулан Нэмэгдүүлэх	Үйл хэрэгжилт, хувиар	100	-	Засгийн газар, ХНХЯ
16.6	ЗГУАХ-ийн 3.3.23 дахь заалт	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жил тутамд замаар иргэдийн орлогын түвшинг дээшлүүлэх	Үйл хэрэгжилт, хувиар	100	Улсын төсөв	16.4 ХНХЯ
16.7	МУТХҮБ-2030-ын 2.2.1. Зорилт 1, ЗГУАХ-ийн 3.3.23 дахь заалт	Ядуу, эмзэг булагт олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулж Нэмэгдүүлэх	Үйл хэрэгжилт, хувиар	100	Улсын төсөв	17.8 ХНХЯ
16.8	МУТХҮБ-2030-ын 2.2.1. Зорилт 1,	Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн болон хөдөлмөр, арга хэмжээ, Үйлчилгээг булаг тус бүрт ялгавартайгаар хүргэх	Ядуурлаас гарах өрхийн тоо, мянган өрх	16.0-гаас доошгүй	-	ХНХЯ

16.9	3ГҮАХ-ийн 3.3.23 заалт	Үнэ түвшинтэй уялдуулан хэмжээг нэмэгдүүлэх	Үнэ ханшины өсөлт, инфляцийн тэтгэврийн	Үйл хэрэгжилт, хувиар ажиллагааны	100	Улсын төсөв 119.5	ХНХЯ	
16.10	3ГҮАХ-ийн 3.3.34 заалт	Хүүхэд даатгуулсан хамааран адил хувиар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хүүхэд терүүлсэн даатгуулсан хамааран адил хувиар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Эзжүүдэд хэлбэрээс үл эх дундаж тэтгэмж олгох чалингаас тэтгэмж авах хувь	Сайн дураар дааттуулсан чалингаас тэтгэмж авах хувь	100	4.5 НДС	ХНХЯ
16.11	3ГҮАХ-ийн 3.3.35 заалт	Төрүүлж өстөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хэрэгжилтийг хангаж ажиллах	Төрүүлж өстөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл хэрэгжилт, хувиар ажиллагааны	100	7.5 НДС	ХНХЯ	
16.12	3ГҮАХ-ийн 3.3.35 заалт	0-3 насны хүүхдээ асарч буй ээжүүдийн нийгмийн даятгалын шишмтэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бурдүүлэх	Хамрагдах эхчүүдийн тоо	50.0 мянгаас доошгүй	16.0	Улсын төсөв 3.4 НДС	ХНХЯ	
16.13	3ГҮАХ-ийн дахь заалт, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.1- 4.3.9 зорилт	Гэр бүлийн үнэт бэхжүүлж, гэр хариуцлагыг зорилгоор гэр болд боловсрол, хөгжлийг хөтөлбөр хэрэгжүүлэх	Зүйлсийг нэмэгдүүлэх чиглэсэн дэмжих тоо	Боловсруулах төлөвлөгөө, стандартын тоо	2	Улсын төсөв 0.1	ХНХЯ	
16.14	3ГҮАХ-ийн 3.4.5 заалт	Хүүхэд, ёсвер үеийнхэнд үндэсний өв соёлыг уламжлууллах, тэдний хүмүүжил, төлөвшилд чиглэсэн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо	5.0 мянгаас доошгүй	0.2 Улсын төсөв	-	ХНХЯ	
16.15	3ГҮАХ-ийн	Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх,	Хөтөлбөр,	арга	100	-	ХНХЯ	

	3.4.4 Дэх заалт	Эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээ авч, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх	Хэмжээний хэрэгжилтийн явц, хувиар	
16.16	ЗГУАХ-ийн 3.4.11 заалт	Залуучуудын хөтжлийн төвөөр дамжуулан зорилтот бүлгийн өсвөр үе, залуучуудад амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүн боловсрол олгож, сургалтад хамруулах	Хамрах хүрээний хүн ам, хувиар	- ХНХЯ
16.17	ЗГУАХ-ийн 3.3.22 заалт	Төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	0.1 Улсын төсөв ХНХЯ
16.18	ЗГУАХ-ийн 3.3.28 заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох ээлтэй орчныг бурдүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	0.2 Улсын төсөв ХНХЯ
16.19	МУТХҮБ-2030-ийн 2.2, ЗГУАХ-ийн 3.3.27, 5.1.7 заалт	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	0.1 Улсын төсөв ХНХЯ
ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДАД БОДЛОГО, БАТЛАН ХАМГАЛАХ САЛБАРЫН БОДЛОГО				
Зорилт 17. Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, төрийн албаны тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллана.				
17.1	Хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай үндсэн	Шүүхийн шинжилгээний тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Боловсруулах эрх зүйн бармыг бичгийн тоо	- ХЗДХЯ

	ЧИГЛЭЛЛИЙН 158, 161 дүгээр заалт						
17.2	ЗГҮАХ-ИЙН 5.4.9 дэх заалт	Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1.3 Улсын төсөв, Х3ДХЯ	
17.3	ЗГҮАХ-ИЙН 5.5.2 заалт	Дотоодын цэргийн үйл ажиллагааг жигдруулж, материаллаг баазыг бэхжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	34.1 Гадаад эх ҮУСВЭР	4.7 Улсын төсөв	Х3ДХЯ
17.4	ЗГҮАХ-ИЙН 5.4.14 заалт	Хил хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техник хэрэгслийг нэвтрүүлэх	Бүр нуурын усан хил хамгаалалтад нийлүүлэх хөнгөн хөлгийн тоо	Орчин үеийн зэвсэг, галт хэрэглэлээр хангах үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2	1.0 Улсын төсөв	Х3ДХЯ
17.5	МУТХҮБ-2030-ын 2.2.2. Зорилт 1, ЗГҮАХ-ИЙН 3.1.10, дэх заалт	Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийг шаардлагатай төхөөрөмж, материалаар	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1.7 Улсын төсөв	0.4 Улсын төсөв	Х3ДХЯ
17.6	ЗГҮАХ-ИЙН 5.2.10 заалт	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, хүртээмжтэй шуурхай нөхцөлийг бурдүүлэх	Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20.0	11.1 Улсын төсөв, Х3ДХЯ	16.8 Гадаад эх ҮУСВЭР	

17.7	ЗГУАХ-ийн 5.3.7 дахь заалт	Иргэдийн хангахуйц мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх тогтолцоог буруулж	Эрэлт эрх эрх мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр	Хэрэгцээг мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилт , хувиар	Бүх нийтийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт , хувиар	Эрх зүйн зүйн хөтөлбөрийн хэрэгжилт , хувиар	Зүйн зүйн хөтөлбөрийн хэрэгжилт , хувиар	Улсын төсөв, Х3ДХЯ	Улсын төсөв, Х3ДХЯ
Зорилт 18. Төрийн болон олон улсын итгээмжлэлийн үйл ажиллагааг сайжруулна.									
18.1	МУТХҮБ-2030- ын 2.1.1-2.1.3, 2.1.5, 2.1.7 дахь заалт, ЗГУАХ-ийн 2.7 дахь заалт	Ноос, ноолуур, арьс шир, оёмолт бүтээгдэхүүн, аялал жуулчлаг, хүнсний салбарын стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх	Шинээр боловсруулж батлуулах стандарт	Шинээр боловсруулж батлуулах стандарт	5	-	-	Стандарт, хэмжил зүйн газар /цаашид “СХ3Г” гэх/	Стандарт, хэмжил зүйн газар /цаашид “СХ3Г” гэх/
18.2	МУТХҮБ-2030- ын 2.1.3, 2.1.5 дахь заалт, ЗГУАХ-ийн 2.8 дахь заалт,	Улсын эталоны нарийвчлалын түвшинг баталгаажуулалтын болон этalon лабораторийг байгуулах	Шинээр лаборатори	Шинээр байгуулах	2	-	-	СХ3Г	СХ3Г
18.3	МУТХҮБ-2030- ын 2.1.3, 2.1.5 дахь заалт, ЗГУАХ-ийн 2.8 дахь заалт	Олон улсын байгууллагын хэлэлцээрт нэгдэх дахь заалт	Итгээмжлэлийн нэгдэн орох хэлэлцээр	Нэгдэн орох хэлэлцээр	2	0.05	Улсын төсөв	СХ3Г	СХ3Г
18.4	ЗГУАХ-ийн 5.2.1 дэх заалт	Төрийн болон орон нутгийн ёмчийн талаар хууль эрх зүйн орчныг боловсруонгуй болгож, компанийн сайн засаглалыг хөгжүүлэх замаар төрийн ёмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	Шинэчлэн хууль	Шинэчлэн найруулах	1	-	-	Төрийн ёмчийн бодлого, зохицуулалт ын газар	Төрийн ёмчийн бодлого, зохицуулалт ын газар
Зорилт 19. Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийн зэрэгцээ хилгийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлнэ.									
19.1	Гадаад бодлогын үзэл	Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил	Замын-Үнд-Эрээний чөлөөт бүс байгуулах	80.0	-	-	-	Шадар сайдын	Шадар сайдын

	Баримтлал /цаашид “ГБҮБ” гэх/ 3.21.6 дахь заалт, 3ГУАХ- ийн 5.6.5, 5.6.7 дахь заалт	Дамнасан чөлөөт бус байгуулах ажлыг эрчимжүүлэх	ажлын явц, хувиар	ажлын явц, хувиар	Ажлын алба, ГХЯ, СЯ
19.2	3ГУАХ-ийн 5.6.5, 5.6.8 дахь заалт	Монголын бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бурдүүлэх, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг бууруулах	Яриа хэлэлцээр хийх орон	2 Улсын төсөв	0.14 ГХЯ
19.3	ГБҮБ-ын 2.14.1 дэх 3ГУАХ-ийн 5.6.2 дахь заалт	Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0 Улсын төсөв	0.2 ГХЯ
19.4	ГБҮБ-ын 6.27.5 дахь дэд заалт, 3ГУАХ-ийн 5.3.12, 5.6.9, 5.6.12 дахь заалт	Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консуулын газар Үйл Нэмэлт, өөрчлөлт оруулах дүрээм	2 - 1	- ГХЯ
Зорилт 20. Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, зэвсэгт хүчиний барилгын засвар төслийг хэрэгжүүлнэ.					
20.1	3ГУАХ-ийн 5.5.5 дахь заалт	Зэвсэгт хүчиний энхийг дэмжих үйл ажиллагааны нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100 Зэвсэгт хүчиний хөгжлийн сан /цаашид	2.9 Улсын төсөв, Батлан хамгаалах яам /цаашид “БХЯ” гэх/ цаашид

				"ЗХХС" гэх/
20.2	3ГҮАХ-ийн 5.5.6 заалт	"Барилгын засвар" төслийг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчиний нэгтгэл, анги, салбаруудын барилга, байгууламжийн их засварын ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	0.5 Улсын төсөв, 100
20.3	3ГҮАХ-ийн 5.5.5 заалт	НҮБ-ын ажиллагаанд энхийг сахиулах инженерийн ротыг бэлтгэж, оролцуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	1.3 3ХХС /цаашид "ЗХЖШ" гэх/
20.4	3ГҮАХ-ийн 5.5.6 заалт	Материал хэрэгслийн нөөцийг зэвсэгт хүчиний хэмжээнд оновчтой шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	- - БХЯ, ЗХЖШ
20.5	3ГҮАХ-ийн 5.5.2, дахь заалт	Зэвсэгт хүчиний лабораторийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2030/-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	0.6 3ХХС БХЯ

--000--

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг боловсрууллаа.

Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д тусгагдсан зорилт, арга хэмжээ болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, яамд, агентлагаас ирүүлсэн саналд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулсан болно.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл нь Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт, 123 бодлогын арга хэмжээг тусгаснаас гадна зорилт, арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг мөн тусгасан.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд 2019 онд татварын орчныг шинэчлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах; төсөв, мөнгөний бодлогыг хослуулах замаар инфляцийг зорилтот түвшинд байлгах; ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах; нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшнээс бууруулах замаар дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг зэрэг болгох нөхцөлийг бүрдүүлэх; эдийн засгийн суурь үзүүлэлтууд болон хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимижг нэмэгдүүлэх; хөнгөн хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйг ахуйн чанарыг сайжруулах; геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх; эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх; бодит салбарын өсөлтийг дэмжих, зам, тээврийн бодлого хэрэгжүүлж, логистикийн сүлжээг өргөжүүлэх чиглэлээр тодорхой арга

хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд эдгээр салбаруудын өсөлтийн нөлөөгөөр ДНБ-ий бодит өсөлт хангагдах боломж бүрдэнэ.

Бус нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах; агаар орчны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийн хамгаалалт зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх; гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүний чадавхийг сайжруулж, гамшгийн үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг тусгасан.

Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын хүрээнд боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх; соёл урлагын салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлж, нийтийн биеийн тамир, зохистой хөдөлгөөнөөр хичээллэсэн иргэдийг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулах; эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх; Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх; төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх; хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэх чиглэлээр зорилт, арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээнд эрх зүйн салбарын шинэчлэлийг үргэлжлүүлж, төрийн албаны тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулах; төрийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, стандарт хэмжил зүйн байгууллагын олон улсын итгэмжлэлийн үйл ажиллагааг сайжруулах; хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх; энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний барилгын засвар төслийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой зорилт тавин ажиллана.

Салбарын яамд, агентлагуудаас ирүүлсэн арга хэмжээний саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа бодлогын зорилт, арга хэмжээг улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 20 зорилт 123 арга хэмжээний хүрээнд нийтдээ 8 их наяд 619.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 78.3 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 1 их наяд 800.3 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 5 их наяд 172.8 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 568.3 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.

оOо

төсөл



**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019
ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2020-2021 ОНЫ
ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

Агуулга

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА.....	10
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2017 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ, 2018 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ.....	10
1.1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ	10
1.1.1. Эдийн засгийн өсөлт	10
1.1.2. Хэрэглээ, хуримтлал	11
1.1.3. Инфляци	12
1.1.4. Гадаад худалдаа	13
1.1.5. Төлбөрийн тэнцэл	16
1.1.6. Мөнгөний нийлүүлэлт	18
1.1.7. Санхүүгийн зах зээл	19
1.1.8. Ажилгүйдэл	20
1.2. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ	20
1.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр.....	20
1.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэр	24
1.2.3. Эрчим хүч.....	26
1.2.4. Зам, тээвэр	28
1.2.5. Барилга, хот байгуулалт	30
1.2.6. Аялал жуулчлал	31
1.2.7. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо	32
1.3. ХҮНИЙ ХӨГЖИЛ	33
1.3.1. Хүний хөгжил	33
1.3.2. Хөдөлмөр эрхлэлт.....	36
1.3.3. Ядуурал.....	37
1.3.4. Нийгмийн даатгал.....	38
1.3.5. Нийгмийн халамж.....	39

1.3.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	40
1.3.7. Эрүүл мэнд	43
1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ	46
1.4.1. Байгаль орчин, ногоон хөгжил.....	46
1.5. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ	49
1.5.1. Хууль, эрх зүйн шинэтгэл.....	49
1.5.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалт	52
1.5.3. Стандарт, хэмжил зүй	53
1.5.4. Улсын мэргэжлийн хяналт	53
1.5.5. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах	54
1.5.6. Онцгой байдал.....	55
1.6. ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ	55
1.6.1 Гадаад харилцаа	55
1.6.2. Батлан хамгаалах.....	58
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2020-2021 ОНЫ ХАНДЛАГА	60
2.1 МАКРО ЭДИЙН ЗАСАГ	60
2.1.1 Эдийн засгийн өсөлт	62
2.1.2 Хэрэглээ, хуримтлал	63
2.1.3 Инфляци	64
2.1.4 Гадаад худалдаа	64
2.1.5 Төлбөрийн тэнцэл	65
2.1.6 Ажилгүйдэл	65
2.2 БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ	65
2.2.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр.....	65
2.2.2 Уул уурхай	67
2.2.3 Эрчим хүч.....	68
2.2.4 Зам, тээвэр	69
2.2.5 Барилга, хот байгуулалт	70
2.2.6 Аялал жуулчлал	70
2.2.7 Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо	71
2.3 ХУНИЙ ХӨГЖИЛ	71
2.3.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	71

2.3.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	72
2.3.3 Эрүүл мэнд	72
2.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ	73
2.4.1 Байгаль орчин, ногоон хөгжил.....	73
2.5 ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ	74
2.5.1 Хууль, эрх зүйн шинэтгэл.....	74
2.5.2 Төрийн өмчийн бодлого, зохицуулалт	74
2.5.3 Стандарт, хэмжил зүй	75
2.5.4 Улсын мэргэжлийн хяналт.....	75
2.5.5 Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах	76
2.5.6 Онцгой байдал.....	76
2.6 ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ	76
2.6.1 Гадаад харилцаа	76
2.6.2 Батлан хамгаалах.....	77
ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД	78
ДӨРӨВ. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД ОРЧИН	80
4.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ, ТҮҮНИЙ ТӨСӨӨЛӨЛ	80
4.2 ГОЛЛОХ АШИГТ МАЛТМАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА	82
ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО 85 ЗУРГАА. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	86

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Инфляцийн бүтцийн задаргаа	12
График 2. Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт, оны эхнээс.....	13
График 3. Гадаад худалдааны 2015-2017 оны гүйцэтгэл, 2018 оны хандлага /тэрбум ам.доллар/	13
График 4. Гадаад худалдааны тэнцэл, улсаар /сая ам.доллар/.....	14
График 5. Гадаад худалдааны нийт бараа эргэлт /тэрбум ам.доллар/	14
График 6. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/	15
График 7. Гадаад валютын албан нөөц болон Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ	16
График 8. Төлбөрийн тэнцэл, 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.....	17
График 9. Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төгрөг/	18
График 10. Арилжааны банкуудын актив, пассивын бүтэц /тэрбум төгрөг/	18
График 11. Хүнсний боловсруулах салбарын үйлдвэрлэл /тэрбум төгрөг/	19
График 12. Уул уурхайн салбарын экспортын бүтэц	22
График 13. Цахилгаан эрчим хүчиний боловсруулалт, эх үүсвэрийн бүтэц /2017 он, хувиар/	24
График 14. Цахилгаан эрчим хүчиний нийт импорт /сая.кв.цаг/	27
График 15. Авто тээврээр тээсэн ачаа болон зорчигчдийн тоо.....	27
График 16. Төмөр замаар тээсэн ачаа болон зорчигчдийн тоо.....	28
График 17. Агаарын тээврийн ачаа болон зорчигчдийн тоо	29
График 18. Жуулчдын тоон үзүүлэлт /мянган хүн/.....	29
График 19. Ядуурлын хамралтын хүрээ.....	32
График 20. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын тоо.....	37
График 21. Эх, нялхас, 5 хүртэл насын хүүхдийн эндэгдэл	40
График 22. Хүн амын өвчлөлийн шалтгаан.....	43
График 23. Халдварт өвчнөөр өвчлөгчид.....	44
График 24. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан	44
График 25. Эдийн засгийн өсөлт болон нэрлэсэн ДНБ-ий хэмжээ.....	45
	63

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Экспортын голлох бүтээгдэхүүн, эхний 3 сар /сая ам.доллар/.....	15
Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд.....	20
Хүснэгт 3. Монгол Улсын малын тоо /мянган толгой/	20
Хүснэгт 4. Хураан авсан ургацын хэмжээ /мянган тонн/	21
Хүснэгт 5. Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	23
Хүснэгт 6. Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	24
Хүснэгт 7. Цахилгаан, дулаан үйлдвэрлэл.....	26
Хүснэгт 8. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ /тэрбум төгрөг/	30
Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага	39
Хүснэгт 10. Нийгмийн халамж болон нийтлэг мөнгөн тусlamжийн зарцуулалт (тэрбум төгрөг)	39
Хүснэгт 11. Ерөнхий боловсролын сургууль болон суралцагчийн тоо.....	41
Хүснэгт 12. Улсын тусгай хамгаалалттай нутгийн ангилал /тоо, талбайн хэмжээ/..	47
Хүснэгт 13. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто зам /км/	69
Хүснэгт 14. CGE загварын үр дүн	79
Хүснэгт 15. Дэлхийн эдийн засгийн өсөлт	80
Хүснэгт 16. Цэвэршүүлсэн зэсийн эрэлт, нийлүүлэлт /мянган тонн/	82
Хүснэгт 17. Дэлхийн зэсийн хэрэглээ /мянган тонн/	82
Хүснэгт 18. Дэлхийн зэсийн нийлүүлэлт /мянган тонн/	82
Хүснэгт 19. Алтны эрэлт, нийлүүлэлт /мянган тонн/.....	83
Хүснэгт 20. Нүүрсний эрэлт, нийлүүлэлт /мянган тонн/	83
Хүснэгт 21. Нүүрсний хэрэглээ /сая тонн/.....	83
Хүснэгт 22. Газрын тосны хэрэглээ /сая баррель, өдөр/	84
Хүснэгт 23. Газрын тосны үйлдвэрлэл /сая баррель, өдөр/	84
Хүснэгт 24. Газрын тосны эрэлт, нийлүүлэлт /сая баррель, өдөр/.....	85
Хүснэгт 25. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	86

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд Үндсэн чиглэлийн биелэлтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн, үнэлгээ хийв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 118 арга хэмжээнд давхардсан тоогоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаас 80.5 хувь буюу 95 арга хэмжээ, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 95.7 хувь буюу 113 арга хэмжээ, бусад бодлогын баримт бичгээс 8.5 хувь буюу 10 арга хэмжээ тусгагдсан.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийн 5 бодлого, 17 зорилт, 118 арга хэмжээний биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 79.3 хувьтай гарлаа.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгасан 5 бүлэг, 17 зорилтын 118 бодлогын арга хэмжээг нийтдээ 5.4 их наяд төгрөгийн санхүүжилтээр, үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 353.9 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 825.2 тэрбум төгрөг, төр хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 4.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээс 104.0 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн нийт 118 арга хэмжээнээс:

- 53 арга хэмжээ 100 хувь буюу бүрэн биелж,
- 50 арга хэмжээ 70 хувь,
- 14 арга хэмжээ 40 хувь,
- 1 арга хэмжээ 0 хувь буюу биелээгүй байна.

оOо

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг боловсрууллаа.

Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д тусгагдсан зорилт, арга хэмжээ болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, яамд, агентлагаас ирүүлсэн саналд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулсан болно.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл нь Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт, 123 бодлогын арга хэмжээг тусгаснаас гадна зорилт, арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг мөн тусгасан.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд 2019 онд татварын орчныг шинэчлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах; төсөв, мөнгөний бодлогыг хослуулах замаар инфляцийг зорилтолт түвшинд байлгах; ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах; нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшнээс бууруулах замаар дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг болгох нөхцөлийг бүрдүүлэх; эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зээрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимиийг нэмэгдүүлэх; хөнгөн хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйг ахуйн чанарыг сайжруулах; геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх; эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх; бодит салбарын өсөлтийг дэмжих, зам, тээврийн бодлого хэрэгжүүлж, логистикийн сүлжээг өргөжүүлэх чиглэлээр тодорхой арга

хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд эдгээр салбаруудын өсөлтийн нөлөөгөөр ДНБ-ий бодит өсөлт хангагдах боломж бурдэнэ.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах; агаар орчны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийн хамгаалалт зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх; гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүний чадавхийг сайжруулж, гамшгийн үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг тусгасан.

Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын хүрээнд боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх; соёл урлагын салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлж, нийтийн биеийн тамир, зохистой хөдөлгөөнөөр хичээллэсэн иргэдийг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулах; эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх; Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх; төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх; хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэх чиглэлээр зорилт, арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээнд эрх зүйн салбарын шинэчлэлийг үргэлжлүүлж, төрийн албаны тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулах; төрийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, стандарт хэмжил зүйн байгууллагын олон улсын итгэмжлэлийн үйл ажиллагааг сайжруулах; хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх; энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний барилгын засвар төслийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой зорилт тавин ажиллана.

Салбарын яамд, агентлагуудаас ирүүлсэн арга хэмжээний саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа бодлогын зорилт, арга хэмжээг улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 20 зорилт 123 арга хэмжээний хүрээнд нийтдээ 8 их наяд 619.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 78.3 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 1 их наяд 800.3 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 5 их наяд 172.8 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 568.3 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.

оОо

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2017 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ, 2018 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

1.1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ

1.1.1. Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засаг 2017 онд 5.1 хувиар өсч, ДНБ-ий хэмжээ 27.1 их наяд төгрөгт хүрлээ.

ОУВС-гийн тайландаа дурдсанаар Дэлхийн эдийн засаг 2017 онд 3.8 хувиар өсч, өмнөх оны түвшингээс 0.6 нэгжээр нэмэгдсэн байна. Дэлхийн эдийн засаг ийнхүү сэргэхэд хөгжингүй орнуудын эдийн засагт гарч байгаа зерэг нааштай өөрчлөлт голлон нөлөөлсөн юм. Энэхүү өсөлтийн үр дүнд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ ханш нэмэгдэж, манай улсын экспортын орлого өмнөх оноос 26 хувиар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 85 хувиар өсөв. Экспортын орлого өсөхөд Засгийн газраас боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, БНХАУ-ын талтай гадаад худалдааг сайжруулах чиглэлээр хийсэн ажлууд үр дүнгээ өгсөн.

Эдгээр зерэг өөрчлөлтийн дүнд нэгдсэн төсвийн алдагдал 1.7 их наяд төгрөг болж, 2016 оныхоос 1.9 их наяд төгрөгөөр буурлаа. Манай улсын экспорт түүхэндээ анх удаа 6.2 тэрбум ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны ашиг 1.9 тэрбум ам.доллар боллоо. Мөн ОУВС, АХБ, ДБ, Жайка зэрэг олон улсын байгууллага, гадаад түншүүдийн санхүүгийн дэмжлэгийн нөлөөгөөр Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2017 оны эцэст 3.0 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан жил байлаа. Монгол Улсын валютын нөөц нэмэгдсэн нь төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах боломжийг бүрдүүлж, 2016 оны эцэст 1 ам.доллар 2489.5 төгрөгтэй тэнцэж байсан ам.долларын ханш 2017 оны эцэст 2427.1 төгрөг болж тогтворжив.

Үндсэн хөрөнгийн хуримтлал 2017 онд 33 хувиар өсч, барилга угсралт бүтээн байгуулалтын ажлыг дэмжсэн. Үндсэн хөрөнгийн хуримтлал буюу хөрөнгө оруулалт нэмэгдэхэд Оюу-Толгой төслийн 2 дахь үе шатны далд уурхайн бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө оруулалт 2017 онд 2.6 дахин өссөн нь голлон нөлөөлсөн юм. Тухайлбал, 2016 онд 300 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалтыг зарцуулж байсан бол 2017 онд 800 гаруй сая доллар ам.долларыг оруулсан байна. Түүнчлэн, уул уурхайн компаниудын ашигт ажиллагаа сайжирч үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэчлэх чиглэлээр хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн байна. Экспортын орлогын өсөлт нийт эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг дэмжиж, арилжааны банкуудын зээл олголтыг урамшуулсан. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлт 2017 онд 30 хувиар, арилжааны банкны зээлийн өрийн үлдэгдэл 10 орчим хувиар өссөн байна. Эдгээр хөрөнгө оруулалт нь импортыг урамшуулж, 2017 онд 30 орчим хувиар өсгөсөн байна. Харин барилгын салбар 2016 онд 6.3 хувиар унаж байсан бол уналтын хурдац саарч, 2017 онд 0.8 хувиар буурсан байна.

Нүүрс, төмрийн хүдэр, алт зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдсэн ч Оюу-Толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж

өмнөх оноос 2.6 дахин буурч, 3.6 тонн-д хүрсэнээр уул уурхайн салбар бодитоор 7 хувиар унасан байна. Баяжуулсан нүүрсний хэмжээ нэмэгдэж, махны экспорт өсч, эдийн засгийн идэвхжлийн улмаас бараа, бүтээгдэхүүний эрэлт өсч байгаатай уялдан боловсруулах аж үйлдвэрийн салбар 22.8 хувиар өслөө.

Уул уурхайн экспортын өсөлт нь худалдаа болон тээврийн салбарыг дэмжиж, тус салбарууд 10-17 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны зуны хуурайшилт, халууны улмаас газар тариалангийн салбарын үйлдвэрлэл 30 орчим хувиар унасны улмаас хөдөө аж ахуйн салбар нийт дүнгээр 2.3 хувиар өссөн.

2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Эдийн засгийн өсөлт 2017 онд өмнөх оны түвшингээс огцом нэмэгдсэн бол 2018 онд тогтвортожиж, 5 хувьд байхаар байна. Дэлхийн санхүүгийн нөхцөл байдал сайжирч, хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна. АНУ-ын Засаг, захиргаанаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бууруулснаар тус улсын эдийн засгийн өсөлтийг урамшуулах, худалдааны гол түнш орнуудын эдийн засагт зөргээр нөлөөлөх төлөвтэй байна. ОУВС-гийн төсөөллөөр 2018 онд дэлхийн эдийн засаг 3.9 хувиар өсч, 2017 оны түвшингээс 0.1 нэгжээр хурдсахаар байна. Харин АНУ-ын засаг, захиргаанаас ган болон хөнгөн цагааны импортын тарифыг нэмэхээр зарласан нь төмрийн хүдрийн үнэ болон коксжих нүүрсний үнийн цаашдын хандлагад тодорхой бус байдал үүсгэж байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэж байгаагаас түүхий эдийн үнэ ханш 2018 оны эхний хагаст бага зэргийн өсөлттэй байх төлөвтэй ч харин сүүлийн хагаст буурч болзошгүй юм.

Түүнчлэн, Оюу-Толгойн зэсийн баяжмал дахь алтын агууламж 2017 оноос нэмэгдэхээр байна. Ингэснээр уул уурхайн салбарын зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртөг 2017 оноос нэг хувиар өсөхөөр байна.

Эдийн засаг идэвхижиж, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа сайжирч, зээлжих зэрэглэл нэмэгдэж байгаагийн хэрээр хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, хөрөнгө оруулалтын хэмжээ 2018 онд 20 хувиар өсөхөөр байна. Энэхүү өсөлтөд Оюу-Толгойн хөрөнгө оруулалтын хэмжээ 1.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 30 орчим хувиар өсөх нь мөн нөлөөлөхөөр байгаа юм. Ингэснээр барилгын салбар 2018 онд 5.6 хувиар өсөх урьдчилсан төсөөлөл байна.

1.1.2. Хэрэглээ, хуримтлал

ДНБ-д эзлэх эцсийн хэрэглээ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 65.7 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 37.9 хувь, цэвэр экспорт -3.6 хувьтай байна. ДНБ-д эзлэх хэрэглээний хувь өмнөх онтой харьцуулахад 1.5 нэгжээр буурсан бол харин хөрөнгийн нийт хуримтлалын хувь 8.7 нэгжээр өссөн байна.

Гадаад зах зээл дэх голлох түүхий эдийн үнэ буурч, эдийн засгийн идэвхжил суларч, томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт удааширсантай холбоотойгоор хөрөнгийн дотогшлох урсгал саарч, ДНБ-д эзлэх нийт хуримтлалын хэмжээ 2015 онд 2010 оноос хойших хамгийн доод хэмжээнд буюу 25.6 хувьд хүрч буурсан байна. Харин 2016 оны сүүлийн хагасаас гадаад зах зээлийн нөхцөл байдал сайжирч, экспортын голлох түүхий эдийн үнэ өссөнтэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт сэргэж, улмаар ДНБ-д эзлэх

хөрөнгийн нийт хуримтлалын хэмжээ 2016 онд 29.3 хувь болж нэмэгдсэн юм. Эдийн засгийн идэвхжил сайжирч хөрөнгө оруулалт цаашид эрчимтэй өссөнөөр ДНБ-д эзлэх хөрөнгийн хуримтлал 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 37.9 хувьд хүрч 2015 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт болоод байна.

ДНБ-д эзлэх эцсийн хэрэглээний хувь 2016 онд огцом буурч байсан бол 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 65.7 хувь болж бууралтын хурд саарсан байна. Энэ нь цэвэр экспортын ДНБ-д эзлэх хувь огцом буурсан, өрхийн хэрэглээ өмнөх оноос 4.3 хувиар өссөнтэй холбоотой юм. Цаашид эдийн засгийн идэвхжлийг хадгалах, өсөлтийг тогтворжуулах бодлогын хүрээнд Засгийн газраас ажлын байр олноор бий болгох хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг эрчимжүүлэх замаар иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.1.3. Инфляци

Улсын инфляцийн түвшин 2015 онд 1.9 хувь, 2016 онд 1.1 хувь байсан бол 2017 эдийн засгийн идэвхижилтэй уялдаж 6.4 хувь боллоо. Инфляцийн түвшин өсөхөд эдийн засаг идэвхжиж дотоодын эрэлт өссөн, хэрэглээний үнийн индексийн сагс, жин өөрчлөгдсөн, зарим төрлийн барааны татварын хувь, хэмжээ өссөн; цаг агаар нөхцөл байдалтай холбоотойгоор ургац хураалт буурсан, өмнөх онд дифляцитай байсан нь суурь үеийн нөлөө зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Тухайлбал, 2017 онд төмс хураалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.3 хувь, хүнсний ногооны ургац хураалт 14.9 хувиар буурсантай холбоотойгоор зах зээлийн нийлүүлэлт буурч үнэ өмнөх оноос өсөхөд хүргэсэн байна.

Улаанбаатар хотын инфляци 2017 онд 7.2 хувь гарсан бөгөөд үүнээс мах, махан бүтээгдэхүүний бүлэг 0.4 нэгж, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний бүлэг 1.8 нэгж, шатахууны бүлэг 0.2 нэгж, шатахуунаас бусад хүнсний бус бүтээгдэхүүн 4.8 нэгжийг тус тус бүрдүүлж байна. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн 2017 оны ерөнхий төлөвийг харахад 8 дугаар сараас эхлэн инфляци өсөх хандлага ажиглагдсан байна.

График 1. Инфляцийн бүтцийн задаргаа




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2018 оны эхний 3 сарын гүйцэтгэл: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын дүнгээр 2018 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны мөн үеэс 6.6 хувийн өсөлттэй гарсан. Тус үзүүлэлт нь 2016 оноос хойшхи мөн үеийн

үзүүлэлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 6.6 хувиар өсөхөд тээврийн бүлгийн үнэ 9.1 хувь, орон сууц, ус цахилгаан, хийн бүлгийн үнэ 13.3 хувь, хүнс бараа, ундаа ус бүлгийн үнэ 5.9 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 5.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн ургац хураалт буурсантай холбоотойгоор нийлүүлэлт буурч хүнсний ногооны үнэ өссөн, сүү, сүүн бүтээгдэхүүний бүлгийн үнэ 8.9 хувиар өссөн нь хүнсний бүлгийн үнийг өсгөхөд хүргэсэн байна.

Мөн нүүрс, түлшний үнэ өмнөх сараас 3.4 хувиар, өнгөрсөн онтой харьцуулах 23.4 орчим хувиар нэмэгдсэн нь тус бүлгийн өсөлтөнд голлох нөлөөг үзүүлсэн байна.

График 2. Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт, оны эхнээс



Эх үүсвэр: УСХ

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр өмнөх сарынхаас 1.2 хувь, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өссөн байна. Инфляцийн 62.9 хувийг дотоодын бараа, үйлчилгээ бурдүүлж байсан бол үлдсэн 37.1 хувийг импортын бараа бурдүүлсэн байна.


2017 оны 3 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 26.4 хувь нь үнийн өсөлттэй, 16.6 хувь нь үнийн бууралттай, 57 хувь нь тогтвортой байлаа.

2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Инфляцийн түвшин 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 8 орчим хувьд хэлбэлзэхээр байгаа нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилттой нийтэй байна.

1.1.4. Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2017 онд 10.5 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспортын хэмжээ 6.2 тэрбум ам.доллар болж, 2016 оноос 26.1 хувиар, импортын хэмжээ 4.3 тэрбум ам.доллар болж, 2016 оноос 29.1 хувиар өссөн байна.

График 3. Гадаад худалдааны 2015-2017 оны гүйцэтгэл, 2018 оны хандлага /тэрбум ам.доллар/




Экспортын өсөлтөд эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлт болон чулуун нүүрсний биет хэмжээний өсөлт голлон нөлөөлсөн байна. Мөн махны экспорт эрс нэмэгдэн 29.3 мянган тоннд хүрч, 2016 оноос 3.2 дахин өсжээ.

Импортын өсөлтөд автобензин, дизелийн түлш, машин, механизм тоноғ төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.

Монгол Улс 2017 онд дэлхийн 163 улстай худалдаа хийснээс 68 улсад бараа, түүхий эд экспортолж, 160 улсаас бүтээгдэхүүн импортолсон байна. Үүнээс БНХАУ, Их Британи улстай хийсэн худалдааны тэнцэл хамгийн өндөр ашигтай байсан бол ОХУ, Япон, АНУ, БНСУ, ХБНГУ-тай хийсэн худалдааны тэнцэл алдагдалтай байлаа.


График 4. Гадаад худалдааны тэнцэл, улсаар /сая ам.доллар/



2018 оны эхний 3 сарын гүйцэтгэл: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 оны 3 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар өссөн бөгөөд гадаад худалдааны тэнцэл 0.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 32.8 хувиар буурсан байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл нийт бараа эргэлтийн 62.8 хувь буюу 1.6 тэрбум ам.долларын худалдааг БНХАУ-тай, 14.5 хувь буюу 0.4 тэрбум ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа 2017 оны мөн үеэс 15.0 хувиар, ОХУ-тай хийсэн худалдаа 57.1 хувиар тус тус өссөн байна.

График 5. Гадаад худалдааны нийт бараа эргэлт /тэрбум ам.доллар/



Эх үүсвэр: YCX

Экспортоор 1.5 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14.0 хувиар өссөн байна. Экспортын өсөлтөд эрдэс, түүхий эдийн үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Экспортын голлох бүтээгдэхүүн, эхний 3 сар /сая ам.доллар/

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2017.03	2018.03*	Өсөлтийн хувь
Уул уурхайн голлох бүтээгдэхүүн		1,170.9	1,321.6	12.9%
Зэсийн баяжмал		385.1	462.5	20.1%
Тоо хэмжээ	мян.тн	370.2	337.7	-8.8%
Нэгж үнэ	\$/тн	1,040.2	1,369.7	31.7%
Чулуун нүүрс		538.5	509.6	-5.4%
Тоо хэмжээ	сая тн	8.0	6.6	-17.5%
Нэгж үнэ	\$/тн	67.2	77.1	14.7%
Боловсруулаагүй алт		43.7	124.3	184.4%
Тоо хэмжээ	тн	1.1	2.9	165.4%
Нэгж үнэ	\$/тн	39.3	42.1	7.2%
Нэгж үнэ	\$/унц	1,264.5	1,355.2	7.2%
Боловсруулаагүй нефть		93.1	101.0	8.5%
Тоо хэмжээ	мян.бар	1,839.2	1,631.2	-11.3%
Нэгж үнэ	\$/бар	50.6	61.9	22.3%
Төмрийн худэр		70.1	63.9	-8.9%
Тоо хэмжээ	мян.тн	1,106.7	1,440.9	30.2%
Нэгж үнэ	\$/тн	63.4	44.4	-30.0%
Цайрын баяжмал		40.3	60.2	49.3%
Тоо хэмжээ	мян.тн	27.4	32.9	20.0%
Нэгж үнэ	\$/тн	1,470.7	1,829.7	24.4%
Бусад	НИЙТ	129.0	160.8	24.6%
		1,299.9	1,482.4	14.0%

Эх үүсвэр: YCX

Импортоор 1.1 тэрбум ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 45.6 хувиар өсжээ. Импортын өсөлтөд мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл, дизелийн түлш, машин, тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.

2018 оны хүлээгдэж буй гүйцэтэл: Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 11.0 тэрбум ам.доллар, гадаад худалдааны тэнцэл 1.6 тэрбум ам.долларын ашигтай гaraхаар байна.

Оюу-Толгойн баяжмалын хэмжээ болон баяжмал дахь зэсийн агууламж буурах хэдий ч, алтны агууламж өсөхөөр байна. Үүнээс гадна уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ тогтвортой байх хандлагатай байгаагаас экспортын хэмжээ 1.2 хувиар нэмэгдэж, 6.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шинжээчид дийлэнх эрдэс бүтээгдэхүүний үнэ 2018 онд тогтвортой байхаар таамаглаж байна.

ДНБ-ий өсөлт, экспортын хэмжээ тогтвортой нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил сайжрах хандлагатай байгаагаас шалтгаалж хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизмын импортын хэмжээ өсөхөөр байна. Иймээс 2018 онд импорт 8.4 хувиар өсөж, 4.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

1.1.5. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос нэмэгдэж, 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Дансуудаар авч үзвэл, урсгал данс 984.4 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оноос алдагдал 41 хувиар өссөн бол хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оноос 1.8 дахин өсч 2.5 тэрбум ам.долларт хүрэв.

График 6. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/



Эх үүсвэр: Монголбанк


2014 оноос гадаад худалдааны тэнцэл ашигтай гарах болсонтой холбоотойгоор төлбөрийн тэнцлийн алдагдал тогтмол буурч ирсэн, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 4 дүгээр сард 500.0 сая ам.долларын бонд

гаргасан, Кредит Свисс банкнаас 250.0 сая ам.долларын арилжааны зээл авсан нь хөрөнгийн дотогшлох ургалыг нэмэгдүүлснээр 2016 онд төлбөрийн тэнцэл 18.2 сая ам.долларын алдагдалтай гарсан билээ. Харин 2017 онд дахин ашигтай гарч эхэллээ.

Ургал тэнцлийн алдагдал нэмэгдэхэд анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 57 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин экспорт /ф.о.б/ 21 хувиар, импорт /ф.о.б/ 26 хувиар өссөний улмаас барааны дэд дансны ашиг 10 хувийн өсөлттэй байв. Үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 10 хувиар буурсан ба үүнд, импорт өссөнтэй холбогдуулан тээврийн зардал өмнөх оны мөн үеэс 47 хувиар нэмэгдсэн ч уул уурхайн салбарын ачаа тээвэр өсөлттэй гарснаар ачаа тээврийн орлогыг 61 хувиар нэмэгдүүлсэн байна.

Гадаад валютын албан нөөц 2017 оны 12 дугаар сарын байдлаар 3,008.1 сая ам.долларт хүрсэн нь импортын 8.3 сарын хэрэгцээг хангахаар түвшинд байв.

График 7. Гадаад валютын албан нөөц болон Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



Эх үүсвэр: Монголбанк


Гадаад валютын албан нөөцийг бүрдүүлэгч нэг чухал үзүүлэлт болох Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2017 онд 20.0 тоннд хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 1.7 тонн буюу 9.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

2018 оны эхний 2 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэл: 2018 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 56 хувиар буурч, 110.7 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Дансуудаар авч үзвэл, ургал данс 382.8 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдсэн бол хөрөнгө ба санхүүгийн данс 222.7 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 7.4 дахин өссөн байна.

Гадаад валютын албан нөөц 2018 оны 2 дугаар сарын байдлаар 2963.3 сая ам.долларт хүрсэн нь импортын 7.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл: Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2018 онд 709.0 орчим сая ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

График 8. Төлбөрийн тэнцэл, 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл



1.1.6. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2017 оны гүйцэтгэлээр өмнөх онтой харьцуулахад 30.5 хувиар өсөж 15.9 их наяд төгрөгт хүрэв. Үүнд, гадаад валютын харилцах 31.5 хувь, төгрөгийн харилцах 41.4 хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 8.7 хувь, төгрөгийн хадгаламж 48.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Монголбанкнаас бодлогын хүүг 2016 онд төгрөгийн активын өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор 2016 оны 8 дугаар сард 4.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 15 хувьд хүргэж байсан нь үр дүнгээ өгч төгрөгийн ханш тогтвожиж байсан бол 2017 онд 4, 12 дугаар сард 2 нэгж, 1 нэгж хувиар тус тус бууруулсан нь хөрөнгө оруулалт, бодит секторын идэвхжилд дэмжлэг үзүүлсэн байна.

График 9. Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Монголбанк

2017 оны эцэст арилжааны банкуудын чанаргүй зээлийн хэмжээ 1148.5 тэрбум төгрөгт хүрч, үүнээс 20.8 хувийг уул уурхай, олборлох салбар, 13.3 хувийг


бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбар, 11.0 хувийг барилгын салбар, 20.6 хувийг боловсруулах салбар, үлдсэн 34.3 хувийг бусад салбарт тус тус олгосон зээл эзэлж байна.

2018 оны эхний 3 сарын гүйцэтгэл: 2018 оны 3 дугаар сарын байдлаар нийт мөнгөний нийлүүлэлт 16.1 их наяд төгрөг болж, өмнөх жилээс 31.1 хувь, өмнөх сараас 1.0 хувиар тус тус өссөн байна. Үүнд, төгрөгийн хадгаламж 37.0 хувь, төгрөгийн харилцах 40.0 хувь, валютын харилцах 45.5 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлөв. 2018 оны 3 дугаар сарын байдлаар нийт мөнгөний нийлүүлэлтийн 55.1 хувийг төгрөгийн хадгаламж, 15.6 хувийг гадаад валютын хадгаламж, 13.7 хувийг төгрөгийн харилцах, 12.0 хувийг гадаад валютын харилцах, үлдсэн 3.6 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө эзэлж байна.

1.1.7. Санхүүгийн зах зээл

Банкны салбарт 2017 оны эцсийн байдлаар нийт 14 банк 1770 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт харилцагчдын тоо давхардсан дүнгээр 8.9 сая, зээлдэгчдийн тоо 880 мянгад хүрчээ.

График 10. Арилжааны банкуудын актив, пассивын бүтэц /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Монголбанк

Арилжааны банкуудын активын хэмжээ 28.8 их наяд төгрөгт хүрч, 2016 оноос 13.6 хувиар өссөн байна.

Арилжааны банкуудын нийт пассивын хэмжээ 25.6 их наяд төгрөгт хүрч, 2016 оноос 3.2 их наяд төгрөг буюу 14.4 хувиар өссөн байна. Нийт пассивын дийлэнх хувийг бүрдүүлэгч хадгаламж, харилцах, Засгийн газрын хадгаламж болон бусад пассив өмнөх оноосоо өссөн бол гадаад пассив 549.9 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар буурсан байна.

Ипотекийн зээлдэгчдийн тоо 2017 оны 12 дугаар сарын байдлаар 93.1 мянгад хүрч, зээлийн нийт үлдэгдэл 4,253.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий/2017 оны урьдчилсан гүйцэтгэл/ 15.7 хувьд хүрээд байна.

1.1.8. Ажилгүйдэл

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргаж буй Ажиллах хүчний 2017 оны 4 дүгээр улирлын түүвэр судалгааны дунгээр 15 ба түүнээс дээш насны 2189.9 мянган хүн байна. 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 62.4 хувьтай, ажилгүйдлийн түвшин 7.3 хувьтай байв.

Ажиллах хүчний түүвэр судалгааны 2017 оны 4 дүгээр улирлын дунгээр эдийн засгийн идэвхтэй хүн ам 1367.2 мянга болж, өмнөх 2016 оны мөн үеэс 10.3 хувиар, ажиллагчдын тоо 11.8 хувиар өссөн бол ажилгүйчүүдийн тоо 6.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2014.IV	2015.IV	2016.IV	2017.IV
15-аас дээш насны хүн ам, мянган хүн	1870.2	1925.4	2053.9	2189,9
Эдийн засгийн идэвхтэй хүн ам,	1127.7	1163.9	1239.8	1367.2
мянган хүн				
Ажиллагчид, мянган хүн	1040.7	1067.6	1132.8	1266.9
ажилгүй иргэд, мянган хүн	87.2	96.3	107.0	100.3
Эдийн засгийн идэвхгүй хүн ам,	742.5	761.5	814.1	822.7
мянган хүн				
Ажиллах хүчний оролцооны түвшин,	60.3	60.5	60.4	62.4
хувиар				
Ажил эрхлэлтийн түвшин, хувиар	92.3	91.7	91.4	92.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар	55.6	55.4	57.5	57.9
Ажилгүйдлийн түвшин, хувиар	7.7	8.3	8.6	7.3
Ажиллагчид, мянган хүн				
Хөдөө аж ахуй, мянган хүн	230	234	218	233
Үйлдвэрлэл, мянган хүн	570	590	581	654
Үйлчилгээ, мянган хүн	311	328	348	380

Эх үүсвэр: УСХ

1.2. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ

1.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Мал аж ахуй. Мал тооллогын урьдчилсан дунгээр 2017 оны жилийн эцэст малын тоо 66.2 сая толгойд хүрч, өмнөх оноос 7.6 хувь буюу 4.6 сая толгой малаар өссөн байна. Үүнээс адuu 8.3 хувь буюу 304.5 мянган толгойгоор, үхэр 7.5 хувь буюу 307.9 мянган толгойгоор, тэмээ 8.1 хувь буюу 32.8 мянган толгойгоор, хонь 8.0 хувь буюу 2,254.6 мянган толгойгоор, ямаа 6.9 хувь буюу 1,773.9 мянган толгойгоор тус тус өссөн байна. Нийт мал сургийн 45.4 хувь нь хонь, 41.3 хувь нь ямаа, 6.6 хувь нь үхэр, 6.0 хувь нь адuu, 0.7 хувь нь тэмээ байна.

2017 оны эцэст нийтдээ 888.0 мянган том мал зүй бусаар хорогдсон байна.

Малчин өрхийн тоо 169.7 мянга болж өмнөх оноос 5.4 хувь буюу 9.1 мянгаар өссөн байна.

Хүснэгт 3. Монгол Улсын малын тоо /мянган толгой/

Малын төрөл	2013	2014	2015	2016	2017*
Тэмээ	321.5	349.3	367.9	401.3	434.1

Адуу	2,618.5	2,995.8	3,294.6	3,634.9	3,939.4
Үхэр	2,908.5	3,413.9	3,779.5	4,080.3	4,388.2
Хонь	20,060.2	23,214.8	24,933.4	27,853.4	30,108.0
Ямаа	19,218.5	22,008.9	23,582.5	25,572.2	27,346.1
Бүгд	45,127.2	51,982.6	55,957.9	61,542.0	66,215.8

Эх үүсвэр: УСХ

Мал аж ахуйн салбараас жилд дунджаар хонини ноос 27.4 мянган тонн, ямааны ноолуур 9.4 мянган тонн, бодын хөөвөр 1.3 мянган тонн, тэмээний ноос 1.7 мянган тонн, 891.5 сая литр сүү, нядалгааны жингээр 400.0 мянган тонн мах, 15.0 сая ширхэг арьс, шир үйлдвэрлэсэн.

Газар тариалан. Улсын хэмжээнд 2017 онд нийт 524.3 мянган га талбайд тариалалт хийснээс 393.6 мянган га-д үр тариа, 15.1 мянган га-д төмс, 8.4 мянган га-д хүнсний ногоо, 26.2 мянган га-д тэжээлийн ургамал тариалсан нь өмнөх оноос нийт тариалсан талбай 3.8 хувь буюу 19.0 мянган га-гаар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2017 онд тариалалтын талбай өссөн боловч хураан авсан ургацын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, үр тарианы ургац 238.1 мянган тонн байгаа нь өмнөх оноос 50.7 хувь буюу 245.4 мянган тонноор, үүнээс буудай нь 50.6 буюу 236.5 мянган тонноор буурсан байна.

Мөн төмс 26.3 хувь буюу 43.5 мянган тонн, хүнсний ногоо 13.1 хувь буюу 12.3 мянган тонн, хадлан 21.0 хувь буюу 267.3 мянган тонн, тэжээлийн ургамал 10.2 хувь буюу 5.5 мянган тонноор тус тус буурсан байна.

Хүснэгт 4. Хураан авсан ургацын хэмжээ /мянган тонн/


Таримлын төрөл	2013	2014	2015	2016	2017*
Үр тариа	388.7	518.7	215.7	483.5	238.1
Үүнээс: буудай	373.3	489.4	203.9	467.1	230.6
Төмс	190.6	164.0	165.2	165.3	121.8
Хүнсний ногоо	102.2	102.2	72.7	94.4	82.1
Тэжээлийн ургамал	43.6	40.3	50.3	53.4	47.9
Тосны ургамал	42.6	51.7	22.4	21.5	12.5

Эх үүсвэр: УСХ

Улсын хэмжээгээр нийт үр тарианы 1,490, төмс, хүнсний ногооны 370 аж ахуй нэгж, 35,000 өрхийн тариалан эрхлэгчид газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Хүнсний үйлдвэрлэл. Хүнсний боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 16 хувь буюу 171.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 11. Хүнсний боловсруулах салбарын үйлдвэрлэл /тэрбум төгрөг/



Салбарын хэмжээнд 2017 оны байдлаар 1,914 хүнсний үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 12.7 мянган хүн ажиллаж байна. Үнээс сүү, сүүн бүтээгдэхүүний 235 үйлдвэр, цех, 72 хөргөлтийн төв улиралын чанартай үйл ажиллагаа явуулж, нийт 1,238 хүн ажиллаж байна. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2016 оны дүнгээр 63.3 сая литр байсан бол 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 81.2 сая литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулсан байна.

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар 942.7 мянган тонн үр тариа тээрэмдэх суурилагдсан хүчин чадал бүхий 63 турилын үйлдвэр, цех байгаагаас 24 турилын үйлдвэр цех тогтмол үйл ажиллагаа явуулан нийт хүчин чадлын 27 хувийг ашиглан нийт 208.7 мянган тонн турил үйлдвэрлэсэн байна.

Хүн амын дотоодын хэрэгцээнд жилд дунджаар 14 сая орчим толгой мал буюу нядалгааны жингээр тооцвол 390 мянган тонн орчим махыг хөдөө аж ахуйн салбараас бэлтгэж байна. Хүнсэнд хэрэглэсэн малын 92 хувийг бог мал, 8 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд 2017 оны эхэнд байсан адууны 13 хувийг, үхрийн 21.3 хувийг, тэмээний 10.4 хувийг, хонины 31.5 хувийг, ямааны 27.7 хувийг хүнсэнд хэрэглэсэн байна. Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн махны 10 орчим хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэдэг бөгөөд 2017 онд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах өмнөх онтой харьцуулахад 2.7 дахин нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2017 онд нийт 29.3 мянган тонн махыг экспортлосон байна. Нийт махны экспортын 89 хувийг зөвхөн адууны мах эзэлж байна. 2017 онд 26.1 мянган тонн адууны мах экспортолсон нь 2016 оноос 3.2 дахин буюу 18.0 мянган тонноор нэмэгдэж, 1 тонн адууны махын дундаж үнэ 5.7 хувиар буурч 1,705 ам.долларт хүрсэн байна. Үхрийн махны экспорт 2016 онд нийт махны экспортод 7.6 хувийг эзлэж байсан бол 2017 онд 2.0 хувьд хүрч буурсан байна.

2017 онд 600 тонн үхрийн мах экспортолж 1.6 сая ам.долларын орлого олсон нь өмнөх оноос 51.8 мянган ам.доллараар их байна. Энэ хугацаанд 1 тонн үхрийн махны экспортын дундаж үнэ 449 ам.доллараар нэмэгдэж, 2,739.0 ам.долларт хүрсэн. 2017 онд 2.6 мянган тонн хонь, ямааны мах экспортлосон нь өмнөх оноос 10.9 дахин өсч 8,267.0 мянган ам.долларын экспортын орлого олсон байна. Хонь, ямааны махны экспортын тонн тутмын дундаж үнэ 3,177.7 ам.долларт хүрч 2016 оны дундаж үнээс 2.1 дахин өссөн байна.

Хөнгөн үйлдвэр. Хөнгөн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.0 их наяд төгрөг, борлуулалт 3.5 их наяд төгрөг болж өмнөх оноос 50 хувиар өссөн байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарт 2017 оны байдлаар 2,000 гаруй аж ахуйн нэгж ноос ноолуур, арьс шир, мод модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, барилгын материал, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, цахилгаан бараа, гоо сайхан, эм, ахуйн химийн болон бэлэг дурсгалын гэсэн 14 чиглэлд 48.8 мянган хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Ноос ноолуур, арьс шир, оёдол, мод модон эдлэл нь нийт хөнгөн үйлдвэрлэлийн 60 хувийг эзэлж байна. Үүнээс ноос, ноолуурын салбар нь хөнгөн үйлдвэрийн салбарын 50 хувийг эзэлж, 2017 оны байдлаар 387.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 70 хувийг нь экспортод гаргасан байна. Угаасан ноос, ноолуурыг Хятад улс руу, самнасан ноолуурыг Итали, Англи, нэхмэл сүлжмэл бэлэн бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Белги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолсон ба нийт ноос, ноолуурын экспортын 80 хувийг угаасан ноолуур эзэлж байна.

Хүснэгт 5. Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017*
1 Самнасан ноолуур	тонн	633.2	754.5	782.1	1108.8
2 Тэмээний ноосон хөнжил	мянган метр	18.5	23.0	12.2	30.2
3 Эсгий	мянган метр	163.1	164	99.9	114.9
4 хивс	мянган метр	743.6	680.2	432.9	473
5 Эсгий гутал	Мянган хос	10.8	0.6	0.5	0.3

Эх үүсвэр: YCX

Монгол Улсын стратегийн түүхий эд болох ноолуурын салбарын хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг дээшлүүлэх, хүчин чадал нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэх, гадаад зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Мод, модон эдлэл үйлдвэрлэлийн салбарт 500 үйлдвэр, аж ахуйн нэгж 5,000 орчим хүнтэй үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны жилийн эцсийн дүнгээр 15.0 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан бөгөөд үүний 31.3 хувь нь модон тавилга, 28.3 хувь нь шахмал хавтан, 17.8 хувь нь барилгын модон хийц, 23.8 хувь нь түлээний мод, 14.9 хувь шахмал түлш байна. Дотоодын мод, модон материал, тавилгын нийт хэрэгцээний 45 хувийг дотоодын үйлдвэрүүд хангаж, 55 хувийг импортоор авч байна.

1.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэр

Уул уурхай. Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 9,386.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 32.8 хувиар өссөн байна. Салбарын өсөлтөд Оюу-Толгойн зэсийн баяжмалаас бусад эрдэс дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин 2013-2015 онуудад уул уурхайн салбарын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байсан Оюу-Толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмалын агууламж 2016 оноос буурч эхэлсэн.

Хүснэгт 6. Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	2013	2014	2015	2016	2017*
Нүүрс /мянган тонн/	29,163.6	24,927.1	24,148.9	35,421.9	47,101.4
Зэсийн баяжмал /металл агуулгаараа мянган тонн/	803.0	1,080.4	1,334.7	1,445.1	1,317.1
Төмрийн хүдрийн баяжмал /мянган тонн/	11,135.9	10,260.5	6,173.4	7,146.1	11,369.7
Газрын тос (мянган баррель)	5,128.9	7,405.3	8,769.3	8,249.8	7,624.1
Цайрын баяжмал /мянган тонн/	104.1	93.2	89.6	100.2	82.7
Алт /кг/	8,904.4	11,503.8	14,556.2	18,435.7	19,846.8


Эх үүсвэр: УСХ

Уул уурхайн салбар 2016 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 20.0 хувийг, нийт экспортын 86.3 хувийг дангаараа бүрдүүлж байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 21.9 хувийг, нийт экспортын 89.2 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Монгол Улсын нийт экспорт 2017 онд өмнөх оноос 1.3 тэрбум ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум ам.доллараар үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн экспортод эзлэх хувь хэмжээг авч үзвэл 42.3 хувийг нүүрс эзэлж байна.

График 12. Уул уурхайн салбарын экспортын бүтэц



Эх үүсвэр: УСХ

Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийг 2016 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. 2017 оны байдлаар БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өндөр гарсантай холбоотойгоор уул

уурхайн салбарын гол түүхий эдүүд болох зэс, төмрийн хүдэр, алт, хөнгөн цагаан зэрэг аж үйлдвэрийн голлох металлуудын үнэ өссөн байна.

Геологи. Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, геологи эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор мэргэжлийн багаар гүйцэтгүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 37.4 хувийг 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн судалгаанд бүрэн хамруулж, 2017 онд 36,000 км² талбайд геологийн 12 төслийг хэрэгжүүлж ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайнуудыг ялган тодорхойлоод байна.

Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулсан геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгай хэмжээнд нэгтгэх ажлыг эхлүүлээд байна.

2017 онд “Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа”-г Монгол Улсын баруун бүсэд хэрэгжүүлж олон тооны орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдийг илрүүлсэн.

Мөн “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын зүүн бүсэд алтны хүдэржилт, хэтийн төлөвийн судалгааг хэрэгжүүлж олон тооны алтны үндсэн болон шороон орд, илрэл, эрдэсжсэн цэгийг илрүүлэн, үнэлгээг хийсэн.

Агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 200,000 км² талбайд гүйцэтгэв. Судалгааны ажлын үр дүнд хар болон өнгөт, үнэт металлын олон тооны дунд ба томоохон хэмжээний ордуудыг илрүүлэх боломжтой геологийн тогтоцуудыг илрүүлээд байна.

Хүнд үйлдвэр. Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Газрын тос боловсруулах үйлдвэр”, “Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр” болон “Хар төмөрлөгийн үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Зэсийн баяжмал боловсруулах үйлвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд “Оюу-Толгой” ХХК-ын удирдлага, Зам тээвэр хөгжлийн яам, “Монголын Төмөр Зам” ТӨХК-тай болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай уулзалт зохион байгуулж “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” барих талбайн байршлыг төмөр зам, эрчим хүчний хангамж болон бусад дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан тодорхойллоо.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэхээр шалгарсан Энэтхэг улсын “Инженерс Индия Лимитед” компани үйлдвэрт ашиглах усны эх үүсвэрийн талбай, бусад дэд бүтэцтэй танилцаж төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн эхлэлийн тайланг ирүүлээд байна.

“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийн эцсийн тайлан, байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2017 онд хүлээн авч төслийн барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах гэрээ хэлэлцээрийг хийх бэлтгэл ажлыг хангав.

Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төслийн хүрээнд “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК евро стандартад

нийцсэн, жилд 20,000 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, давтах аргын технологитой үйлдвэрийг ашиглалтад оруулав. Уг цогцолборын төслийн ТЭЗҮ-ийг 2017 онд хүлээн авсан ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг 2018 оны 1 дүгээр улиралд хүлээн авна.

1.2.3. Эрчим хүч

Эрчим хүч. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 180 дугаар тогтоолоор эрчим хүний салбарын хэмжээнд ТЭЦ-3-ын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх, станцын цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төсөл, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэх, станцын цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төсөл, Багануур-Чойрын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, Багануур дэд станцыг өргөтгөх төсөл, Чойрын дэд станцыг өргөтгөх төсөл, Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Алтай сум хүртэл 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл болон Гурвантэс сумын Нарийнсуухайтын 270 МВт-ын цахилгаан станц барих төслүүдийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхээр ажиллаж байна.

Эрчим хүний салбар 2017-2018 оны өвлийн их ачаалалд батлагдсан горим, төлөвлөгөөний дагуу ажиллаж, системийн нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, 2018 оны нэгдүгээр сарын 25-ны өдрийн өвлийн хамгийн өндөр ачааллыг авч ажилласан ба энэ өдөр нэгдсэн системийн нийт ачаалал 1262 МВт хүрснээс төвийн эрчим хүний системийн оргил ачаалал 1081 МВт-д хүрч ажиллав.

Хүснэгт 7. Цахилгаан, дулаан үйлдвэрлэл

	Нэгж	2013	2014	2015	2016	2017*
Эрчим хүч	сая квт.цаг	4,317.9	4,632.3	4,772.4	4,938.6	5,197.7
Дулааны эрчим хүч	мян.Гкал	8,928.8	9,126.6	9,593.4	10,334.5	10,680.0

Эх үүсвэр: YCX

Монгол улсын хэмжээнд 2017 онд 5,197.7 сая квт.цаг цахилгаан эрчим хүч 10,680.0 мян.Гкал дулааны эрчим хүч тус тус үйлдвэрлэн боловсруулж, өмнөх оноос цахилгаан эрчим хүний боловсруулалт 5.24 хувиар буюу 259.1 сая квт.цагаар, дулааны эрчим хүч боловсруулалт 3.34 хувь буюу 345.5 мянган Гкал-оор тус тус өссөн байна.

График 13. Цахилгаан эрчим хүчний боловсруулалт, эх үүсвэрийн бүтэц /2017 он, хувиар/




Эх үүсвэр: УСХ

Монгол Улсын эрчим хүчний нийт хэрэглээний 75.8 хувийг дулааны цахилгаан станцууд, 3.5 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд, 20.7 хувийг ОХУ, БНХАУ-ын импортын эрчим хүч хангаж байна.

Монгол Улсын эрчим хүчний системд 2017 онд шинээр “Цэцийн салхин станц”, “Моннарангийн нарны станц”, “Эрдэнэт үйлдвэрийн дулааны цахилгаан станц”-үүд тус тус ашиглалтад орж, нийт хүчин чадлыг 123 МВт-аар нэмэгдүүлж, 1,273 МВт-д хүргээд байна.

График 14. Цахилгаан эрчим хүчний нийт импорт /сая.кв.цаг/



Эх үүсвэр: УСХ

Эрчим хүчний салбар 2017 оны эцсийн байдлаар зөвхөн уул уурхайн салбарт ашиглагдах цахилгаан эрчим хүчийг БНХАУ-аас 1,216.3 сая кВт.цагийг импортоор худалдаж авсан нь өмнөх оноос 8.8 хувиар өссөн байна. Цаашид уул уурхайн ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэлт нэмэгдэх хандлагатай байгаагаас үзэхэд эрчим хүчний хэрэглээ мөн адил өсөхөөр байна. Харин оргил ачааллын үед аж ахуй нэгж байгууллагууд болон айл өрхүүдийг тогтвортой цахилгаан эрчим хүчээр хангахын тулд 2017 онд ОХУ-аас 358.0 сая кВт.цагийг импортоор худалдаж авсан нь өмнөх оноос 18.4 хувиар өссөн дүн байна.

1.2.4. Зам, тээвэр

Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээг үзүүлэх эрхэм зорилгын хүрээнд авто зам, авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн салбарыг хөгжүүлж байна.

Бүх төрлийн тээврээр 2017 онд 53.9 сая тонн ачаа, давхардсан тоогоор 215.7 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 13.5 сая тонн буюу 33.5 хувиар, зорчигчид 48.3 сая буюу 18.3 хувиар буурсан байна.

Авто зам. Монгол Улс нийт 49,695 км авто замын сүлжээтэйгээс 15,244.5 км нь нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон улсын чанартай авто зам байна. Улсын чанартай авто замын сүлжээнд нийт 4,300 орчим км-ын 3 чиглэл (АН3, АН4, АН32)-ийн олон улсын чанартай авто зам байна.

Авто замын салбарт 2017 онд Улсын төсөв, Хөгжлийн банк, гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар нийт 21 чиглэлийн 1,412.7 км хатуу хучилттай авто зам, 3 байршилд 639.6 урт метр төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга, их засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Авто тээвэр. Авто тээврийн салбар 2017 онд 31.2 сая тонн ачаа, давхардсан тоогоор 212.2 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 10.8 сая тонн буюу 5.3 хувиар өсч, харин зорчигчид 48.5 сая хүн буюу 18.6 хувиар буурсан байна. Автотээврийн орлого 506.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 8.5 хувь буюу 39.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 15. Авто тээврээр тээсэн ачаа болон зорчигчдийн тоо



Эх үүсвэр: УСХ

Төмөр зам. Монгол Улс нийт 1912 км төмөр замтай бөгөөд Булган, Орхон, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Дорнод аймгуудын нутгаар дамжин өнгөрч байна.

Төмөр замын тээврээр 2017 онд 22.7 сая тонн ачаа, давхардсан тоогоор 2.6 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхос тээсэн ачаа 2.7 сая тонн буюу 13.6 хувиар өсч, зорчигчид 21.9 мянган хүн буюу 0.8 хувиар буурсан байна.

График 16. Төмөр замаар тээсэн ачаа болон зорчигчдийн тоо



Эх үүсвэр: YCX

Төмөр замын тээврийн салбарын орлого 2017 онд 529.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 92.3 тэрбум төгрөг буюу 21.1 хувиар өссөн.

Иргэний нисэх, агаарын тээвэр. Агаарын тээврээр 2017 онд 3.1 мянган тонн ачаа, давхардсан тоогоор 0.8 сая зорчигч тээвэрлэж, өмнөх оноос тээсэн ачаа 0.3 хувиар буурч, зорчигчийн тоо 25 хувиар өссөн байна.

График 17. Агаарын тээврийн ачаа болон зорчигчдийн тоо



Эх үүсвэр: YCX

Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын агаарын зайд үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий зургаан замыг шинэчлэн тогтоож 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс ашиглаж эхэлсэн. Мөн агаарын навигацийн хураамжийг тогтоох шинэчилсэн аргачлалыг боловсруулан, 2017 оны 7 дугаар сараас эхлэн мөрдөж байна. Ингэснээр навигацийн үйлчилгээний орлого 2017 оны жилийн эцсийн байдлаар 242.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 27.9 хувиар өссөн байна.

Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 110,953-т хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 11743 нислэг буюу 12 хувиар өссөн байна.

Далайн тээвэр. Далайн боомт ашиглалтын хүрээнд БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Итали Улсын худалдааны далайн боомтуудыг Монгол Улсын гадаад худалдаанд ашиглах, өөрийн улсын бүтээгдэхүүнийг гуравдагч оронд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Итали Улсын Генуя боомтыг таатай нөхцөлөөр ашиглах талаар харилцан тохиролцоонд хүрээд байна.

БНХАУ-ын Тяньжин дэх Дунзяны эдийн засгийн чөлөөт бүсийн 10 га газарт тээвэр, логистик, үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолбор барьж ашиглах талаар Хятадын талтай тохиролцсон бөгөөд одоогоор төслийг “Монголын төмөр зам” ТӨХК 49 хувь, Хятадын тал 51 хувийн оролцоотойгоор хамтран хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

1.2.5. Барилга, хот байгуулалт

Барилга угсралт, их засварын ажил 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.5 хувь буюу 45.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 94.1 хувийг дотоодын байгууллага, 5.9 хувийг гадаадын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажлын 39.4 хувийг орон сууцны барилга, 35.5 хувийг орон сууцны бус барилга, 22.4 хувийг инженерийн барилга, байгууламж, 2.7 хувийг их засварын ажил эзэлж байна.

Хүснэгт 8. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ /тэрбум төгрөг/

Барилга	2013	2014	2015	2016	2017*
Барилга угсралт, их засварын ажил, бүгд дотоодын байгууллага	3,771.8	2,750.8	2,837.8	3,084.8	3,130.7
Төрийн өмчийн байгууллага	3,513.6	2,559.6	2,628.9	2,871.3	2,944.6
Хувийн байгууллага	261.8	63.2	46.0	30.5	55.1
Гадаадтай хамтарсан байгууллага	3,200.9	2,454.7	2,567.1	2,827.4	2,812.1
Гадаадын байгууллага	50.8	41.7	15.9	13.4	77.3
	258.2	191.2	208.8	213.5	186.1

Эх үүсвэр: УСХ

Орон сууц. Монгол Улсын нийт хүн амын 30.0 хувь нь инженерийн хангамжтай орон сууцанд, үлдсэн хэсэг нь инженерийн бус хангамжтай гэр хорооллын сууц, уламжлалт монгол гэрт амьдарч байна. Улсын хэмжээнд 2013 онд 18,012 айлын, 2014 онд 22,546 айлын, 2015 онд 26,340 айлын, 2016 онд 15,923 айлын, 2017 онд 11,023 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон байна.

Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолоор “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ыг баталж, мөн оны 6 дугаар сараас жилийн 8 хувийн хүүтэй, орон сууцны зээлийг орон сууц худалдан авах иргэдэд олгож эхэлсэн бөгөөд 2017 оны байдлаар ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо 93,147-д хурсний 73 хувь нь Улаанбаатар хотод, 27 хувь нь орон нутагт байна. Зээлийн нийт үлдэгдэл 4,253.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 28 дугаар тушаалаар батлагдсан “Иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам”, ТОСК ТӨААТУГ-ын ерөнхий захирлын 2016 оны А/21 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн

түрээсийн орон сууцад иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцад хамруулах ажлыг зохион байгуулах журам"-ын дагуу Улаанбаатар хотод 4,150, орон нутагт 2,222 иргэнд шаардлагатай мэдээллийг өгч, материалыг хүлээн авсан. Үүнээс Улаанбаатар хотод шаардлага хангасан нийт 2,376 иргэн, орон нутагт шаардлага хангасан 929 иргэн, нийт 3,315 иргэн, айл өрхийг 2017 онд түрээсийн орон сууцанд хамруулсан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 25 дугаар тушаалаар Түрээсийн орон сууцны 1 м.кв талбайн хэмжээг нийслэлд 6,000 төгрөг, орон нутагт 4,500 төгрөг байхаар тогтоосон бөгөөд мөн сайдын 26 дугаар тушаалаар зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журмыг батлуулсан.

Хот байгуулалт. “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Булган, Өвөрхангай, Завхан, Дорнод, Хэнтий, Ховд, Баян-Өлгий, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгийн төвүүдэд нийгмийн дэд бүтцийн хамт баригдах орон сууцны хорооллыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулаад байна.

Монгол Улсын хилээр дамжин гарах ачаа эргэлт нэмэгдсэнтэй холбогдуулан хилийн боомтын шинэчлэлийн хүрээнд Ханги, Бичигт, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Гашуунсуухайт, Шивээхүрэн, Боршоо хилийн боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай 30 ширхэг станцыг аймгийн төв болон сум, суурин газруудад байгуулж улсын хэмжээнд нийтдээ 38 станц ажиллаж байна.

1.2.6. Аялал жуулчлал

Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 471.1 мянгад хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 14.2 хувиар буюу 66.9 мянгаар өсч, аялал жуулчлалын салбарын орлого 400 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдыг тэргүүлэх 10 улсаар нь авч үзвэл нийт жуулчдын 38 хувийг Хятад, 18 хувийг Орос, 12 хувийг Солонгос, 5 хувийг Япон эзэлж үлдсэн хувийг Америк, Казакстан, Герман, Франц, Их Британи, Австрали зэрэг улсууд бүрдүүлж байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс” үзүүлэлтээр Монгол Улс 141 орноос 99 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна.

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 274 аялал жуулчлалын компани, 473 зочид буудал, 385 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, тус салбараас 54.0 мянган ажлын байрыг бий болгосон нь нийт ажлын байрны 4.8 хувийг бүрдүүлсэн байна.

График 18. Жуулчдын тоон үзүүлэлт /мянган хүн/



Эх үүсвэр: УСХ

Монгол Улсад агаарын тээврийн чиглэлээр МИАТ, ХҮННҮ Эйр, Аэро Монголиа зэрэг гурван үндэсний авиа компаниуд үйл ажиллагаа явуулж, Берлин, Франкфурт, Бээжин, Станбул, Бусан, Сөүл, Москва, Токио, Хонгконг, Эрхүү, Хөх хот, Манжуур, Хайлаар, Бишкеқ, Тианьжин зэрэг нийт 15 чиглэлд тогтмол нислэгтэй бөгөөд Хайнань, Чежү, Бангкок зэрэг чиглэлүүдэд тогтсон хуваарийн дагуу чартер нислэг үйлдэж байна.

1.2.7. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хэмжээнд “Өрх бүрт шуудан” хөтөлбөр (2010-2020), “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” (2017-2025) батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын мэдээлэл харилцаа, холбооны шилэн кабелийн сүлжээний нийт урт 2017 оны жилийн эцсийн байдлаар 36.7 мянган км болж, 21 аймгийн 304 сум шилэн кабельд холбогдсон.

Шуудан, холбооны салбарын орлого 2017 онд 805.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.3 хувь буюу 26.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүрэн утас хэрэглэгчдийн тоо 2017 онд давхардсан дүнгээр 3,680.3 мянгад хүрч, 2016 оноос 9.2 хувь буюу 308.7 мянган хүнээр өссөн байна.

Суурин утасны цэг 2017 онд 312.7 мянган ширхэг болж, 2016 оноос 8.7 хувь буюу 25.0 мянгаар өссөн байна. Кабелийн телевиз хэрэглэгчид 2017 онд 487.2 мянга болж, өмнөх оноос 16.5 хувь буюу 68.8 мянгаар нэмэгдсэн байна. Суурин утасны цэг, кабелийн телевиз хэрэглэгчдийн 2016-2017 оны өсөлтөд гурвалсан үйлчилгээг орон нутагт нэвтрүүлсэнтэй холбоотойгоор хэрэглэгчид болон агаарын олон сувгийн тоон телевизийн дамжуулах үйлчилгээ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиглэлээр судалгаа хийж иргэдэд хамгийн их зардал, чирэгдэл учруулдаг, цахимжуулах шаардлагатай үйлчилгээнүүдийг тодорхойлон эдгээр үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах зорилготойгоор “Төрийн үйлчилгээний нэгдсэн веб порталын модулиуд хөгжүүлэлт” төсөл хэрэгжүүлж төрийн үйлчилгээний цахим систем болох

www.service.gov.mn хуудсаар дамжуулан иргэдэд төрийн 27 үйлчилгээг цахимаар хүргэж байна.

Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, 159 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

1.3. ХҮНИЙ ХӨГЖИЛ

1.3.1. Хүний хөгжил

Манай улсын хүн ам 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,179.8 мянгад хүрч өмнөх оноос 1.9 хувиар өслөө. Сүүлийн арав гаруй жилд Монгол гэр бүлийн хөгжилд шинэ хандлага, тулгамдсан асуудлууд гарч ирсээр байна. Нийгмийн амьдралд гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрагчид нэмэгдсэн, гэр бүлийн харилцаанд чөлөөтэй хандах болсон, гэр бүл цуцлалт болон гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдсэн зэрэг сөрөг үзэгдлүүд байсаар байна.

2016 онд 16,778 хос гэрлэлтээ бүртгүүлж, 4,003 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. 2016 онд гэр бүлээ цуцлуулсан гэр бүлийг гэр бүл байсан хугацаагаар нь судлахад 51.6 хувь нь 10-аас дээш жил, 26.5 хувь нь 7-9 жил, 14.7 хувь нь 4-6 жил, үлдсэн 7,1 хувь нь 3 хүртэл жил ханилж байсан байна. Судалгаагаар эмэгтэйчүүдийн 10.7 хувь, эрэгтэйчүүдийн 9.7 хувь нь гэрлэлтээ батлуулалгүй хамтран амьдарч байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оноос хэрэгжиж байгаа боловч, гэр бүлийн хүчирхийлэл байсаар байна. Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээр 2017 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1,286 бүртгэгдсэн нь өмнөх оноос 11.2 хувь буюу 163 хэрэгээр буурсан байна. Эдгээрээс хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 85.7 хувийг эзэлж байгаа бол хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 12.9 хувьтай байна. Нийт хохирогчдын 92.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүүхдийн хөгжил. Монгол Улсын нийт хүн амын 34.4 хувийг 0-18 хүртэл насынхан эзэлж байна. Нийт хүүхдийн дунд бүтэн өнчин 3,553 хүүхэд, хүүхдийн асрамж, халамжийн төвд 1,045 хүүхэд, хараа хяналтгүй 97 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 10,724 хүүхэд, хурдан морины уралдаанч 10,453 хүүхэд байна. 2017 онд гэмт хэргийн улмаас хохирсон нийт 1,224 хүүхэд, хүүхэд оролцсон гэмт хэрэг 670, гэмт хэргийн улмаас хохирч амь насаа алдсан 121 хүүхэд, бэлгийн хүчирхийллийн хохирогч 135 хүүхэд, хурдан морины уралдааны явцад мориноос унаж хөгжлийн бэрхшээлтэй болсон 3, амь насаа алдсан 2 хүүхэд бүртгэгдсэн байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, хүүхдийн асуудлаарх мэдээллийн сан бий болгох, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажиллах журам, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийг магадлан итгэмжлэхтэй холбоотой 10 дүрэм, журмыг батлан хэрэгжүүлж байна.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”, “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр, “Сургалт, судалгаа, мэдээллийн төв”-ийг, Багахангай дүүрэгт “Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх төв”-ийг тус тус байгуулан ажиллаж байна.

Залуучуудын хөгжил. Манай улсын хувьд залуучуудын тоо харьцангуй өндөр буюу нийт хүн амын 34.6 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 51.5 хувийг 15-34 насны залуучууд эзэлдэг.

Дэлхийн залуучуудын хөгжлийн индекс ба тайлан судалгаанд манай улс залуучуудынхаа хөгжлийн түвшингээрээ 183 ороос 71 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна. Залуучуудын өнөөгийн нөхцөл байдлыг статистик тоон мэдээллээс харвал:

- Нийт өрхийн 29.6 нь, үүний дотор 30-аас доош насны тэргүүнтэй өрхийн 27.0 хувь нь, 30-39 насны тэргүүнтэй өрхийн 36.2 хувь нь ядуу;
- Ажилгүйдлийн түвшин 10 хувь байхад залуучуудын ажилгүйдлийн түвшин 14.4 хувь;
- 2015-2016 оны хичээлийн жилд төгссөн нийт төгсөгчдийн 60.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байна;
- Бэлгийн замаар дамжих халдвартын 14.9 мянган тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 21.5 хувийг эзэлж байгаа ба насны ангилаар авч үзэхэд 11.9 хувь нь 15-19 насны, 29.3 хувь нь 20-24 насны, 24.3 хувь нь 25-29 насны, 14.3 хувь нь 30-34 насны залуучууд байна.

Иймд залуучуудын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлох зорилгоор “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг батлан, 2018 оноос хэрэгжүүлж байна. Хуульд залуучуудын хөгжлийг хувь хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах хөгжих орчин гэсэн 5 үндсэн чиглэлээр дэмжих, салбар дундын зохицуулалтыг хангах чиг үүрэгтэй залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлд залуучуудын оролцоог ханган ажиллах эрх зүйн орчныг бүрдүүллээ. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж байна.

Энэ хүрээнд залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, боловсролын чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, оюутны цагийн ажлын болон залуучуудын сайн дурын ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх ба Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлийг байгуулсан бөгөөд үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, салбар зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тэргүүлэн ажиллаж байна.

Ахмад настан. Монгол улсад 2017 оны байдлаар ахмад настан 270 мянгад хүрч, нийт хүн амд ахмад настан 8 орчим хувийг эзэлж байна.

Ахмад настны эрхийг баталгаажуулах, нийгмийн хамгааллын үйлчилгээний төрөл, тоо, чанарыг дээшлүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2017

оны 01 дугаар сарын 26-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар Ахмад настны тухай хуулийг батлуулан хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. Монгол Улсад 2017 оны байдлаар 103.6 мянга буюу нийт хүн амын 3.3 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 44 хувь нь эмэгтэй, 54 хувийг эрэгтэйчүүд, 2 хувь нь 16-аас доош насны хүүхэд байна. Тэдний 42 хувь нь төрөлхийн, 58 хувь нь олдмол шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн насны 19,974 иргэн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны 3,018 иргэн байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй 73,285 иргэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусlamж, хөнгөлөлт үзүүлэх журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох”, “Хөтөч нохойг сургах, ашиглах журам”-ыг тус тус баталлаа.

Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл, 2017 оны 116 дугаар тогтоолын хүрээнд бүх яам болон зарим агентлагийн дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл ажиллаж байна. Харин аймгуудад Засаг даргын дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл байгуулан ажиллаж байна.

Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Жендер. Монгол Улс жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг 2002 онд батлан хэрэгжүүлж, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд тус тус батлан мөрдөж байна. Жендерийн үндэсний хороог Монгол Улсын Ерөнхий сайд ахалж, хорооны гишүүдийг төр, төрийн бус байгууллагаас тэнцүү тоогоор бүрдүүлэн ажиллаж байна. Түүнчлэн салбар, орон нутагт жендерийн асуудал хариуцсан бүтэц, үндэсний хэмжээний сүлжээ бий болгох зорилгоор яамд, аймаг, нийслэл, дүүрэгт 44 жендерийн салбар зөвлөл, хороодыг байгуулаад байна. Үндэсний хэмжээнд ажиллах анхны жендерийн сургагч багш нарыг бэлтгэж, Жендерийн үндэсний хорооны дэргэд мэргэшсэн жендерийн шинжээчдийн бүлэг, хэвлэл мэдээллийн зөвлөл, жендер консорциумыг ажиллуулж байна.

Олон улсын чиг хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн төрөөс жендерийн талаар баримталж буй бодлого, шийдвэрийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг эрчимжүүлэхийг зорилгоор “Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна.

1.3.2. Хөдөлмөр эрхлэлт

Манай улсад 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 15 ба түүнээс дээш наасны 2,189.9 мянган хүн байгаагаас 62.4 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам, 37.6 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.9 хувьтай, ажилгүйдлийн түвшин 7.3 хувьтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэх, ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, ажил олоход хүндрэлтэй, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар сул байгаа хэсэг бүлгийг дэмжин ажиллах, хөдөлмөрлөх, орлого бий болгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хөшүүргийг бий болгох зорилгоор 2013, 2014 онд тус бүр 8 хөтөлбөр, төсөл, 2015 онд 5 хөтөлбөр, 2016 онд 7 хөтөлбөр, 1 төсөл, 2017 онд 6 хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр тус тус батлуулж хэрэгжүүллээ. Хөтөлбөр, төсөлд 2013-2017 онд нийт 421.3 мянган хүн хамрагдаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 149,229.6 сая төгрөгийг зарцуулж, 308.0 мянган түр болон байнгын ажлын байр бий болсон байна.

2018 онд Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 181 дүгээр конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88 дугаар конвенцуудын зүйл, заалтуудад нийцүүлэх, 2016 онд батлагдсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдуулах, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, иргэдийн орлогыг дээшлүүлэхтэй холбоотой зорилтуудын хэрэгжилтийг хангах, олон улсын чиг хандлагад нийцүүлэх, өөрийн орны онцлог, нөхцөл байдал, өнгөрсөн хугацаанд хуулийн хэрэгжилтийг хангах явцад гарсан хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.8 тэрбум төгрөгийг зарцуулах бөгөөд гарааны бизнес эрхлэхийг дэмжих, санхүүгийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх, аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Мөн залуучуудын гарааны бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр Швейцарийн хөгжлийн агентлагийн төслөөс 2017 онд хэрэгжүүлсэн туршлагыг 2018 онд 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулж байна.

2018 оны төсвийн тухай хуульд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эх үүсвэрийг 22.9 тэрбум төгрөгөөр баталсан. Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл болон зээлийн өмнөх, дараах санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Цалин. Үндэсний статистикийн хорооны тайлан мэдээгээр аж ахуйн нэгж байгуулагад ажиллагчдын сарын дундаж цалин 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 1,038.9 мянган төгрөг байна.

2017 оны 4 дүгээр улирлын байдлаар цалин хөлстэй ажиллагч 613.9 мянган хүн байгаа бөгөөд тэдгээрийн 13.2 хувь нь 300.0 мянган төгрөг хүртэл

цалинтай, 14.0 хувь нь 300.0-500.0 мянган төгрөг, 35.2 хувь нь 500.0-900.0 мянган төгрөг, 19.8 хувь нь 900.0- 1300.0 мянган төгрөг хүртэл, 4.6 хувь нь 1300.0-1500.0 мянган төгрөг хүртэл, 13.2 хувь нь 1500.0 мянгаас дээш төгрөгийн цалинтай байна.


Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт тусгагдсан эмч, багш нарын ажлын ачаалал, мэргэшлийн ур чадвар, ажлын хариуцлага, үр дүнгээс хамаарсан цалин, урамшууллын тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд 2016-2017 онд эрүүл мэндийн бүх шатлалыг хамарсан төв, орон нутгийн эрүүл мэндийн 30 байгууллагын 2,351 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байрны үнэлгээнд хамруулан зохион байгууллаа. Ажлын байрны үнэлгээний үндсэн дээр эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албаны ангилал, зэрэглэлийн төслийг шинэчлэн боловсрууллаа.

Хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сард 240.0 мянган төгрөгөөр тогтоон мөрдөж байгаа бөгөөд 2013 оны түвшнээс 25 хувиар нэмэгдүүлсэн.

1.3.3. Ядуурал

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны судалгааны дүнгээр Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ 29.6 хувь болсон бөгөөд 907.5 мянган хүн ядууралд өртсөн байна. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 30 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна.

График 19. Ядуурлын хамралтын хүрээ



Эх үүсвэр: УСХ

Ядуурлын түвшин 2011 оноос хойш тасралтгүй буурч байсан бол 2016 онд 29.6 болж 2014 оныхоос 8.0 пунктээр өссөн байна. Ядуурлын хамралтын хүрээ 2016 оны байдлаар хотод 27.1, хөдөөд 34.9 байгаа бол бүсийн хувьд зүүн бүс хамгийн өндөр буюу 43.9, баруун бүс 36.0, хангай бүс 33.6, төвийн бүс 26.8, Улаанбаатар 24.8 хувьтай байна.

Улаанбаатар хот болон Төвийн бүсэд ядуурал хамгийн бага буюу тухайн орон нутгийн нийт хүн амын 24.8-26.8 хувь нь ядуу байна. Баруун, Хангай болон Зүүн бүсэд ядуурлын хамралтын хүрээ хамгийн өндөр буюу тухайн орон нутгийн нийт хүн амын 33.6-43.9 хувь нь ядуу байна. Улаанбаатар хотод ядуурлын

хамралтын хүрээ хамгийн бага буюу 24.8 хувь байгаа боловч бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн их ядуу хүн ам буюу 343.1 мянган хүн байна. Хотод нийт хүн амын 67.8 хувь нь, ядуу хүн амын 62.1 хувь нь амьдарч байна. Харин хөдөө нутагт нийт хүн амын 14.6 хувь нь, ядуу хүн амын 18.8 хувь нь, сумын төвд нийт хүн амын 17.5 хувь нь, ядуу хүн амын 19.1 хувь нь амьдарч байна.

1.3.4. Нийгмийн даатгал

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилтын хүрээнд тэтгэвэр барьцаалсан зээлийн хүүг дахин 3 хувиар бууруулж, урт хугацааны зээлийн хүүг сарын 1.0, жилийн 12.0 хувиар тогтоож, хугацааг нь нэг жил хүртэл уртасгах, тэтгэврийн 70 хувийг зээл хэлбэрээр олгож, үлдэх 30 хувийг ахмадуудын гар дээр очиж байхаар Монголбанк, Хаанбанк, Төрийн банктай хамтран Санамж бичиг байгуулж хэрэгжүүлснээр 2018 оны 3-р сарын байдлаар 12.0 хувьтай урт хугацаатай тэтгэврийн зээлийг 11.6 орчим мянган тэтгэвэр авагч 12.9 тэрбум төгрөгийн зээл авсан байна. Мөн тэтгэврийн богино буюу 6 хүртэл сарын хугацаатай зээлийн хүү жилийн 18 хувьтай байсныг 3 хувиар буулгаж, 15.0 хувиар тогтоож, 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. 2018 оны 3 сарын байдлаар нийт 100.1 мянган тэтгэвэр авагч 80.2 тэрбум төгрөгийн зээл авсан байна.

Тэтгэвэр авагч өөрийн сонгосон банкаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлснээр 6.5 мянган тэтгэвэр авагч хүсэлтээ гаргаж, өөрт ойрхон банкаар хурдан, шуурхай үйлчлүүлэх боломжтой болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2018 оны 2 сарын 01-ний өдрөөс эхлэн 27.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, уг арга хэмжээнд 392.8 мянган тэтгэвэр авагчдад 119.5 тэрбум төгрөг зарцуулна.

Нийгмийн даатгалын хуулиудад 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны хувьд даатгуулагч өөрөө хүсвэл эрэгтэй 60, эмэгтэй 55 насандаа тэтгэвэрт гарах эрхтэй байх, тэтгэврийн насыг иргэнд хүндрэл багатайгаар буюу жилд 3 сараар нэмж 65 насанд хүргэхээр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн өргөн мэдүүлснийг 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн батлуулав.

Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас, 12 жил 6 сараас доошгүй жил нь шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хурсэн бол өндөр насны тэтгэвэрт гарах нөхцөл бүрдэж, хууль 2018 оны 01 сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхлээд байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар

дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг хийж, хуулийн заалтуудыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр мөн хуульчилсан.

Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Нийгмийн даатгалын сан	2014 /тэрбум төг/		2015 /тэрбум төг/		2016 /тэрбум төг/		2017* /тэрбум төг/	
	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага
НИЙТ	1,141.6	1,285.0	1,187.9	1,507.4	1,315.1	1,695.6	1,548.6	1,890.2
Тэтгэврийн	705.3	984.6	719.1	1,171.8	767.8	1,303.9	877.6	1,416.7
Тэтгэмжийн	78.4	78.4	81.1	87.0	86.9	92.3	109.0	100.3
ҮОМШӨ-ний	99.8	29.5	109.8	30.1	125.2	29.3	147.6	44.1
Ажилгүйдлийн	26.3	17.8	29.8	22.4	32.5	31.6	43.9	35.2
Эрүүл мэндийн даатгалын	231.8	174.7	248.1	196.1	302.7	238.5	370.5	293.9

Эх үүсвэр: УСХ

Нийгмийн даатгалын сангийн орлогын хэмжээг 2014 оны тувшинтэй харьцуулахад 2017 онд 407.0 тэрбум төгрөг буюу 35.7 хувиар, сангийн зарлага 605.2 тэрбум төгрөг буюу 47.1 хувиар тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг Засгийн газрын 2018 оны 16 дугаар тогтоолоор нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 280.0 мянгаар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 245.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, дундаж тэтгэвэр 342.8 мянган төгрөгт хүрлээ.

1.3.5. Нийгмийн халамж

Монгол Улсын хувьд нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа авах шаардлагатай иргэдийг төр ивээлдээ авч, амьдралын баталгааг нь алдагдуулахгүй байх зорилгоор 1995 онд Нийгмийн халамжийн анхны бие даасан хуулийг УИХ-аас батлан гаргасан. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид 2000, 2008 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орж, 1998, 2005, 2012 онуудад шинэчилсэн найруулга хийсэн юм. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд, Ахмад настны тухай, Алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулиудыг 2017 онд шинэчилсэн найруулгаар, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг шинээр тус тус баталсан. Одоогоор нийгмийн халамж, хүн амын өсөлтийг дэмжих чиглэлийн 6 хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж 12 төрлийн нийгмийн халамж, үйлчилгээний хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Эдгээр нийгмийн халамжийн арга хэмжээнд 2017 онд нийт 555.4 тэрбум төгрөгийг зарцуулснаас хүүхдийн мөнгийг оролцуулахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээнд 297.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 10. Нийгмийн халамж болон нийтлэг мөнгөн тусlamжийн зарцуулалт (тэрбум төгрөг)


Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017*
Нийгмийн эмзэг хэсэг	191.8	170.6	188.6	291.0	229.3
Нийтлэг мөнгөн тусlamжид	342.7	310.1	317.9	188.2	326.1
Нийт зардал	534.6	480.7	506.6	479.2	555.4

Нийгмийн халамжийг эмзэг, ядуу зорилтот бүлэгт чиглүүлэх зорилгоор халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоон зарим хөнгөлөлт, тусlamжийг нэгтгэн багцалж, халамжийн үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

1.3.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт

Сургуулийн өмнөх боловсрол. Улсын хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын буюу 2-5 насны хүүхдийн тоо 300.7 мянга байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 310.1 мянга болж 3.1 хувь буюу 9.1 мянган хүүхдээр өссөн байна. 2016-2017 оны хичээлийн жилд 1,354 цэцэрлэгт 243.4 мянган хүүхэд хамрагдаж байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 1,416 цэцэрлэгт 256.7 мянган хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 82.7 хувьд хүрсэн байна.

График 20. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын тоо



Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Сургуулийн өмнөх боловсролын 1,416 байгууллагын 62 хувь буюу 878 нь төрийн өмчийн байгууллага бөгөөд үүнд нийт сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн 85.7 хувь хамрагдаж байна. Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо 2013-2014 оны хичээлийн жилээс 2017-2018 оны хичээлийн жилийн хооронд жил бүр дунджаар 3.2 хувиар өсч байсан бол хувийн өмчийн байгууллагын тоо жил бүр дунджаар 23.7 хувиар өссөн байна. Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн тоо 2017-2018 оны хичээлийн жилд 2013-2014 оны хичээлийн жилээс 25.7 хувиар өссөн бол сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн тоо 32.5 хувиар өссөн байна. Харин Сургуулийн өмнөх боловсролын үндсэн багшийн тоо 2013-2014 оны хичээлийн жилд 5,895, туслах багшийн тоо 5,249 байсан бөгөөд 2014-2017 оны хичээлийн жилд дунджаар 8.2 хувиар өсч, 2017-2018 оны хичээлийн жилд үндсэн багш 7,745, туслах багш 6,970-д хүрч 32.0 хувиар өссөн байна.

Ерөнхий боловсрол. 2016-2017 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 778 сургууль байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 798 болж өсч тэдгээрийн 69.8 хувь буюу 557 нь хөдөөд, 30.2 хувь буюу 241 нь нийслэлд байршиж байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн тоо 2017-2018 оны хичээлийн жилд 652 байгаа нь өмнөх оноос 7 сургуулиар нэмэгдсэн бол хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн тоо мөн үед 13-аар нэмэгдсэн байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийн 81.7 хувь нь төрийн өмчийн бөгөөд нийт суралцагчдын 93.8 хувь нь төрийн өмчийн сургуульд хамрагдаж байна. Нийт суралцагчдын тоо 2017-2018 оны жичээлийн жилд өмнөх оныхоос 3.7 хувиар өссөн бөгөөд бага ангийн суралцагчдын тоо 6.9 хувь, дунд ангин 5.3 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн суралцагчдын тоо 10.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 11. Ерөнхий боловсролын сургууль болон суралцагчийн тоо

Үзүүлэлт		2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018
Сургуулийн тоо		756.0	762.0	768.0	778.0	798.0
Өмчийн хэлбэр	Төрийн Хувийн	628.0	628.0	636.0	645.0	652.0
Байршил	Хот Хөдөө	128.0	134.0	132.0	133.0	146.0
		203.0	214.0	215.0	226.0	241.0
Суралцагчдын тоо		497.0	505.8	535.0	551.9	572.7
Өдрийн анги	Төрийн Хувийн	468.3	476.6	504.0	520.2	537.7
		28.6	29.1	30.9.0	31.7	35.0

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Ерөнхий боловсролын сургуульд 2017-2018 оны хичээлийн жилд 20.2 мянган бүлэг хичээллэж байна. Бүлгийн тоо өнгөрсөн хичээлийн жилээс нийт 2.6 хувиар буюу бага ангийн бүлэг 4.3 хувь, дунд анги 6.2 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн бүлэг 7.8 хувиар буурсан байна. Нийт бүлгийн 62.9 хувь буюу 12.7 мянган бүлэг нэгдүгээр ээлжид, 36.2 хувь буюу 7.2 мянган бүлэг хоёрдугаар ээлжид, 0.8 хувь буюу 177 бүлэг гуравдугаар ээлжид хичээллэж байна. Улсын хэмжээнд 22 сургуулийн 177 бүлгийн 7,102 суралцагч гуравдугаар ээлжээр хичээллэж байгаагийн 85.5 хувь нь бага ангийн, 4.5 хувь нь дунд ангийн бүлэг байна.

Улсын хэмжээнд гуравдугаар ээлжээр хичээллэж байгаа 22 сургуулийн 19 нь нийслэл хотын 164 бүлгийн 6,700 суралцагч байгаа бол хөдөө орон нутагт 3 сургуулийн 13 бүлгийн 402 суралцагч байна. 2016-2017 оны хичээл жилд нийт 32 сургуулийн 224 бүлгийн 8755 суралцагч гуравдугаар ээлжид хичээллэж байсан бөгөөд үүний 31 нь нийслэл хотод байсан байна.

Дээд боловсрол. 2017-2018 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад дээд боловсролын 96 байгууллага сургалтын үйл ажиллагaa явуулж байгаагийн 36.4 хувь буюу 35 их сургууль, 54.1 хувь буюу 52 дээд сургууль, 6.2 хувь буюу 6 коллеж, 3.1 хувь буюу 3 гадаадын салбар сургууль байна. Үүнээс 89 нь нийслэлд, 7 нь орон нутагт харьяалагдаж байна. Нийт 155.2 мянган оюутан суралцаж байгаагийн 90.0 мянга нь буюу 58.0 хувийг эмэгтэй оюутнууд эзэлж байна. Боловсролын түвшний хувьд нийт оюутны 84.0 хувь буюу

130.4 нь бакалавр, 13.1 хувь буюу 20.3 мянга нь магистр, 2.7 хувь буюу 4.2 мянга нь докторын түвшинд суралцаж байна.

Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн өмчийн болон хувийн өмчийн их дээд сургууль, коллежийн тоо тус бүр 1-ээр өсч, гадаадын сургууль 1-ээр буурч нийт төрийн өмчийх 18, хувийн өмчийн 75, гадаадын 3 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад 2017-2018 оны хичээлийн жилд 45,480 суралцагч шинээр элссэний 32,919 буюу 72.4 хувийг тухайн жилд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсөж бүрэн дунд боловсрол эзэмшигчид, 4.9 хувийг бусад хэлбэрийн сургуулиас, 19.2 хувийг ажиллагчдаас, 3.6 хувийг ажилгүйчүүдээс элсэгчид бүрдүүлж байна. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад нийт шинээр элсэгчид 4,295-аар, түүний дотор ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсгөгчдөөс элсэгчдийн тоо 5,293-аар өссөн байна.

Шинжлэх ухаан, технологийн салбар. Шинжлэх ухаан, технологийн эрдэм шинжилгээ, судалгааны 41 төрийн өмчийн, 20 хувийн хэвшлийн нийт 61 байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Шинжлэх ухааны салбарт нийт 4,125 хүн ажиллаж байгаагийн 53.6 хувь буюу 2,211 нь үндсэн орон тооны, 46.4 хувь буюу 1,914 нь гэрээт ажиллагчид байна. Үндсэн ажиллагчдын 69.8 хувь буюу 1,544 нь эрдэм шинжилгээний ажилтнууд байна.

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар 499 шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжиж байсан бол 2018 оны байдлаар 296 үргэлжлэн хэрэгжиж, 210 орчим төслийг шинээр эхлүүлэхээр ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоол батлагдсан "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого" болон Засгийн газрын 2015 оны 368 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт"-ын хүрээнд хавдар, зүрхний шигдээсийг эмчлэх, элэг шилжүүлэн суулгах технологи боловсруулах зэрэг хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн томоохон төслүүдийг эхлүүлээд байна.

Соёл. "Монгол уран бүтээл" (2015-2025), "Соёлын баримтат өвийг хамгаалах" (2015-2022), "Соёлын үйлдвэрлэл" (2016-2020) үндэсний хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна. Өнөөдрийн байдлаар Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Киноны тухай хуулийн төсөл, Музейн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар соёл, урлагийн нийт 788 байгууллага 6,783 ажиллагчтай үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажиллагчдын 4.2 хувь нь урлагийн байгууллагад, 5.2 хувь нь музей, 45.7 хувь нийтийн номын санд, 41.3 хувь нь соёлын төв ордонд, 3.6 хувь нь кино үзвэрийн байгууллагад байна. Соёл урлагийн салбарт ажиллагчдыг 44.4 хувь нь дунд боловсролтой, 11.2 хувь нь дипломын, 38.2 хувь нь бакалаврын боловсролтой, 6.2 хувь нь магистр, докторын зэргийн боловсролтой байна.

Биеийн тамир, спорт. Улсын хэмжээнд спортын салбарт 31 төрийн байгууллага, төрийн өмчит улсын үйлдвэрийн 3 газар, 77 тогтмол үйл ажиллагаа

явуулдаг төрийн бус байгууллага, 1 төрийн өмчийн биетийн тамирын дээд сургууль, 3 төрийн бус өмчийн биетийн тамирын дээд сургууль, 8 спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын дунд сургуулиуд үйл ажиллагаа явуулж байна.


2017 онд шинэчлэн батлагдсан Биетийн тамир, спортын тухай хуулийн дагуу Монгол Улсын сумдад орон тооны биетийн тамирын арга зүйч ажиллуулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

1.3.7. Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2017 онд нийт 74 мянган хүүхэд эсэн мэнд мэндэлж Монгол Улсын хүн ам 3.2 саяд хүрч, хүн амын дундаж наслалт 69.5 болсон байна. Дундаж наслалт эрэгтэй 65.5, эмэгтэй 75.1 байна.

Сүүлийн жилүүдэд нялхын эндэгдэл тогтвортой буурч 2013 онд хамгийн бага түвшинд хүрч 1000 амьд төрөлтөд 14.6 болсон хэдий ч 2016 онд 16.5 болж өсч, 2017 онд эргээд буурч 13.6 болсон байна. Эхийн эндэгдэл мөн адил 2016 онд өсч 100000 амьд төрөлтөд 48.6 болсон ба 2017 онд 26.9 болж буурсан байна. 2017 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16.7 болж өмнө онтой харьцуулахад 306 тохиолдол, 2013 онтой харьцуулахад 194 тохиолдоор буурсан байна.

График 21. Эх, нялхас, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

Хүн амын өвчлөл. Монгол Улсын хүн амын өвчлөлийн нийтлэг шалтгаанд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчин зонхилж, хүн амын нас баралтын 77 хувийг эзэлж, салбарын нийт төсвийн 70 гаруй хувийг зарцуулж байна. Халдварт бус өвчиний улмаас цаг бусаар эрт нас барж байгаа үзүүлэлтийн хувьд бага болон дунд орлоготой орнуудтай харьцуулахад дэлхийд хоёрдугаарт орж байна. Нийт хүн амын 10000 хүн тутмаас 1,674.4 нь амьстгалын тогтолцооны өвчинеэр, 1,231.4 нь хоол боловсруулах тогтолцооны өвчинеэр, 1,007.6 нь зүрх, судасны тогтолцооны өвчинеэр, 807.6 нь шээс, бэлгийн тогтолцооны өвчинеэр, 469.9 нь гэмтэл хордлого бусад гадны шалтгаант үр дагавар бүхий өвчиний улмаас эмнэлэгт хандаж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчинеэс бусад бүх өвчлөл жил бүр нэмэгдсээр байна.

График 22. Хүн амын өвчлөлийн шалтгаан



Эх үүсвэр: YCX

Улсын хэмжээнд 2017 онд 28 төрлийн 44,300 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 2016 онтой харьцуулахад 25,363 тохиолдоор буурсан байна. Улаанбурхан өвчний дэгдэлт буурсантай холбоотойгоор нийт халдварт өвчний тохиолдлын тоо буурсан хэдий ч, цусан суулга, халдварт рикетсиоз, салхин цэцэг болон тэмбүүгийн тохиолдол нэмэгдсэн байна. Сүрьеэгийн шинэ тохиолдол жилд дундажаар 4,000 гаруй бүртгэгдэж 2017 онд 10000 хүн амд 12.4 болж, нийт бүртгэгдсэн халдварт өвчний 8.5 хувийг эзэлж байна. Сүрьеэгээр өвчлөгсдийн 70 гаруй хувийг 16-аас 44 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд эмчилгээний амжилт дунджаар 84 хувьтай байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон олон улсын хамтарсан багийн 2016 онд хийгдсэн үндэсний түвшний судалгаагаар сүрьеэгийн тархалт манай улсад тооцоолж байснаас 3 дахин өндөр байгаа болон халдварын тархалт эмзэг бүлгийн хүн амын дунд илүүтэй төвлөрч байгааг анхааруулсан байна.

График 23. Халдварт өвчнөөр өвчлөгчид



Эх үүсвэр: YCX

Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын 15,364 тохиолдол 2017 онд бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 34.7 хувийг эзэлж өмнөх оноос 2.7 хувиар өссөн байна. Нийт өвчлөлийн 28.8 хувийг заг хүйтэн, 43.4

хувийг тэмбүү, 27.6 хувийг трихомониаз, 0.2 хувийг ХДХВ/ДОХ-ын халдвартус тус эзэлж байна.

Улаанбаатар хотын хүн амын 59.1 хувь нь гэр хороололд суурьшиж, нийслэлийн нийт өрхийн дийлэнх хувь нь төвлөрсөн ус, дулааны хангамжид холбогдоогүй, автомашины тоо жил тутам ёсч байгаа зэрэг нь орчны бохирдлыг нэмэгдүүлж байна. Мөн Улаанбаатар хотын гэр хорооллын хүн амын хэт нягтрал суурьшлаас хамааран агаар, хөрс, газрын гүний усны бохирдол өндөр, ундны усыг зориулалтын бус саванд хадгалж байгаа зэрэг нь усны чанар, аюулгүй байдлыг алдагдуулж хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлсээр байна.

Хүн амын нас баралт. Хүн амын нас баралт 2017 онд 15,812 тохиолдол бүртгэгдэж өмнөх онтой харьцуулахад 369 тохиолдлоор, 2013 онтой харьцуулахад 380 тохиолдлоор буурсан байна. 2016 онд бүртгэгдсэн нийт нас баралтын 15-аас 20 орчим хувийг харьцангуй сэргийлж болох нас баралт эзэлж байна. Нас барсан хүн тутмын гуравны нэг нь зүрх судасны өвчинөөр, дөрвөн хүн тутмын нэг нь хорт хавдрын улмаас нас барсан байна. Халдварт өвчний шалтгаант нас баралтын 117 тохиолдол бүртгэгдсэний 68.4 хувийг сүрьеэ, 11.1 хувийг төрөлхийн тэмбүү, 5.1 хувийг вируст хепатит эзэлж байна.

График 24. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан



Эх үүсвэр: УСХ

Хорт хавдраар өвчлөгчдийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол ёсч 2016 онд 15,837-д хүрсэн байна. Үүний 5,739 нь шинээр өвчлөгчид байгаа нь өмнөх оноос 3.2 хувиар ёссөн үзүүлэлт байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ. Улсын хэмжээнд 2017 онд нийт 3500 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 6, тусгай мэргэжлийн төв 5, нэгдсэн эмнэлэг 39, эрүүл мэндийн төв 12, сумын эрүүл мэндийн төв 312, өрхийн эрүүл мэндийн төв 220, хувийн ортой эмнэлэг 234, үүдэн эмнэлэг 1076 байна. Улсын хэмжээнд 2017 онд 17 сая гаруй

эрүүл мэндийн үзлэг хийгдсэний 31.7 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг 47 хувийг өвчлөлийн улмаас эмнэлэгт хандсан үзлэг, 12.2 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нийт үзлэгийн 46.8 хувийг анхан шатны эрүүл мэндийн байгууллага буюу өрх, сумын эрүүл мэндийн төвд, үлдсэн хувийг лавлагаа шатлалын эмнэлэгт үзүүлсэн байна. Жилд дунджаар 750-850 гаруй мянган үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, жилдээ 5.9-аас 6 сая ор хоногийг ашиглаж жил бүр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо өсч байна.

Салбарт нийт 48,173 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагийн 10.0 мянга гаруй нь их эмч, 1.5 мянган эм зүйч, 11.4 мянга нь сувилагч, 7.4 мянга нь эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилчин байна. Нэг их эмчид 309, нэг сувилагчид 269 хүн ногдож байна. Сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч мэргэжилтний тоо өсч 2016 оны байдлаар 1,310 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад 8,730 гаруй эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагийн 33.6 хувийг их эмч, 23.4 хувийг сувилагч нар эзэлж байна. Нийт ажиллаж байгаа эмч нарын 27.8 хувь нь шүдний, 11.4 хувь нь уламжлалтын, 11.1 хувь нь дотрын, 8.9 хувь нь эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгын газар 2017 онд эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын эрүүл аж төрөх таатай нөхцөлийг нэмэгдүүлэх хүрээнд “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах хөтөлбөр”, “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөр”, “Элэг бүтэн Монгол хөтөлбөр”, “Орчны эрүүл мэнд-2 хөтөлбөр”, “Халдварт бус өвчинтэй тэмцэх-3 хөтөлбөр”-үүдийг тус тус батлан хэрэгжүүлж байна.

1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

1.4.1. Байгаль орчин, ногоон хөгжил

Монгол Улсын тогтвортой хөгжлийн тулгуур бодлогын нэг болох “Ногоон хөгжлийн бодлого”-ыг Улсын Их Хурлын 2014 оны 43 тоот тогтоолоор батлуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

2013 онд Монгол Улс нь НҮБ-ын “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл” (НЭЗТТ/PAGE) хөтөлбөрт нэгдэн орж дэмжлэг авах анхны улс болсон. Энэ хүрээнд сургуулийн ногоон барилгын жишиг зураг төсөл боловсруулах, ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, засгийн газрын худалдан авалтыг “ногоон” болгоход чиглэсэн тогтвортой худалдан авалтын эрх зүйн, зах зээлийн судалгаа хийж үе шаттайгаар нэвтрүүлэх, ногоон эдийн засгийн мэдлэг олгох, байгаль хамгаалал, цэвэр технологийн стандарт, норм нормативыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт. Уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас хэд дахин хүчтэй явагдаж байгаа, эмзэг өртөмтгий Монгол Улсын хувьд олон улсын дэмжлэг туслалцаанд хамрагдах шаардлага өндөр байгааг анхаарч, Парисын хэлэлцээрийг 2016 онд УИХ-аар соёрхон батлуулсан. Уг конвенцийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, хөгжиж байгаа улс орнуудад санхүү, техник технологи, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх механизмууд бий

болж НҮБ-ын Уур амьсгалын ногоон санд жил бүр 100 тэрбум ам доллар бүрдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 2017 оны байдлаар 102 байршилд 27.9 сая га талбайг хамарч, Монгол Улсын газар нутгийн 17.8 хувийг эзлээд байна. Монгол Улсын ойн сангийн 36.8 хувь, гол, горхи, булаг шанд, нуур, томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эх, гадаргын усны 44.7 хувь, Цэвдгийн 5.7 хувь, устах аюулд орсон болон устаж болзошгүй 300 гаруй амьтан, ургамлын үндсэн тархац нутаг, байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний түүх, соёлын үнэт өв бүхий газар нутгийн 80 орчим хувийг улсын тусгай хамгаалалтад хамруулан хамгаалж байна.

Хүснэгт 12. Улсын тусгай хамгаалалттай нутгийн ангилал /тоо, талбайн хэмжээ/

№	Тусгай хамгаалалттай газрын ангилал	Тусгай хамгаалалттай газрын тоо	Талбайн хэмжээ, сая га	Нийт газар нутагт эзлэх хувь
1	Дархан цаазат газар	20	12.4	7.9
2	Байгалийн цогцолборт газар	32	11.8	7.6
3	Байгалийн нөөц газар	36	3.5	2.3
4	Дурсгарт газар	14	0.12	0.09

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад 2017 оны байдлаар нийт 607 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Ус. Монгол Улсын гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбайн 44.7 хувь улсын тусгай хамгаалалтад хамрагдаж байна.

2012-2016 онуудад хот суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын хүрээнд 12 аймаг, сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн судалгааны ажлуудыг хийсэн байна. 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын төвийн, 2017 онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумыг төвийн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгаа хийсэн.

Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь аймаг, нийслэлд ихээхэн ялгаатай байна. Улаанбаатар хотод баталгаат ус хангамж өндөр хувьтай байгаа ч хотын захын гэр хорооллууд, Баян-Өлгий, Баянхонгор, Архангай, Ховд, Хөвсгөл, Завхан, Увс зэрэг аймгийн ихэнх хүн ам гадаргын усыг ахуйн зориулалтаар шууд хэрэглэж байгаа нь ундны ус хангамжийн эрүүл ахуй, чанарын шаардлагыг хангахгүй байна. Иймд гидрогеологийн судалгааны ажлын хэтийн төлөвлөгөөний чиглэлийн дагуу хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол орны хэмжээнд 2007-2016 оны хооронд улсын төсвийн хөрөнгөөр болон төсөл хөтөлбөрөөр бороо, цасны усыг хуримтлуулах нийт 117 хөв, цөөрмийг барьж байгууллав. Хөв цөөрөм байгуулж усны нөөцийг нэмэгдүүлэх

чиглэлээр 2017 онд Баянхонгор, Дорнод, Төв, Увс аймгуудад шинээр хөв цөөрөм байгуулан Булган, Дорнод, Увс аймгуудын хуучин хөв цөөрмийг сэргээн засварлав. Булган аймаг 4, Говь-Алтай аймаг 1 хөв цөөрөм байгуулах зураг төсвийн ажлыг боловсруулан батлуулаад байна.

Улсын хэмжээнд 2017 онд нийт 143 булаг шандны эхийг хашиж, хамгаалах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэв.

Агаарын бохирдол. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн агаарын бохирдол ихэсч, ялангуяа өвлийн улиралд Улаанбаатар хотын хэмжээнд нийт ажиглалтын 50 гаруй хувьд Монгол Улсын Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой байна. 2017-2018 оны хүйтний улирал буюу 2017 оны 10-12 дугаар сар, 2018 оны 1 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 15мкг/м3-ээр буюу 8 хувиар, PM2.5 тоосонцор 16мкг/м3-ээр буюу 10 хувиар, хүхэрлэг хий 17мкг/м3-ээр буюу 32 хувиар тус тус бага, азотын давхар ислийн агууламж өмнөх жилийн түвшинд байлаа.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 3,200 орчим халаалтын зуух гаргаж, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 400 мянга гаруй автотээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд гаргаж, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэрээс ялгарч байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/107 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Ой. Ойн сан бүхий газар 18.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.8 хувийг эзэлдэг бөгөөд үүний 12.3 мянган га нь ойгоор бүрхэгдсэн, 543.5 мянган га нь ойн сан доторх ойн бус талбай байна. Ойн сангийн талбайн 14.7 мянган га буюу 79.5 хувь нь хамгаалалтын бүсийн ой, 3.8 мянган га буюу 20.5 хувь нь ашиглалтын бүсэд хамарагдаж байна.

Ой зохион байгуулалтын судалгаагаар тогтоосон сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг харьцуулж үзэхэд ойгоор бүрхэгдсэн талбай 637.2 мянган га-гаар багасаж, ойгоор бүрхэгдээгүй талбай 918.4 мянган га-гаар нэмэгдсэн байна.

Цаг уурын дулаарлаас шалтгаалж ойд шавьж олширсноор жилд 450.0-500.0 мянган га талбайд хөнөөл учруулж асар их хэмжээний ойн сан дахин сэргэн ургахгүй нөхцөл үүсээд байна. Ойн хөнөөлт шавьж өвчний тархалтыг тогтоо судалгааны ажлыг 2015-2016 онд 4,617.4 мянган га талбайд явуулж 901.1 мянган га талбайд хөнөөлийн голомт байгааг тогтоосон. Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд ойн хөнөөлт шавжийн судалгааны ажлыг 15 аймаг, Нийслэлийн ногоон бүс, Богд-Хан уулын Дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын 100 гаруй, сум дүүргийн 2.6 сая га талбайд хийж, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг 9 аймаг, 23 сум, Нийслэлийн ногоон бүс, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газар, Богдхан-Уулын Дархан цаазат газрын 171.8 мянган

га талбайд биологийн болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар хийж гүйцэтгэлээ.

Хөрс хамгаалал. Хот суурин газрын хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын ариун цэврийн байгууламжаас гадна хог хаягдал, уул уурхайн хаягдал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн хаягдал, агаарын бохирдол зэргээс үүдэлтэй байна.

Улаанбаатар хотын хөрсний бохирдол, экогоеохимиин судалгаагаар 360 цэгээс сорьц авч шинжлэхэд 88 хувьд нь нян, хөгц мөөгэнцөр илэрсэн байна. Хот, суурин газарт гэр хорооллын ариун цэврийн байгууламжтай (жорлон, муу усны нүх) холбоотой нянгийн бохирдол өндөр байдаг бол орон нутагт уул уурхайн үүдэлтэй хөрсний бохирдол болон боловсруулах үйлдвэрлэл, машин засвар, хогийн цэгийн ойр орчмын хөрсөнд хар тугалга, хром, цайр зэрэг хүнд металлын бохирдол их байна.

1.5. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

1.5.1. Хууль, эрх зүйн шинэтгэл

Хууль зүй, дотоод хэргийн салбар “Эрх чөлөөтэй Монгол хүн” зорилтын хүрээнд ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхитай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, шударга, хүртээмжтэй болгох, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгоход чиглэсэн багц хуулийн төслүүдийг боловсруулан, УИХ-аар батлууллаа.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн тухай, Зөрчлийн тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Галт зэвсгийн тухай, Өршөөл үзүүлэх тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Арбитрын тухай хуулиудыг боловсруулан, УИХ-аар батлуулав.

Эрүүгийн хууль батлагдсанаар ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хууль эрх зүйн орчин сайжирч, гэмт хэргийн талаарх ойлголтыг өргөн хүрээтэй болгох, хүн, нийгэм, төрд учруулах хор аюулын шинж чанараас хамааран гэмт хэргийг үйлдлийн шинжээр нь тодорхой ялган заагласан.

Зөрчлийн тухай хууль батлагдсанаар Монгол Улсын хариуцлагын тогтолцоог нэгдсэн системд оруулж, уг систем ажиллах хууль эрх зүйн орчин

бүрдсэн. Уг хуулиар зөрчил, түүний бүрэлдэхүүнийг гэмт хэргийн шинжээс ялгаж, оногдуулах хариуцлагыг шинээр тогтоосон.

Хууль тогтоомжийн тухай хууль батлагдсанаар хуулийн төслийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах тогтолцоог бий болгож, хуулийн төслийн хэрэгцээ шаардлага, үр нөлөө, гарах зардлыг урьдчилан тооцоолох, үнэлгээ хийх боломжийг бүрдүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар боловсруулсан Захиргааны ерөнхий хууль батлагдсанаар захиргааны үйл ажиллагааг зохицуулсан суурь хуультай болж, захиргааны үйл ажиллагаа нийтлэг нэг зохицуулалтад орж, захиргааны хэргийн шүүх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн үндэслэл бий болж, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ерөнхий үйл ажиллагааг стандартчилан зохицуулах, хүний эрх, эрх чөлөө, хууль, ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлсэн.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар захиргааны хэргийн шүүхийн хяналтын хүрээ нэмэгдэж, хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тохирсон буюу сонгууль, тендер зэрэг нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой маргааны хувьд тусгай журмаар хянан шийдвэрлэх ач холбогдолтой боллоо.

Монгол Улсад 2017-2021 онд хэрэгжүүлэх “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны хөтөлбөр”, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөр” зэрэг томоохон хөтөлбөрүүдийг батлан, хэрэгжүүлж байна. Мөн ”Цахим гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Нэг иргэн, нэг бүртгэл хөтөлбөр”-ийн төслийг тус тус боловсруулж байна.

Цагдаагийн байгууллага. Монгол Улсын цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаанд түшиглэн, зохих түвшинд гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 90 гаруй хуулийн 180 орчим хэм хэмжээг иргэд, олон нийтэд сахиулах үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хил хамгаалал. Хил хамгаалах байгууллага нь Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурсас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хил хамгаалалтын нягтрал, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, хилчдийн албаны болон нийгмийн

асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Дорноговь аймгийн Сулинхээрийн хилийн 0168 дугаар ангийг Хатанбулаг суманд нүүлгэн шилжүүлж, Увс аймгийн Баруунтуруун суманд байрлах хилийн 0311 дүгээр ангийн хариуцсан хэсэгт “Хэсэг хариуцсан хил хамгаалалтын алба”-ыг шинээр байгуулан хил хамгаалалтыг өөрчлөн зохион байгуулж байна.

Улсын хил хамгаалалтад орон нутгийн засаг захиргаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, гишүүдийн нэгдсэн зөвлөгөөнийг орон нутгийн засаг захиргаа, хууль хяналтын байгууллагуудтай хамтран жил бүр зохион байгуулсаны үр дүнд хилийн дэглэмийн зөрчил жил тутам 10-15 хувиар буурч, улсын хил хамгаалалтын үр дүн дээшилсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь цагдан хорих болон баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх, иргэн, зөрчил, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд хаалттай 7, нээлттэй 9, нээлттэй, хаалттай дэглэмтэй 3 хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 23 хорих анги, Нийслэлд Цагдан хорих төв 1, орон нутагт 25 цагдан хорих байртайгаар үйл ажиллагаа явуулж байна. 2017 онд хорих анги, салбар нэгжүүдийн хэмжээнд бетон арматурчин, цахилгаанчин, мужаан, өрөг угсралч, засал чимэглэлчин, авто засварчин, хүнд машин механизмын операторчин, тогооч, гагнуурчин, сантехникч, арьсаар гар урлалын зүйл урлаач, уул уурхайн нөхөн сэргээлт, салхивч агааржуулагч тоног төхөөрөмжийн засварчин, ойжуулагч зэрэг мэргэжлүүдээр нийт 783 хоригдолд сургалт зохион байгуулж, “Мэргэжил эзэмшүүлэх гэрчилгээ” олгосон. Мэргэжлийн үнэмлэх олгох сургалтад 2016 онд 595 хоригдлыг хамруулж байсан бол 2017 онд нийт 783 хоригдол хамрагдсанаар хоригдлын тоо 188-аар буюу 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагаа. Бүртгэлийн байгууллагаас гаргасан тоон мэдээллээр 2017 оны жилийн эцсийн байдлаар иргэн, хуулийн этгээдэд нийт 271.7 мянган лавлагааг үнэт цаасаар олгосон.

Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлэх, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, үндэсний аюулгүй байдлыг ханган төрийн ой санамжийг бэхжүүлж, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэн цахим хэрэглээг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Хууль сахиулах сургалт болон эрүүл мэндийн үйлчилгээ. Хууль сахиулах аюулгүй байдлыг хангах байгууллагуудын албан хаагчдын мэдлэг, боловсролыг ажлын байран дээр нь дээшлүүлэх зорилго бүхий бүсийн сургалтын төвүүдийг Төв, Орхон, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Ховд аймгийг түшиглэн 5 бүсэд байгуулав.

Хууль сахиулахын их сургуулийн сургалтын үйл ажиллагааг олон улсын жишигт ойртуулах, ижил төрөл, мэргэжлийн их, дээд сургууль, судалгааны байгууллагын дэвшилтэд туршлагаас суралцан нутагшуулахад анхаарч, ОХУ, БНСУ, БНХАУ, БНТУ, ХБНГУ, АНУ, БНВУ, БНУУ, Канад, Тайланд зэрэг гадаадын 10 гаруй улс орон, Цагдаагийн сургуулиудын холбоо /INTERPA/, Засан хүмүүжүүлэх ба хорих байгууллагын олон улсын холбоо /ICPA/, Криминологчдын олон улсын холбоо /ICA/, Цагдаагийн байгууллагын дарга нарын олон улсын холбоо /IACP/, Ази дахь Цагдаагийн сургалтын байгууллагуудын холбоо /APTA/, Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллага /OSCE/ зэрэг олон улсын байгууллагуудтай харилцаа тогтоож, эрдэм шинжилгээ, сургалт судалгааны чиглэлээр хамтран ажиллаж байна. Хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, үр нөлөөг судалж, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд шинжлэх ухааны санал дүгнэлт өгөх, хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллээр үйлчлэх, хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа хийх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 68 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг сэргээн байгуулж, чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтний хамтарсан багийг бүрдүүлэн, эмчилгээ үйлчилгээний стандартыг хүн ардад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Тус эмнэлэг нь Монгол улсын стандарт “Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5095:2013-д нийцүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагууд болон шүүх, прокурор, гааль, онцгой байдал, тэдний гэр бүлийнхэн, чөлөөнд гарсан ахмадууд зэрэг нийт 130 гаруй мянган хүнд үзүүлж байна.

1.5.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн өмчийн талаарх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэж, ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангахад анхаарал хандуулан ажиллаж байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 95 хуулийн этгээд нь 2016 онд нийтдээ 506.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2017 оны жилийн эцэст 859.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015-2016 онд гүйцэтгэсэн “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>”-ийг 2017 онд бүрэн ашиглалтад оруулж, 1,133 төрийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд уг системд бүртгүүлсэн.

Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн

байгуулах үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгууллаа.

1.5.3. Стандарт, хэмжил зүй

Монгол Улсын хэмжээнд 2013 онд 6,135 стандарт мөрдөж байсан бол 2017 онд нийт 6,312 стандарт болж өссөн байна. Стандартчиллын ажлын хөтөлбөр, төлөвлөгөөнд жилд дунджаар 150-240 стандартыг боловсруулах, дахин хянахаар төлөвлөн, хэрэгжилтийг хангаж байна.

Тохирлын үнэлгээний 227 байгууллага итгэмжлэгдэн ажиллаж байгаагаас сорилтын 162, шалтгалт тохируулгын 15, эмнэлгийн 7 лаборатори, техникийн хяналтын 15, бүтээгдэхүүн баталгаажуулалтын 24, менежментийн тогтолцоо баталгаажуулалтын 3, хүлэмжийн хийн магадлагаа, нотолгооны 1 байгууллага байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 86 байгууллага шинээр итгэмжлэгджээ.

Монгол Улсын итгэмжлэлийн тогтолцоо Ази, номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (PAC)-ын хэлэлцээрт 2017 оны 6 сарын 18-ны өдөр нэгдсэнээр үндэсний бараа, бүтээгдэхүүн гадаад зах зээлд гарахад хөнгөлөлт үзүүлэх нэмэлт зардлыг багасгах, худалдаа, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжихэд чухал ач холбогдолтой болсон.

Үнэт металл, сорьцын хяналтын хүрээнд эрдэнийн чулуу, үнэт металлаар хийсэн эдлэлд шинжилгээ хийх, сорьц тогтоох ажлыг жилд дунджаар 1,000 гаруй удаа, мөнгөн эдлэлд сорьц тогтоох шинжилгээ, дотоодын болон импортын 60.0 мянган ширхэг эдлэлд сорьцын баталгаа олгож байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцрооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлуулж, салбарын хэмжээний эрх зүйн шинэчлэлийг хийв.

1.5.4. Улсын мэргэжлийн хяналт

Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хуулийг сахин мөрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, Монгол Улсын 106 хууль, олон улсын гэрээ конвенц 42, Улсын Их Хурлын 23 тогтоол, Засгийн газрын 300 тогтоол, 3,600 стандарт, техникийн зохицуулалт, 434 дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахад 27 чиглэлийн хяналтыг 2008 орон тоотойгоор хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 129 дүгээр тушаалаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бүрэлдэхүүнд 9 газар, мөн орон нутагт Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, аймгуудын мэргэжлийн хяналтын газар, хилийн

мэргэжлийн хяналтын албад, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллага 2016 онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 96,360 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, “Шилэн хяналтын цахим систем”-д бүртгэсэн бөгөөд нийт үнэлгээнд хамрагдсан объектын 14,277 буюу 14.8 хувь нь их эрсдэлтэй, 48,034 буюу 49.8 хувь нь дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Эрсдэлийн түвшин их болон дунд үнэлэгдсэн объектын 7,802 буюу 12.5 хувийг хяналт шалгалтад хамруулах ажлыг 99.3 хувиар, 5,255 буюу 8.4 хувийг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулах ажлыг 97.7 хувиар 2017 онд биелүүлсэн байна.

Харин 2017 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтаар 10,926 албан шаардлага, 5,889 зөвлөмж, 4,686 дүгнэлт гаргаж, 484 объектын үйл ажиллагааг түр, 35 объектын үйл ажиллагааг бүрэн зогсоосон байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас шинэчлэн боловсруулсан 33 шалгуур үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийж, нийт 50,365 шалгуулагч этгээдийн 123.4 мянган объектыг хамруулсан бөгөөд үүнээс эрсдэлийн түвшин их 17,649 объект, дунд эрсдэлтэй 71,943 объект, бага эрсдэлтэй 33,872 объект байна. Үүнээс эрсдэлийн түвшин их болон дунд үнэлэгдсэн обьектоос 2018 онд 7,831 шалгуулагч этгээдийн обьектод хяналт шалгалт, 5,538 шалгуулагч этгээдийн обьектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр, бусад хяналтын чиглэлээр 44 асуудлаар тандалт судалгаа, 17 асуудлаар хяналт шинжилгээ, 39 асуудлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, холбогдох хууль, тогтоомжоор олгогдсон чиг үүргийн дагуу 22 чиглэлээр баталгаажуулах үйл ажиллагаа, 39 чиглэлээр салбарын сургалтыг нэгдсэн удирдамж, заавраар зохион байгуулан хийхээр төлөвлөж, олон нийтэд зарлан, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

1.5.5. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд 2017 оны байдлаар 401 өргөлдөл, гомдлыг шийдвэрлэж, 243 хяналт шалгалтын ажил хийж, 21 аж ахуйн нэгж байгууллагыг хамрууллаа. Монополь, давамгай байдалтай аж ахуйн нэгжийн тоо 2017 онд 270-д хүрч, өнгөрсөн оноос 6-аар буюу 2.3 хувиар нэмэгджээ. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Шударга өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллана.

1.5.6. Онцгой байдал

Монгол Улсын хэмжээнд 2017 онд 4,194 удаа аюулт үзэгдэл, ослын тохиолдол гарч, 96.7 тэрбум төгрөгийн хохирол учирч, 14.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Аюулт үзэгдэл, ослын улмаас нийт 203 хүн амь насаа алдаж, 62 хүн гэмтэж, хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтын тоо 539.1 мянган толгой болсон байна. Гамшигтай тэмцэх хор уршгийг арилгахад Онцгой байдлын алба, орон нутгаас 1.4 тэрбум төгрөг, Улсын онцгой комисс, Засгийн газрын нөөц сангаас 6.9 тэрбум төгрөг зарцуулж, 1,162 хүний амь нас, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 21.8 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалжээ.

Мөн 3,536 удаа объектын түймэр гарч, 11.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, гал түймэрт 44 хүн өртөн амь насаа алдаж, 34 хүн түлэгдэж эрүүл мэндээр хохирсон байна. Өнгөрсөн 2017 онд ой, хээрийн түймэр 13 аймгийн 70 суманд 207 удаа, Улаанбаатар хотын 5 дүүрэгт 18 удаа, нийт 75 сум, дүүрэгт 225 удаа гарч, түймрийн улмаас 231.3 мянган га ойн болон бэлчээрийн талбай шатаж, түймрийг унтраахад 499.2 сая төгрөг, байгаль экологид 77.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Улсын хэмжээнд гамшигаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр 2017 онд 268,798 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, 198,615 зөрчил илрүүлснээс 71,170 зөрчлийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар 34,351 албан шаардлага, мэдэгдлийг холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлж ажиллажээ.

Гамшигаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшигаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Гамшигаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлаар батлууллаа. “Гамшигийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /2018-2030/-ийг Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 355 дугаар тогтоолоор, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 23 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг хангаж байна.

Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор “Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх Лхагва гарагийг Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгож, газар хөдлөлтийн гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх, таниулах ажлыг зохион байгуулан жил бүр улс даяар тэмдэглэн өнгөрүүлж байхаар шийдвэрлэсэн.

1.6. ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ

1.6.1 Гадаад харилцаа

Монгол Улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод

нийцсэн энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг туштай хэрэгжүүлж байна. Гадаад бодлогын нэг цонхны бодлого, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалах чиг шугамаа туштай баримталж, гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлж, улс орны хөгжлийн гадаад таатай нөхцөлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Олон улстай харилцаагаа бэхжүүлэх хүрээнд НҮБ-ын бүх гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоох чиглэлийг баримталж, 2017 оны жилийн эцсийн байдлаар дипломат харилцаатай улсын тоо 190-д хүрлээ. Эдгээр орнуудтай болон олон улсын байгууллагуудтай хоёр талын хийгээд олон талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна.

Хөрш орнуудын харилцаа. Гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болох ОХУ, БНХАУ-тай тогтоосон харилцааны түвшинг баталгаажуулж, чингэхдээ ОХУ-тай Стратегийн түншлэл, БНХАУ-тай Иж бүрэн стратегийн түншлэлийг бүхий л салбарт гүнзгийрүүлж, шинэ агуулгаар баяжуулж байна. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 9 дүгээр сард ОХУ-д ажлын айлчлал хийж Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтад оролцсон. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2017 оны 5 дугаар сард БНХАУ-д айлчилж, 6 дугаар сард ОХУ-ын Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцлоо. Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил 2017 оны 2 дугаар сард ОХУ, БНХАУ-д, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2017 оны 12 дугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийсэн.

Оросын Холбооны Улстай ойрын хугацаанд гарын үсэг зурахаар бэлтгэж буй “Төмөр замаар ачаа дамжуулан тээвэрлэх нөхцөлийн тухай” болон “Бус нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд нь Монгол Улсын бараа бүтээгдэхүүн, ашигт малтмалыг далайд саадгүй гарах, гуравдагч зах зээлд нэвтрэх нөхцлийг бүрдүүлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

“Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх механизм болон “Хөрөнгө оруулалтын судалгааны төв” байгуулах зарчмын тохиролцоонд хүрч, эхний ээлжинд тээврийн дэд бүтцийн чиглэлээр “Төмөр замын Төв коридор (Улаан Үүд-Наушки-Сүхбаатар-Улаанбаатар-Замын Үүд-Эрээн-Улаанцав-Жанчхүү-Бээжин-Тяньжин)-ыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах эдийн засгийн үндэслэлийг судлах”, “Азийн автозамын сүлжээний АН-3 (Улаан Үд-Хиагт/Алтанбулаг-Дархан-Улаанбаатар-Сайншанд-Замын Үүд/Эрээн-Бээжингийн гаднах тойрог-Тяньжин) чиглэлийг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах, тус чиглэлд хурдны автозам барих эдийн засгийн үндэслэлийг судлах”, эрчим хүчний чиглэлээр “Монгол, Оросын цахилгаан эрчим хүчний сүлжээг шинэчлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүд оролцох боломжийг судлах” төслүүдийг хэрэгжүүлэхээр тохирсон нь чухал алхам болсон.

“БНХАУ-ын нутаг дэвсгэрээр далайд гарах, дамжин өнгөрөх, олон улсын зэрэглэл бүхий авто болон төмөр замын боомт нэмж байгуулах асуудлыг хамтран шийдвэрлэх” ажлын хүрээнд “Монгол Улс БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарах, буцах болон дамжин өнгөрөх тээвэр хийх тухай хэлэлцээр” 2017

оны 5 дугаар сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болж, БНХАУ-ын нутгаар дамжин Хятадын 7 боомтыг манай улс ашиглах боломжтой боллоо.

Гуравдагч хөршийн харилцаа. “Гуравдагч хөрш”-тэй харилцах хүрээнд АНУ-ын зүгээс Монгол Улсыг ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдахад чухал дэмжлэг үзүүллээ. Мянганы сорилтын корпорацийн Захирлуудын зөвлөл 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, Монгол Улсыг 350.0 сая ам.долларын хоёр дахь компакт гэрээ байгуулах боломжтой орноор дахин шалгаруулсан.

Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Япон Улс 850.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг 3 үе шаттайгаар олгохоор шийдвэрлэсэн бөгөөд холбогдох хэлэлцээрт талууд 2017 оны 12 дугаар сард гарын үсэг зурж, эхний ээлжийн санхүүжилтийг манай талд шилжүүллээ.

Монгол Улс, АНУ, Япон Улсын гурван талт уулзалтыг 2017 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулсан нь чухал ач холбогдолтой боллоо. Европын холбооноос гуравдагч орнуудад хэрэгжүүлж буй хөгжлийн хамтын ажиллагааны санхүүжилтийг багасгаж байгаа хэдий ч Монгол Улсад 2014-2020 онд олгохоор шийдвэрлэсэн 65.0 сая европийн тусламжийг хэвээр үлдээсэн. Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр 2017 оны 11 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж, Европын холбооноос төлөөлөгчийн газраа Улаанбаатар хотноо албан ёсоор нээж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 1 дүгээр сард БНСҮ-д айлчилж, тус улстай ойрын жилүүдэд хамтран ажиллах салбар, чиглэлийг тохирч, Эдийн засгийн хамтын ажиллагааны сангаас олгох 500.0 сая ам.долларын зээлийн Ерөнхий хэлэлцээрийг амжилттай байгуулсан. Энэхүү зээлийн хөрөнгийг Улаанбаатар хотын агаарын бохирдол, орчны асуудлыг шийдвэрлэхэд ашиглахаар төлөвлөж байна.

БНЭУ-ын Засгийн газраас олгох 1.0 тэрбум ам.долларын зээлийн хэлэлцээрийг батлуулж, санхүүжилтийг 2017 оны 8 дугаар сараас хийж эхэллээ.

Улсын Их Хурлын дарга М.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Бангладеш Улсын нийслэл Дака хотноо 2017 оны 4 дүгээр сарын 1-4-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын парламентын холбооны Ассамблейн 136 дугаар чуулганд, Гадаад харилцааны сайд АНУ-ын Нью-Йорк хотноо 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 72 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд, Швейцарийн Женев хотноо 2017 оны 2 дугаар сарын 28-ний өдөр зохион байгуулагдсан Хүний эрхийн зөвлөлийн 34 дүгээр чуулганы үеэр болсон Өндөр түвшний хуралдаанд, Тайландын Вант Улсын Бангкок хотноо 2017 оны 5 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд болсон Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 73 дугаар чуулганд, Бүгд Найрамдах Австрали Улсын нийслэл Вена хотноо 2017 оны 12 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд болсон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сайд нарын зөвлөлийн 24 дүгээр уулзалтад тус тус оролцлоо.

Улаанбаатар хотод төвтэй Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийн үйл ажиллагааг 2017 оны 10 дугаар сарын 6-наас олон улсын байгууллагын статустайгаар эхлүүллээ.

БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааг жилийн хугацаанд хийж, холбогдох хэлэлцээг 2018 оны сүүлийн хагасаас эхлүүлэх нөхцөл бүрдэв. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллах “Үндэсний хороо”-г байгуулж, Европын холбоотой хамтран “Худалдааг дэмжих төсөл”, Дэлхийн банктай хамтран “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн вебсайт байгуулах төсөл” хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

“Монгол экспорт” хөтөлбөрийн төслийг боловсруулж, экспортын нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Технологи, инновацийн судалгаа, мэдээллийн зөвлөл”-ийг Гадаад харилцааны сайдын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/70 тушаалаар Боловсрол соёл, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк, Мэдээлэл технологийн газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагын Үйлдвэрлэл, инновацийн газар, Шинжлэх ухааны академи, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монголын хөдөө аж ахуйн их сургууль зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байгууллаа.

Улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ улс төр, эдийн засгийн харилцааны түвшинг соёлын хамтын ажиллагаатай цогцоор нь бодлогын түвшинд уялдуулах, Монгол Улсын түүх, соёл, ёс зан заншил, өв уламжлал болон хөгжил дэвшилийг хилийн чанадад сурталчлах, гадаад орнуудтай соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад сурталчилгаанд үндэсний нэгдсэн тогтолцоог бий болгох хүрээнд “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”, “Дэлхийн Монголчууд хөтөлбөр”-ийг хэрэгжилтийг хангаж байна.

Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах, соёрхон батлах, хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох, тайлбар хийх, гэрээг биелүүлэх, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний үйлчлэлийг дуусгавар болгох, нийтлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Олон улсын гэрээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж байна. Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар тогтоолоор “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”, 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 193 дугаар тогтоолоор “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-уудыг тус тус шинэчлэн батлууллаа.

1.6.2. Батлан хамгаалах

Батлан хамгаалах салбар төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг улс орны хэмжээнд уялдуулан зохицуулах, Зэвсэгт хүчнээ хөгжүүлэн бэхжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэн, “Монгол Улсын Засгийн газрын тухай хууль”, “Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Эрх зүйн орчны шинэчлэл. Монгол Улсын Их Хурлаар “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, батлан хамгаалахын багц

хуулиуд болох “Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай”, “Цэргийн албаны тухай”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулиудыг батлуулснаар салбарын эрх зүйн шинэчлэлийг хийж, улмаар Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай”, “Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Дайны байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” зэрэг хуулиудыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Батлан хамгаалахын багц хуулиуд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулж мөрдүүлэх 40 орчим эрх зүйн актын жагсаалтыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/374 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Батлан хамгаалах бодлого, багц хуулиар төрийн цэргийн байгууллагыг хуульчлан тогтоосны дагуу төрийн цэргийн байгууллагуудын хөгжлийн стратегийг тодорхойлсон “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” баримт бичгийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 127 дугаар тогтоолоор батлуулсан.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлүүд болон Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратегид тусгагдсан зорилго, зорилтуудтай уялдуулан “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 80 дугаар тогтоолоор батлуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлууллаа.

Зэвсэгт хүчний шинэчлэл. Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны гишүүд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын үйл ажиллагаатай танилцаж, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2018 оны “Чиглэл өгөх тухай” 2 дугаар тогтоол гарч, тогтоолын хэрэгжилтийг хангахыг Засгийн газарт даалгаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Оюутан-цэрэг” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Дорнод, Говьсүмбэр аймаг дахь их, дээд сургуулийн оюутнуудыг хамруулан “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтыг орон нутагт нь зохион байгуулж, улмаар “Цэргийн мэргэжлийн бэлтгэл” сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Сургалт-дадлагын төв, Ховд аймаг дахь Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хээрийн сургалтын төв, Дорнод аймаг дахь Зэвсэгт хүчний 327 дугаар

ангийн хээрийн сургалтын төвд тус тус зохион байгуулж, нийт 903 оюутан-цэрэгт цэргийн мэргэжил олгосон байна.

Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар тогтоолоор “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох журам, 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор “Иргэнийг цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг баталсан.

Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан 2017 онд Зэвсэгт хүчний цэргийн баг оролцуулах энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах арга хэмжээний жагсаалтын дагуу Монгол Улсад болон бусад улсад зохион байгуулагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаа, олон улсын хамтарсан сургалт, дадлага, хээрийн сургуулийг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал, энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр бусад улс орнуудтай “Шийдвэртэй дэмжлэг”, “Хааны эрэлд-2017”, “Сэлэнгэ”, “Нүүдэлчин заан” “Шийдэмгий шийдвэр”, “Анчин бүргэд” зэрэг сургалтуудыг хамтран зохион байгуулав.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлын асуудлаар зохион байгуулдаг бус нутгийн болон олон улсын дээд хэмжээний уулзалтад Батлан хамгаалах салбарын төлөөлөгчид тогтмол оролцож Монгол Улсын аюулгүй байдлыг улс төрдипломатын аргаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2020-2021 ОНЫ ХАНДЛАГА

2.1 МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Өнгөрсөн 2017 онд ДНБ 5.1 хувиар өссөн нь эдийн засаг сэргэж байгааг илтгэх боловч нөгөө талаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтвортгүй, хэлбэлзэл ихтэй байна. Дэлхийн түүхээс харвал эдийн засгийн өсөлт нь тодорхой түвшинд, тогтвортойгоор удаан хугацааны турш хадгалагдсан орнууд ихэвчлэн амжилттай хөгжсөн байдаг. Тухайлбал, 1960 оноос хойш жилд дунджаар 7 хувиар 25 жилийн турш эрчимтэй хөгжсөн 13 орон байна. Эдгээр орнуудын суурь нөхцөл нь ялгаатай байсан ч (Япон улс /дайны дараах сэргээн босголт/, Азийн дөрвөн бар болох Хонгконг, Тайвань, Сингапур, Өмнөд Солонгос улс /жижиг боловч далайн боомттой/, БНХАУ /аварга том боловч тогтвортой засаглалтай/, Ботсвана, Бразил, Индонез, Малайз, Тайланд, Оман /Байгалийн баялаг арвантай/, Малта /Хүн ам цөөн/) хөгжлийн шинэ шатанд гарч чадсан нь тогтвортой өсөлтийн үр шим гэж Дэлхийн банк дүгнэжээ. Эдгээр улс орнууд нь тогтвортой өсөлтийг хадгалж чадвал газар нутаг, эдийн засгийн том, жижиг, хүн амын олон, цөөн, далайд гарцтай эсэх, байгалийн баялагтай үгүйгээс үл хамааран аливаа улс хөгжиж болдогыг харуулсан байна.

Иймд эдийн засгийг жигд, алгуур өндөр түвшинд хүргэхэд урт хугацааны тогтвортой өсөлт чухал үүрэгтэй байна. Монгол Улсын Засгийн газар Татварын орчныг шинэчлэн, хялбар, энгийн болгох, шударга өрсөлдөөнийг урамшуулах,

бизнес эрхлэхийг урамшуулах замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг 2019 онд 8.0 хувьд хүргэх зорилт дэвшүүлж байна. Ингэснээр эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдах боломж бүрдэх юм.

Татварын бодлогоор хөрөнгө оруулагчдыг дэмжих хүрээнд ногдол ашиг, хүүгийн орлого зэрэг хөрөнгийн орлогод ногдуулах суутган татварын хувийг бууруулах, хөрөнгийн элэгдэл байгуулах хугацааг багасгах, алдагдал шилжүүлэх хугацааг уртасгах, гадаадад төлсөн татварыг хасагдуулах, үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн НӨАТ-ыг хасах боломжийг олгох замаар хөрөнгө оруулалтаа богино хугацаанд нөхөх бололцоог бүрдүүлж, бизнес эрхлэхийг урамшуулахаар төлөвлөсөн байна.

Мөн урт хугацааны тогтвортой өсөлтөөс гадна бас нэг чухал зүйл бол эдийн засгийн өсөлтийн үр шимийг олон нийтэд хүргэх, хүртээмжтэй өсөлтийн асуудал юм.

Манай орны хувьд хүн амын гуравны нэг нь ядуу, хөдөө орон нутагт ажлын байр хомс бөгөөд худалдаа, үйлчилгээнээс өөр бизнесийн үйл ажиллагаа бараг байхгүй, малчдын орлогын эх үүсвэр болсон ХАА-н түүхий эдийн үнэ доогуур, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж иргэдийн амьжиргааны түвшин, бодит орлого буурсан зэргээс харахад зарим жилүүдэд эдийн засаг өндөр өсөлттэй байсан хэдий ч эдийн засгийн өсөлт иргэдэд хүрч чадаагүй болохыг илтгэнэ. Энэ хугацаанд иргэдийн орлогын ялгаа нэмэгдэж, ядуурал өссөн байна.

Эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох асуудал нь нийгэмд тэгш боломжийг олгохоос эхлэнэ. Татварын шинэчлэлийн араас нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл, үйлдвэрлэгч худалдан авагчийг холбосон дэд бүтцийн шинэчлэл, хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэл, аж үйлдвэр, кластер зохион байгуулалтын шинэчлэл, олон нийтийн соёл, нийтээр хүлээн зөвшөөрөх дүрэм, журамын шинэчлэл, төрийн албан хаагчдын бүтээмж, үнэлэмжийн шинэчлэл, төрийн үйлчилгээний цахим шинэчлэл зэрэг маш олон шинэчлэлийг хийх шаардлагатай байна.

2019 онд Бизнес эрхлэгчид шудрагаар өрсөлдөх, төрийн бодлого, шийдвэр, аливаа зөвшөөрөл, лиценз, эрх, болон бодлого, шийдвэр, худалдан авалтын тухай мэдээллийг авах боломжоор тэгш хангагдах, төрийн үйлчилгээний субектив байдлыг бууруулах зорилгоор төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийнэ.

Шигтгээ 1

Эстони Улс Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнээс тусгаар тогтнолоо 1991 онд сэргээнээсээ хойш эдийн засаг, хүний хөгжил, болон боловсролын салбарт асар их амжилт гаргасан ч дэлхийд цахим дэвшлээрээ хамгийн алдартай. Одоо дөнгөж 1.3 сая иргэнтэй ч тус улс нь Skype, цахим төр, цахим иргэншлийн эх нутаг.

Эстони нь хууль батлах, сонгууль, боловсрол, шүүх, эрүүл мэнд, банк, татвар, цагдаа гээд төрийн оролцоотой бүх үйлчилгээнүүдийг нэгэн платформд нэгтгэсэн байна. Эстони чадвартай төрөөс авах бараг бүх үйлчилгээгээ цахим хэлбэрээр авч болох бөгөөд зөвхөн гэрлэх, биет өмч хөрөнгө шилжүүлэх тохиолдолд л төрийн агентлаг дээр биеэр очих ёстой.

1. “Ганц удаа”-гийн дүрэм

Энэ дүрэмд аливаа иргэн нь өөрийн мэдээллийг нэг удаа мэдээлсэн л бол ахиж мэдээлэх шаардлагагүй байх ёстой гэж заажээ. Жишээ нь зээлийн хүсэлт гаргахад өөрийн овог, нэр, регистрийн дугаараас авахуулаад орлого, хөрөнгийн мэдээллийг бөглөх шаардлагагүй. Энэ бүх мэдээллийг өмнө нь системд мэдүүлчихсэн байсан мэдээллийг нь автоматаар бөглөөд өгчихсөн байх бөгөөд тухайн хүн хүсэлтээ гаргахад цахим гарын үсэг зурах л шаардлагатай байх болно. Татварын маягт мэдүүлэхэд дундажаар 3-5 минут шаардлагатай. Мөн жишээ нь оюутан бол үнэмлэхэнд нь тухайн оюутны шаардлагатай бүхий л мэдээлэл байх ба нийтийн тээвэр болон дэлгүүрт хөнгөлөлт эдлэхэд, тус үнэмлэх ашиглагддаг. Иргэн эмнэлэг дээр очиход тухайн хүний өвчний бүхий л түүх эрүүл мэндийн салбарын цахим мэдээллийн санд хадгалагдах байдаг.

шийдвэрлүүлэхийн тулд дүрэм, журмыг судалдаг болж манай улс эдийн засаг, нийгмийн хөгжлийн хувьд шинэ шатанд гарах үндэс тавигдах юм.

Цаашид хуулийг хүн бүр өөрийнхөө ойлголтоор тайлбарладаг, хууль, дүрэм, журмын хэрэгжилт ялгаатай байдаг байдлыг бүрэн халж, цаасан дээр бичигдсэн хууль, дүрэм нэг утгаар ойлгогдож, ёсчлон мөрдөгддөг хариуцлагатай засаглал төлөвшихөд нэг алхам ойртох юм.

Иргэдэд тэгш боломж олгож, эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгоно гэдэг нь нөгөө талаар ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхийг хэлж байна. Манай улс хүн ам цөөн, хөдөлмөрийн нөөц бага байтал нөөцийн ашиглалт тааруу байна.

Хоёр сая орчим хөдөлмөрийн насны хүн ам байгаагаас дөнгөж 62 хувь нь ажил хөдөлмөр хийх сонирхолтой буюу ажиллах хүчинд хамрагдаж байгаа нь бусад оронтой харьцуулахад хөдөлмөрийн нөөцийн ашиглалт доогуур түвшинд байна. Иймд хөдөлмөрийн зах зээлийн үндсэн асуудал болсон эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, энэ хүрээнд мэргэжил сонгоход нь дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх замаар ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.1.1 Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын Засгийн газраас “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг 2016-2018 онд амжилттай хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг 1.2 хувиас 5.1 хувь хүртэл нэмэгдүүлсэн бөгөөд цаашид эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг тавих, эрсдэл даах чадавхийг сайжруулах үүднээс “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлж байна. Энэ бодлогын нэг чухал хэсэг нь татварын шинэтгэл бөгөөд тус шинэтгэлийн хүрээнд бизнес эрхлэгчдийн татвар төлөхтэй холбоотой гарах зардлыг бууруулах, татварын тэгш шударга байх нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах зорилгоор ногдол ашиг, хүүгийн орлогод ногдуулах татварыг багасгах зэрэг өөрчлөлтийг хийх юм. Энэхүү хуулийн өөрчлөлт нь дунд болон урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжих бололцоог бүрдүүлнэ.

Эдгээр бодлогын үр дүнд эдийн засгийн дотоод орчин сайжирч байгаа бол олон улсын байгууллагуудаас Дэлхийн эдийн засгийн төлвийг харьцангуй тогтвортой байхаар төсөөлж байна. Гэсэн хэдий ч Трампын засаг, захиргаанаас авч хэрэгжүүлж байгаа худалдааны бодлого гадаад орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байгаа болно.

Гадаад болон дотоод орчны нөхцөл байдлыг харгалзан үзвэл Монгол Улсын эдийн засаг 2019-2021 онд 6-8 орчим хувьд байхаар байна.

Эдийн засгийн дунд хугацааны өсөлтөд хөрөнгө оруулалт болон экспортын өсөлт голлон нөлөөлнө гэж үзэж байна. Татварын шинэтгэл болон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын дунд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ дунд хугацаанд жилд дунджаар 10 орчим хувиар өсөх төсөөлөлтэй байна. Хөрөнгө оруулалт, экспортын өсөлт нь ажлын байрыг нэмэгдүүлэхээс гадна улсын төсвөөр дамжин иргэдийн бодит орлогыг өсгөж, улмаар өрхийн хэрэглээг дунд хугацаанд нэмэгдүүлэхээр байна.

Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл 2019 онд уул уурхайн салбар 6.3 хувиар өсөхөөр байна. Үүнд Оюу-Толгойн олборлох алтны хэмжээ 2019 онд 2018 оноос 12 хувиар өсөх нь голлон нөлөөлөх ба нүүрсний олборлолт тогтвортой байхаар байна.

Уул уурхайн бус салбарын өсөлт 2019 онд 8.4 хувиар өсөхөөр төсөөлж байна. Хөрөнгө оруулалтын үр дүнд барилга, угсралтын ажил 2019-2021 онд 5-14 хувиар өсч, уул уурхайн бус салбарын өсөлтийг дэмжихээр байна. Урьдчилан төсөөлж байгаагаар барилгын салбар 2019 онд 14 хувиар өсөхөөр байна. Хөрөнгө оруулалт, экспортын өсөлт нь тээвэр, худалдаа болон санхүүгийн салбарыг өсөлтийг дэмжиж, үйлчилгээний салбар 2019 онд 8.6 хувиар өсөх төлөвтэй байна.

График 25. Эдийн засгийн өсөлт болон нэрлэсэн ДНБ-ий хэмжээ



Эх үүсвэр: Сангиин яам

Тайлбар:
 * Урьдчилсан гүйцэтгэл
 ** Хүлээгдэж байгаа гүйцэтгэл
 *** Төсөөлөл

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүтцийн өөрчлөлтийн бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт 2020-2021 онд 6 хувиар өсөхөөр байна.

Оюу-Толгойн ил уурхайгаас олборлох алтны хэмжээ 2020 онд буурахаар байгаа хэдий ч, далд уурхайн бүтээн байгуулалт болон Засгийн газраас эдийн засгийг идэвхижүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх болон үйлдвэржилтийг дэмжих бодлогуудын үр дүнд 2020 онд эдийн засгийн өсөлт 6 хувиар өсөхөөр байна. Харин 2021 оноос Оюутолгойн далд уурхайн олборлолт, баяжуулалт эхлэх тул эдийн засгийн өсөлтийн хурдац хадгалагдахаар байна.

2.1.2 Хэрэглээ, хуримтлал

ДНБ-д эзлэх нийт хэрэглээний түвшин 2018-2021 онд тогтвортой өсөх хандлагатай байна. Дунд хугацаанд нийт хэрэглээнд эзлэх өрхийн хэрэглээ болон төрийн байгууллагын хэрэглээний түвшин өсөхөөр төсөөлөгдөж байна. Энэ нь Засгийн газраас татварын шинэчлэл, зорилтод бүлэгт чиглэсэн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэд, аж ахуйн нэгжийн орлого, хэрэглээг өсгөх замаар эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх бодлоготой холбоотой юм.

Дунд хугацаанд нийт хуримтлалын хэмжээ тэр дундаа үндсэн хөрөнгийн хуримтлалын хэмжээ өсөх төлөвтэй байна. Үндсэн хөрөнгийн хуримтлал нь нийт хуримтлалын 70 гаруй хувийг эзэлдэг бөгөөд үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт нь хөрөнгө оруулалтын хэмжээнээс ихээхэн хамаардаг. Дунд хугацаанд ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээл, тусlamжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийгмийн чанартай томоохон төслүүд, Оюу-Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, ДЦС-иудын өргөтгөл, Төв цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нэлөөгөөр хөрөнгө оруулалт өсөж, нийт хуримтлалын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ өсөхөөр төсөөлөгдөж байна.

2.1.3 Инфляци

Суурь тооцоогоор инфляцийн түвшин 2019 онд зорилтот түвшинд байхаар байна. ОУВС-ийн хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдан инфляцийн түвшин 2019-2021 онд 8 орчим хувьд байхаар байна.

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшин өсөхөд эрэлтийн болон нийлүүлэлтийн дарамт байна. Эдийн засгийн өсөлт идэвхижиж байгаа нь хүн амын худалдан авах чадвараар дамжиж, эрэлтийн гаралтай инфляци өсөх дарамтыг бий болгож байна. Нөгөө талаар дэлхийн эдийн засгийн сэргэлттэй уялдан гадаад зах зээлд газрын тосны үнэ 2016 оноос өндөр байхаар байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийг өдөөж болзошгүй байна. Гэсэн хэдий ч Засгийн газраас татварын багц хуулийн шинэчлэл хийж, бизнесийн орчныг сайжруулах, тодорхой салбаруудад 1.5 тэрбумаас бага орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлж байгаа нь бизнесийн зардлыг бууруулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, инфляцийн түвшинг тогтвортой байлгах боломжийг бүрдүүлнэ.

Түүнчлэн, төсвийн алдагдлыг бууруулж, мөнгөний нийлүүлэлтийг зохистой түвшинд хадгалах замаар төгрөгийн ханшийт тогтвортой байлгаж, инфляцид үзүүлэх дарамтыг бууруулна.

Эдгээр цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр инфляцийн түвшинг зорилтод хэмжээнээс хэтрүүлэхгүй байх боломж бүрдэх юм.

2.1.4 Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 онд 12.2 тэрбум ам.долларт, 2020 онд 12.6 тэрбум ам.долларт, 2021 онд 13.0 тэрбум ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 2019-2021 онд дунджаар 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарагаар байна.

Экспорт 2019 онд 5.2 хувиар өсөж 6.6 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Энэ нь Оюу-Толгойн зэсийн баяжмал дахь алт болон зэсийн агууламж нэмэгдэх болон нүүрс экспортлогч компаниудын экспортыг нэмэгдүүлэх, борлуулж байгаа нүүрсний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй холбоотой юм. 2021 онд Оюу-Толгойн далд уурхайгаас зэсийн баяжмал экспортлогдож эхлэхтэй холбоотойгоор экспортын нийт орлого жилд дунджаар 3.0 хувиар өсөхөөр байна.

2019 онд уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байгаа, эдийн засгийн өсөлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор худалдан авалт идэвхжиж, импортын хэмжээ 18.2 хувиар өсөж, 5.6 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Цаашид 2020-2021 онд жилд дунджаар 3-4 хувиар өсөхөөр тооцлоо.

2.1.5 Төлбөрийн тэнцэл

Дунд хугацаанд уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихтэй холбогдон эдийн засгийн идэвхижил нэмэгдэж, улмаар импортын хэмжээ өсөх, түүнчлэн зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэхээр хүлээгдэж байгаа нь урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэх төлөвтэй байна.

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл 2018 оны 3 дугаар сар 28-нд “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн 3 дахь шатны үнэлгээг баталлаа. Хөтөлбөр амжилттай хэрэгжих хугацаанд нийт 434.3 сая ам.долларын санхүүжилт олгогдооос 152.79 сая ам.долларын санхүүжилт олгогдоод байна. Түүнчлэн уг санхүүжилтийг дагалдан Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Жайка зэрэг байгууллагуудаас 2018 онд 580, 2019 онд 550 гаруй сая ам.долларын төсвийн дэмжлэг орж ирэх хүлээлттэй байна.

Төгрөгийн ханшийг тайлбарлагч гол хүчин зүйл болох төлбөрийн тэнцэл ирэх жилүүдэд ашигтай гарахаар байгаа ба үүний үр дүнд гадаад валютын улсын нөөц мөн нэмэгдэж байгаа нь төгрөгийн ханш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.1.6 Ажилгүйдэл

Ажиллах хүчний түүвэр судалгаанд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн 2018-2021 оны тооцоо, төсөөллийг гаргахад ажиллагчдын тоо жилд дунджаар 3.4-5.0 хувиар өсч, ажиллах хүчний оролцооны түвшин 62.4 хувиас 64.0 хувьтай байхаар байна.

Дунд хугацаанд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 3 тулгуурт бодлого, Хөгжлийн зам зэрэг уул уурхай, дэд бүтэц, боловсруулах салбарын томоохон төслүүдийг эрчимжүүлсний үндсэнд дээрх үр дүнд хүрэх юм.

Үр дүнд нь ажилгүйдлийн түвшин дунд хугацаанд 7.5-8 хувьд байхаар байна.

2.2 БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ

2.2.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд шинээр дараах эрхзүйн баримт бичгүүдийг боловсруулж, батлуулна. Үүнд: Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл, Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл, Таримал ургамлын үр сортын тухай хуулийн төсөл, Худалдааны тухай, дэмпингийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд холбогдох худалдаа, үйлчилгээний журам, бусад холбогдох журмын төсөл, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн

найруулга, Хоршооны тухай хууль, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг боловсруулах зэрэг болно.

Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг хийж, улсын хэмжээнд малчин өрх, малын тоо, малын үүлдээрлэг байдал, ашиг шимиин түвшинг тогтоож, дүгнэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа хашаа хороо, уст цэгт техникийн тооллогыг явуулах, улсын нэгдсэн бүртгэлийн системд мэдээллийг оруулж бүртгэлжүүлнэ. Мөн малын бүртгэлийн системийг онлайнд шилжүүлэх техник, технологийн шинэчлэл хийх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн болон малын үргүүлэг, технологийн ажил үйлчилгээнд техникийн шинэчлэл хийнэ.

Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин, архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, эрүүлжүүлэх стратегийг бүсчлэн хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулна.

Хүн амын хүнсний хангамжийг тогтвортжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын мал, сүүний хэрэгцээг тогтвортой хангах, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мал, сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх, мах, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

“Атрын гурав дах аян”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хүнсний ногоо, жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хадгалалт, борлуулалтын цогцолбор байгуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэх, услалтын системийг шинээр барих, сэргээн завсарлах, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, тариалангийн алслагдсан бүсэд элеватор байгуулах, үтрээний дэвшилтэт технологийн шинэчлэл хийх, бодлогоор дэмжинэ.

Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангана.

Хөнгөн үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр, Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор “Ноолуур хөтөлбөр”-ийг тус тус боловсруулан батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, загвар хоршоод болон бизнес дэмжих төвийг байгуулна. “Ноолуур хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх эдийн засгийн өндөр үр ашигтайгаас гадна ажлын байр нэмэгдэх, хадгалагдах, манай улсын гадаад валютын нөөц, улмаар улсын төсөвт төвлөрөх татварын хэмжээ нэмэгдэх юм.

Арьс ширийг байгальд ээлтэй технологиор бүрэн боловсруулж, зах зээлд өрсөлдөх чадвартай, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, бус

нутгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлж, Монгол улсын эдийн засгийн өсөлтөд оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.2.2 Уул уурхай

Уул уурхайн салбарт 2019 онд Оюу-Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” гэсэн зорилтын хүрээнд эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэс баялгийн нөөцийг байгаль орчинд ээлтэй технологиор бүрэн ашиглаж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Мөн уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах, хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчныг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэх, өнгөт болон хар төмөрлөг, нүүрс-хими, барилгын материалын үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулна.

Геологи Геологийн 1:50000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд үргэлжлэх 18 төслөөс 4 төслийн үр дүнгийн тайланг хүлээн авч 2019 онд нийт нутаг дэвсгэрийн 2,4452 км² буюу 1.56 хувийг хамруулан, 2020, 2021 онд тус бүр 10 төслийн хүрээнд нийт нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулна.

Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг 2019 онд К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг эхлүүлэн, 2020 онд L хавтгайн хэмжээнд, 2021 онд M хавтгайн хэмжээнд нэгтгэнэ. Мөн агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлын хүрээнд Ховд-1 төслийг 2019 онд хэрэгжүүлж нутаг дэвсгэрийн 7 хувийг хамруулан, 2020 онд нутаг дэвсгэрийн 5.6 хувьд судалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.

Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлын хүрээнд 2019 онд нутаг дэвсгэрийн 20 хувьд гүйцэтгэх бөгөөд 2020-2021 онд үлдсэн хэсгийн судалгааны ажлыг үргэлжлүүлнэ.

Мөн томоохон хотуудын геоэкологи, гидрогоеологийн судалгааны ажлын хүрээнд 2019 онд 3 судалгааны ажлын үр дүнг хүлээн авч, 2020-2021 онд Ховд, Чойбалсан хотуудын судалгааны ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Геологи, ашигт малтмалын сэдэвчилсэн судалгааны ажлын хүрээнд 2019 онд Төв зүүн Монголын алтны судалгааны үр дүнгийн тайланг хүлээн авч, 2020-2021 онуудад 5 хүртлэх талбайд нарийвчилсан эрлийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн үндэсний геологийн алба байгуулах, геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах болон гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлуудыг 2019 оноос эхлүүлэхээр төлөвлөж байна.

Хүнд үйлдвэр. Хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд 2019 онд газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгааг хийх, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх мөн төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангаж ажиллана. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төслийг боловсруулж дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын хүрээнд үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг хийх бөгөөд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, үйлдвэрийн геотехникийн судалгааг хийж гүйцэтгэнэ.

Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулж, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулан, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлнэ.

Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрснээс нийлэг байгалийн хий боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжин ажиллана.

Мөн 2019 онд шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

2.2.3 Эрчим хүч

Эрчим хүчний салбарт 2019 онд дотоодын эрчим хүчний хэрэгцээг хангах эх үүсвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлуудыг үргэлжүүлэн, сэргээгдэх эрчим хүчийг бодлогоор дэмжиж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд Чойбалсангийн дулааны цахилгаан станц"-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийн гэрээ хэлэлцээрийг хийж, “Дулааны гуравдугаар цахилгаан станц”-ыг 250 МВт-аар өргөтгөх, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц”-ыг 35 МВт-аар нэмэгдүүлэх төслүүдийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.

Өмнийн бүсийн өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах “Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц”-ын хөрөнгө оруулагч болон цахилгаан худалдан авагч талуудын гэрээ хэлцлийг хийж, Багануурын 700 МВт-ын ДЦС барих төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Мөн шинээр баригдахаар төлөвлөж буй томоохон цахилгаан станцууд болон үйл ажиллагаа явуулж буй дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр тасралтгүй хангах ажлын хүрээнд Шивээ Овоо, Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг 2019 оноос эхлүүлнэ.

Шивээ Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том хүчин чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийн гэрээ хэлэлцээрийг хийж, барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх хүрээнд Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслийн суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.

Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд Тайшир-Есөнбулагийн 110 кв-ын 50 км урттай ЦДАШ, Есөнбулаг дэд станц барих төсөл, 220 Кв-ын Дархан дэд станцыг өргөтгөх төслүүдийн барилгын ажлыг 2019 оноос эхлүүлнэ.

Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгуудад байгаль орчинд ээлтэй дулааны станц, дулааны шугам сүлжээ барих ажлыг эхлүүлнэ.

Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Багануур, зүүн өмнөд бүс, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлнэ.

Метан хийн ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх ажлын хүрээнд метан хийн салбарын хөгжлийг дэмжсэн бүтэц зохион байгуулалт бий болгох, үүнтэй холбогдсон норм, дүрэм стандартуудыг батлуулан эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагааг бүрдүүлэхэд чиглэсэн технологийг олон улсын стандарттаар дамжуулан нэвтрүүлж эхэлнэ.

2.2.4 Зам, тээвэр

Азийн авто замын сүлжээний АН4 чиглэлийн авто замыг бүрэн ашиглалтад оруулах, үлдэж буй таван аймаг болох Говь-Алтай, Ховд, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, хилийн боомтуудыг аймгийн төвүүдтэй холбох ажлыг эхлүүлж, зарим боомтыг холбож дуусгах, орон нутгийн хөгжил болон тухайн бүс нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн орон нутгийн чанартай авто замыг үе шаттайгаар барьж байгуулах, нийслэл хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх хүрээнд авто зам, гүүрэн гарц барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 13. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто зам /км/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дараах онуудад					
		2015	2016	2017	2018	2019	2020
Хатуу хучилттай авто замын сүлжээний урт	км	5684.62	6402.72	6934.12	7294.52	7923.82	8663.8
Сүлжээнд эзлэх хувь	хувь	44.7	50.3	54.5	57.4	62.3	68.1

Эх үүсвэр: Зам, тээврийн хөгжлийн яам

Улаанбаатар хотын хүн амын өсөлттэй уялдуулан хотын иргэдийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахуйц автозамын сүлжээ, тээврийн дэд бүтцийг бий болгох,

хотын замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулж, түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах зорилготой нийтийн тээврийн шинэ төрөл болох Тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Төмөр замын салбарт улсын төсөв, Хөгжлийн банк, гадаадын зээл, тусламж болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хөөт-Бичигт төмөр замын төсөл, Эрдэнэт-Овоот төмөр замын төсөл, Улаанбаатар төмөр замын шинэчлэл, өргөтгөл, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Бүс нутгийн логистикийг хөгжүүлэх төсөл" зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Бүс нутгийн өрсөлдөх чадвар бүхий олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулж, эдийн үр ашигтай байдлыг бий болгоно.

Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Дорнод, Ховд, Хэнтий зэрэг аймаг болон томоохон сумдын нисэх онгоцны буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.2.5 Барилга, хот байгуулалт

"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулж батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.

Хөшигийн хөндийд баригдсан олон улсын нисэх буудлыг даган бий болох "ухаалаг" жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, Завхан, Орхон, Архангай, Хэнтий, Булган, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, Ханги, Зэлтэр Бичигт, Бургастай, Булган, Ханх зэрэг хилийн боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

АХБ, Франц улсын засгийн газар, бусад хандивлагч орнуудын зээл тусламжаар Өмнөговь аймгийн Даланзадгад хот, Дорноговь аймгийн Сайншанд хот, Өвөрхангай аймгийн Арвайхээр хот, Архангай аймгийн Цэцэрлэг, Дархан хотод шинэ цэвэрлэх байгууламж барих төслүүдийг хэрэгжүүлнэ. БНПУ, Унгар Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 5 аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх болон шинээр барьж, ашиглалтад оруулна.

Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхшуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар барьж байгуулан, хэрэглэгчдийг найдвартай цахилгаан, дулаан, усаар хангах техникийн боломж бүрдүүлнэ.

"Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж Алтай хотын иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах болно.

Нийслэлд 1000 айлын түр орон сууцыг барьж ашиглалтад оруулан, "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.2.6 Аялал жуулчлал

Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу байгальд ээлтэй Вангиллын үйлчилгээний жишиг цогцолборыг байгуулах ажлыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран эхлүүлнэ.

Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх зорилтын хүрээнд хөтөлбөрт туссан арга хэмжээг хэрэгжүүлж

Хөвсгөл нуурын тогтвортой аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлж, Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн цогцолбор болон Хүлэгбаатар Боорчи-Андлалын Өргөө цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

2.2.7 Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025)”-д тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хэмжээнд 2019 онд төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, цахим албан хэрэг хөтлөлтийн болон цахим шуудангийн системийн үйл ажиллагааг эхлүүлэх, тоон гарын үсгийн хэрэглээг дэмжих, хөдөө орон нутгийн интернэтийн үйлчилгээ хүрээгүй сумд, стратегийн болон аялал жуулчлалын бүс нутаг, хүн ам ихээр төвлөрдөг газарт утасгүй интернэтийн үйлчилгээг хүргэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны үзүүлэлт 2019 онд 21 аймгийн 310 сум шилэн кабельд холбогдож шилэн кабелийн нийт урт 37.9 мянган км болохоор байна.

2.3 ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.3.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2019 онд зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, MCYT, Политехник коллежид элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд мэргэжил, ур чадварыг эзэмшүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зохион байгуулалттай болон хувь хүний ур чадварт түшиглэсэн ажлын байр бий болгож “Гэрээт малчин” төсөл хэрэгжүүлнэ. Монгол залуусаа сургаж, дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадын ажиллагчдын тоог бууруулна.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр ажилгүйдлийн түвшин 2019 онд 7.5 хувьтай байхаар байна.

Төрийн албан хаагчдын ажлын ачаалал, үр дүн, хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, инфляцийн түвшинтэй уялдуулан цалинг нэмэгдүүлнэ.

Ядуу, эмзэг бүлэгт олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулж нэмэгдүүлнэ.

Үнэ ханшны өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Ядуу, эмзэг бүлэгт олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинд хүргэж нэмэгдүүлнэ.

Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлд чиглэсэн боловсрол, хөгжлийг дэмжих хөтөлбөр, хүүхэд, өсвөр үеийнхэнд үндэсний өв соёлыг уламжлуулах, тэдний хүмүүжил, төлөвшилд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлнэ.

Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээ авч, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан зорилтот бүлгийн өсвөр үе, залуучуудад амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгож, сургалтад хамруулна.

Төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох ээлтэй орчныг бүрдүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн цэцэрлэгүүдийг бүрэн камержуулна.

Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн аюулгүй, ая тухтай сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлж гурван ээлжээр хичээллэж буй сургуулийг хоёр ээлжинд бүрэн шилжүүлнэ.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээг бий болгохын зэрэгцээ сурх бичгийн түрээсийн тогтолцоог нэвтрүүлнэ.

Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөцийг хөгжүүлнэ.

Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд инноваци, судалгаа хөгжил, техник, технологийн ололтыг нэвтрүүлнэ.

Нийтийн биеийн тамирыг дэмжиж, иог, бясалгал, зохистой хөдөлгөөнөөр хичээллэсэн иргэнийг эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг тогтолцоог нэвтрүүлнэ.

2.3.3 Эрүүл мэнд

Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн нэгдсэн эмнэлэгүүдийн амбулатори болон хэвтэн эмчлүүлэх хэсэгт хүүхдийн мэс засал, мэдрэлийн болон нярайн нэгжийг байгуулна.

Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчилгээ оношилгооны чанарыг сайжруулан хүн амын дунд архи, тамхины хэрэглээг бууруулах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, эрүүл зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр сургалт, сурталчилгааг эрчимжүүлнэ.

Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, сэргийлэлтийг сайжруулан пневмококкийн эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ.

Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулан, тусlamж үйлчилгээнээс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэн нэг удаагийн хэрэгслийн хангамжийг сайжруулан, тоног төхөөрөмжийн чанарын хяналт баталгаажуулалтыг нэмэгдүүлнэ.

2.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

2.4.1 Байгаль орчин, ногоон хөгжил

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар дундын уялдаа, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлж, түүхий нүүрсний хэрэглээг 2019 оноос эхлэн Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд бүрэн халж, агаарын бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хөтөлбөрт туссан ажлуудыг холбогдох яамдын оролцоотойгоор үе шаттай хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд гэр хорооллын өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх, урамшууллыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлнэ.

Агаарын бохирдлыг бууруулахад шинэ техник, технологи нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрыг хамруулан 600.0 мянган га-аас доошгүй талбайг улсын тусгай хамгаалалтанд авна. Хамгаалалтын захиргаадын дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлэн хамгаалалтын захиргааны 11 байр, байгаль хамгаалагчийн 30 байр барьж, шинээр улсын тусгай хамгаалалтанд авсан газруудад хамгаалалтыг сайжруулах тэмдэгжүүлэлт, хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын ажилд шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж нийлүүлэх, байгаль хамгаалагчийн хувцас хэрэглэлээр хангана.

Байгаль орчин, цаг уурын шинжилгээний техник, технологийн шинэчлэл хийж, хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхаг, цаг уурын өртөөнийн барилга болон байгаль орчны төв лабораторийн барилгын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хот суурин газрын хүн амын унд ахуй болон үйлдвэрлэлийн ус хангамжийг сайжруулах хүрээнд гидрогеологийн дунд масштаб /1:200 000/-ын зураглалын ажлыг хийж, 3-аас доошгүй суурин газрын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоон баталгаажуулна. Усны нөөцийг зүй зохистой ашиглах хуримтлуулах, дахин ашиглах чиглэлээр бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрмийг орон нутагт 10-аас доошгүй газарт байгуулж, 100-аас доошгүй булаг шандны эхийг хашиж хамгаална.

Ой хамгаалал, ойжуулалтын ажлыг чанаржуулж, ойн нөхөн сэргээлт хийж, байгалийн сэргэн ургалтыг дэмжих зорилтын хүрээнд 200 мянган га-гаас багагүй талбайд ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажил гүйцэтгэж, 7,500-аас доошгүй га талбайд ойжуулалт, ойн сэргэн ургалтыг дэмжих ажлыг зохион байгуулж, ойн цэвэрлэгээг 30 мянгаас доошгүй талбайд хийж гүйцэтгэнэ.

2.5 ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

2.5.1 Хууль, эрх зүйн шинэтгэл

Шүүхийн шинжилгээний тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна.

Дотоодын цэргийн үйл ажиллагааг жигдрүүлж, материаллаг баазыг бэхжүүлж хил хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техник хэрэгслийг нэвтрүүлнэ.

Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, хүртээмжтэй шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.

Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, шинээр байгуулагдсан хуулийн этгээд, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд цахим хэлбэрээр бүртгэх үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Иргэний болон хуулийн этгээдийн архивын цаасан баримтыг цахимжуулах ажлыг дуусгаж, бүртгэлийн дотоод хэрэглээ болон цахим орчинд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.5.2 Төрийн өмчийн бодлого, зохицуулалт

Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, эдийн засгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон хэрэгжилтийг хангаж ажиллана.

Төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, компанийн сайн засаглалыг хөгжүүлэх замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар нэгдсэн удирдамж, бодлого зохицуулалтаар хангаж, төрийн өмчит үйлдвэрийн газар зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргээ хэрэгжүүлдэг байх хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр ажиллана.

Төрийн өмчийн хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэхдээ улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор хувийн хэвшлийн үр өгөөж бүхий хөрөнгө оруулалтыг татах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн оролцоог багасгах эдийн засгийн бүтцийг бий болгох, хувьчлалыг хууль эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлэх, төрийн өмчлөлөөр дамжуулан зохицуулж байгаа төрийн зохицуулалтыг багасгаж, зах зээлийн харилцаанд шилжүүлэх үндсэн зарчмыг баримтална.

2.5.3 Стандарт, хэмжил зүй

Экспортын тэргүүлэх салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд ноос, ноолуур, арьс шир, оёмол бүтээгдэхүүн, аялал жуулчлал, хүнсний салбарын үндэсний стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх бөгөөд ингэснээр олон улсын нийтлэг зарчим, практикт нийцсэн эрх зүйн орчин бүрдэж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, гадаад худалдааг хөнгөвчлөх өргөн боломж, нөхцлийг бүрдүүлэх, Худалдаан дахь саад тогторыг арилгах, иргэд аж ахуйн нэгжүүдийн экспортыг дэмжинэ.

Улсын эталоны нарийвчлалын түвшинг дээшлүүлж, баталгаажуулалтын болон эталон лабораторийг байгуулж, худалдааны тэнцвэртэй байдал, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцлийг бий болгох, худалдааг хөгжүүлэхэд тулгарч буй техникийн саад бэрхшээлийг арилгана.

Олон улсын түвшинд хүрсэн Үндэсний стандартын эзлэх хувийг 37.0 хувьд хүргэх төлөвлөгөөтэй байна.

Ази, номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APAC)-ын Олон талын хүрээнд харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ (MLA)-нд нэгдсэн байр сууриа хадгалж, давтан үнэлгээг 2020 онд хийлгэхээр төлөвлөж байна.

Үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж ISO 9001, ISO 14001, ISO 22000 зэрэг менежментийн шилдэг тогтолцоог нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ олон улс, бус нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.5.4 Улсын мэргэжлийн хяналт

Мэргэжлийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар ханган хяналт, шалгалтын үр дүнгээр эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлж шалгуулагч этгээдийн хууль сахин мөрдөлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Нэгдсэн болон орон нутгийн сүлжээ лабораториудын итгэмжлэлийг 5-аас доошгүй шинжилгээний үзүүлэлтээр өргөжүүлэх, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагаанд MNS/ISO IEC 17025:2007, MNS/ISO IEC 17043:2010 стандарт, лабораторийн зохистой дадал (GLP)-ын нэвтрүүлэх, эм биобэлдмэлийн лабораторийг ДЭМБ-аас итгэмжлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Орон нутгийн мэргэжлийн хяналтын лабораторийн ажиллах нөхцөлийг сайжруулснаар хяналт шалгалтын үйл ажиллагааны явцад хүнсний бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний баталгаат чанар сайжирч, хүн ам эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангагдана. Үндны усан дахь уран болон бусад хүнд металл тодорхойлох орчны шинжилгээний лабораторийг тоног төхөөрөмжөөр хангаснаар үндны усанд ураны агууламжийг тогтмол хянах зэрэг арга хэмжээг тусгасан.

2.5.5 Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах

Одоогийн мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа зах зээлийн шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох шаардлага байгаа тул Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2018-2020 онд Өрсөлдөөн ба хэрэглэгчийн эрхийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Монгол Улсын зах зээлд шударга өрсөлдөөний орчин нөхцөлийг хангаж ажиллах чиглэл баримтална.

2.5.6 Онцгой байдал

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны хүрээнд 2019 онд гамшигаас урьдчилан сэргийлэх, гамшигийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхийг сайжруулах, аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийн чадавхийг сайжруулах хөтөлбөр боловсруулах, гамшигийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах хүнсний болон шатахууны агуулахыг механикуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Гамшигийн агуулахад хадгалах бараа бүтээгдэхүүний хадгалалтын горим сайжирч гамшигийн үеийн аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг иргэдэд чанартай, хүртээмжтэй, хурдан шуурхай хүргэх боломж бурдэнэ.

Хүн амын нягтрал, тохиолдож байгаа гамшигийн төрөл, давтамжийг харгалзан томоохон хот, суурингуудыг түшиглэн гамшигийн голомтод шуурхай үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийг нэмж байршуулах, бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэн, бэлэн байдлыг ханггуулна. Төв орон нутгийн анги, байгууллагуудыг бие дааж ажиллах, шаардлагатай аврах ажлын зориулалттай машин техник, тусгай хувцас, багаж хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хөрөнгө оруулалт, гадаад орон, олон улсын байгууллагуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрөөр үргэлжлүүлэн шийдвэрлэнэ.

2.6 ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ

2.6.1 Гадаад харилцаа

Гадаад харилцааны салбарт энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хөрш орнуудын эдийн засаг, нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ОХУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн харилцаа, БНХАУ-тай тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны агуулгыг баяжуулах, эдгээр орнуудтай тэнцвэртэй харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны бодит үр өгөөжийг нэмэгдүүлэх, Монгол, Оросын стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр болон Монгол, Хятадын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гурван талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тэргүүлэх зорилтыг дэвшүүлж ажиллана.

Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад худалдааг хөнгөвчлөх бүхий л боломжийг

эрэлхийлж, эдийн засгийн өсөлтийг тогтвортжуулахад олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, түнш орнуудтай хамтран ажиллахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

Бус нутгийн интеграцид Монгол Улс оролцоо бага, гадаад худалдаа нэг зах зээлээс хэт хамааралтай, худалдааны гол түнш орнуудын зах зээлийн тарифын болон тарифын бус хамгаалалт хүчтэй байгаа зэргийг анхааран бус нутгийн интеграцид түлхүү оролцох, чөлөөт худалдааны хэлэлцээрүүд байгуулахыг зорьж ажиллана. Энэ хүрээнд Ази, номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэх, БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлаар судалгаа хийх зорилготой байна.

Хөрш орнуудтай дээд, өндөр түвшний айлчлалын давтамжийг хадгалж, хил орчмын хамтын ажиллагааг идэвхжүүлж, холбогдох байгууллагууд болон аймаг, муж хоорондын хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн солилцоог идэвхжүүлж, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын уулзалтыг зохион байгуулах чиглэлээр ажиллана.

Япон, БНЭУ, БНСУ, БНСВУ, Австрали, Казахстан зэрэг гол түнш орнуудтай дээд өндөр түвшинд харилцан айлчлал хэрэгжүүлэх, бус нутгийн улс орнуудтай уламжлалт, найрсаг харилцаа, хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын хамтын ажиллагааг цаашид бэхжүүлнэ.

АНУ-ын Мянганы сорилтын корпорацитай компакт гэрээ байгуулах, Канадын хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдийг нэмэгдүүлэх, Латин Америкийн орнуудын хөдөө аж ахуй, аялал жуулчлал хөгжүүлсэн туршлагыг нэвтрүүлэх, Булангийн орнуудаас хөрөнгө оруулалт татах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.

Европын чиглэлээр цаашид хоёр талын өндөр, дээд хэмжээний айлчлалууд, ЗГХК-ын хуралдаан, ГХЯ-дын хоорондын зөвлөлдөх уулзалтаар тохирсон зүйлсийн хэрэгжилтийг хангахад анхаарч, харилцаанд аль болох бодитоор хэрэгжих арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлнэ.

Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан чөлөөт бус байгуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд Замын-Үүд-Эрээний чөлөөт бус байгуулах ажлыг үргэлжлүүлж явцыг 80.0 хувьд хүргэх, монголын бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг бууруулах, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.6.2 Батлан хамгаалах

Монгол Улсын батлан хамгаалах эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, улс орчныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, Зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлэн батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, түүнийг хэрэгжүүлэх талаар батлан хамгаалах чадавхийг хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагад

нийцсэн, уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

Зэвсэгт хүчний энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн ротыг бэлтгэж, оролцуулснаар Монгол Улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох үндэсний байнгын хүчний чадавхи нэмэгдэж, улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг улс төр-дипломатын аргаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал алхам болно.

Материал хэрэгслийн нөөцийг зэвсэгт хүчний хэмжээнд оновчтой шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулж, Зэвсэгт хүчний лабораторийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2030/-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Олон улсын болон бус нутгийн аюулгүй байдлын орчны төлөв, өөрчлөлтийн хандлагад нийцүүлэн, үндэсний аюулгүй байдлыг хангахуйц батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, улс орны хөгжлийн зорилго, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэх үндсэн дээр улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хүний аюулгүй байдлыг найдвартай хангах зорилтыг ирэх жилүүдэд дэвшүүлэн ажиллана.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 119 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн таамаглалын эрсдэл. Макро эдийн засгийн таамаглалд дараахь тодорхой бус байдлууд байна. Үүнд:

- АНУ-ын засаг, захиргаанаас хэрэгжүүлж байгаа ган болон хөнгөн цагааны импортын тарифыг нэмэгдүүлэх бодлого нь БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж, улмаар тус улсын төмрийн хүдэр болон коксжих нүүрсний үнийг бууруулах дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна. Энэ тохиолдолд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн таамаглалыг бууруулж болзошгүй юм.
- БНХАУ руу нүүрс нийлүүлэгч орнуудын өрсөлдөөн нэмэгдэж байгаагаас гадна манай улсын нүүрсний тээвэрлэлт удаашралтай, авто замын чанар муудаж байгаа зэрэг олон асуудал нүүрсний экспортод сөргөөр нөлөөлж болзошгүй юм.
- Дэлхийн эдийн засгийн өсөлт эрчимжиж байгаагаас гадна геополитикийн тодорхой бус байдлууд хэвээр байгаа нь газрын тосны үнийг нэмэгдүүлж болзошгүй юм. Энэ тохиолдолд үйлдвэрлэлийн үндсэн орц болох түлш, шатахууны үнийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх юм. Мөн, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж, хүн амын бодит худалдан авах чадварыг бууруулах эрсдэлтэй.

Экспортын бүтээгдэхүүний үнийн бууралтаас үүдэх эрсдэлийн тооцоо: Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдал нь цөөн тооны экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай

байдаг. Дэлхийн глобал худалдааны нөхцөл байдлаас шалтгаалан нүүрсний үнэ тэр дундаа коксжих нүүрсний дундаж үнэ 2019, 2020 онуудад буурч болзошгүй олон улсын шинжээчид дурдсан байна. Мөн дэлхийн зах зээл дээрх төмрийн хүдрийн дундаж үнэ тус онуудад буурах эрсдэлтэй байна. Харин олон улсад цахилгаан авто машины эрэлт, үйлдвэрлэл нэмэгдэх, нөгөө талдаа дунд орлоготой иргэдийн хүрээ тэлэхээр байгаатай уялдан зэсийн хэрэглээ өсөж, дэлхийн зах зээл дээрх тус түүхий эдийн дундаж үнэ ирэх жилүүдэд өсөлттэй, тогтвортой өндөр хэвээр байхаар хүлээгдэж байна.

Экспортын зарим бүтээгдэхүүний үнийн бууралтаас үүдэн манай улсын макро эдийн засгийн тогтвортой байдалд тодорхой хэмжээний эрсдэл үүсэж болзошгүй. Иймд Ерөнхий тэнцвэрийн загвар буюу CGE загварыг ашиглан нүүрс болон бусад ашигт малтмалын үнийн бууралтын эдийн засагт үзүүлэх нөлөөг судалсан.

Тус эрсдэлийг Ерөнхий тэнцвэрийн загвар ашиглан тооцоходоо GAMS болон Interface эксель программын өргөтгөлийг ашигласан. Загварт дараах макро тэнцвэржүүлэгч хувьсагчид, нөхцөлийг авч үзсэн. Үүнд:

- Хүчин зүйлийн хувьд нөөц бүрэн шилждэг;
- Ашигт малтмалын олборлолт түүхий эдийн үнээс хамаарч өөрчлөгддөг;
- Шууд татварын хувь хэмжээ нь Засгийн газрын төсвийн балансыг тэнцвэржүүлнэ;
- Валютын ханш нь төлбөрийн тэнцлийг тэнцвэржүүлэгч хувьсагч байна.

Загвар дахь өгөгдөл. Загварт Монгол Улсын 2015 оны Social Accounting Matrix /SAM/ болон эдийн засгийн суурь өсөлт зэрэг өгөгдлүүдийг ашигласан.

Загварын үр дүн. GAMS программыг ашиглан экспортын үнийн нөлөөг судлан үзэхэд дараах үр дүн гарсан.

Хүснэгт 14. CGE загварын үр дүн Макро эдийн засгийн бодит үзүүлэлтүүд

Индикатор	2015	Суурь өсөлт, хувиар	Шокын нөлөө, өсөлт, хувиар
Хувийн хэрэглээ	1367.12	6.11	5.87
Засгийн газрын хэрэглээ	313.21	5.15	5.15
Хувийн хөрөнгө оруулалт	451.21	5.40	5.23
Засгийн газрын хөрөнгө оруулалт	21.39	6.09	6.07
Экспорт	1045.16	5.29	5.00
Импорт	1021.92	5.49	5.12
Бодит ДНБ	2117.14	5.31	5.20
Үндэсний нийт орлого	2213.53	4.87	4.72
Бодит валютын ханшын өөрчлөлт	Eps	0.03	0.19
Ажилгүйдлийн түвшин, хувиар	5.70	3.25	3.30

ДӨРӨВ. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД ОРЧИН

4.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ, ТҮҮНИЙ ТӨСӨӨЛӨЛ

Дэлхийн эдийн засаг 2017 оноос сэргэж эхлээд байна. Энэ нь АНУ, Канад, Франц, Герман, Итали, Испани зэрэг өндөр хөгжилтэй орнуудаас гадна хөгжиж байгаа томоохон эдийн засагтай орнууд болох Бразил, БНХАУ, Мексик зэрэг орнуудын эдийн засагт эерэг өөрчлөлт гарсантай холбоотой байна.

Хүснэгт 15. Дэлхийн эдийн засгийн өсөлт

	2012	2013	2014	2015	2016	2017	2018*	2019*	2020*	2021*
Дэлхий	3.5	3.5	3.6	3.5	3.2	3.8	3.9	3.9	3.8	3.8
Өндөр хөгжилтэй орнууд	1.2	1.3	2.1	2.3	1.7	2.3	2.5	2.2	1.7	1.7
АНУ	2.2	1.7	2.6	2.9	1.5	2.3	2.9	2.7	1.9	1.7
Евро бүс	-0.9	-0.2	1.3	2.1	1.8	2.3	2.4	2.0	1.7	1.5
Япон	1.5	2	0.4	1.4	0.9	1.7	1.2	0.9	2.8	2.8
Хөгжих буй орнууд	5.4	5.1	4.7	4.3	4.4	4.8	4.9	5.1	5.1	5.1
ОХУ	3.7	1.8	0.7	-2.5	-0.2	1.5	1.7	1.5	1.5	1.5
БНХАУ	7.9	7.8	7.3	6.9	6.7	6.9	6.6	6.4	6.3	6.0

Эх үүсвэр: "Дэлхийн эдийн засгийн төсөөлөл" тайллан, ОУВС, 2018 оны 4 дүгээр сар,

Тухайн улсын үндэсний статистикийн газрын төсөөлөл

АНУ. АНУ-ын эдийн засаг 2017 оны эцэст 2.3 хувиар, хэрэглээний үнийн индекс 2.1 хувиар өссөн байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш бодлогын хүүг 2015 оны 12 дугаар сард анх удаа нэмэгдүүлж байсан бол 2017.03.22-нд 0.25 нэгжээр, 2017.06.14-нд 0.25 нэгжээр, 2017.12.13-нд 0.25 нэгжээр, 2018.03.15-нд 0.25 нэгжээр тус тус нэмэгдүүлж 1.75 хувьд хүргээд байна. Ажилгүйдлийн түвшний хувьд 2018 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 4.1 хувьтай гарч, түүхэн доод түвшинд хэвээр хадгалагдаж байгаа ба татварын шинэчилсэн бодлогын (atatvar buuruulah) нөлөөгөөр хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг эрчимжих, гадаад худалдааны алдагдал нэмэгдэх төлөвтэй байгаа зэргээс 2018 оны 2 дугаар сард ХНС-гийн шинэ тэргүүнээр томилогдсон Джером Пауэлл энэ онд бодлогын хүүг дахин 2 удаа, ирэх онд 2 удаа өсгөх магадлалтай гэж шинжээчид үзэж байна.


АНУ-ын эдийн засаг цаашид үргэлжлэн өсөж, хөрөнгийн зах зээл өндөр өсөлтөө хадгална гэж тус улсын Төв банкны удирдлагууд үзэж байгаа ба 2018 онд эдийн засаг 2.9 хувиар, 2019 онд 2.7 хувиар өснө гэж таамаглаж байна.

Европын холбоо. Европын Холбооны гишүүн 28 улсын улирлын нөлөөг арилгасан бодит ДНБ-ий өсөлт 2017 оны эцэст 2.3 хувиар өссөн байна. Харин хэрэглээний үнийн индекс 2017 оны 12 дугаар сард 1.7 хувь, ажилгүйдлийн түвшин 7.3 хувь болж буурсан байна.

Европын Төв банк 2018.03.14-нд мөнгөний бодлогын цаашид баримтлах бодлогоо танилцуулсан байна. Энэ үеэр тус банкны тэргүүн Марио Драги "Евро бүсийн эдийн засаг тогтвортой өсөж байгаа ч АНУ-ын импортын татвар болон бусад эрсдэл, тодорхойгүй байдлууд үүсээд байгаа"-г анхааруулжээ. Цаашид инфляц тогтвортой өсвөл бонд худалдан авах хөтөлбөрөө зогсоно гэж Европын Төв банкны тэргүүн Марио Драги мэдэгдсэн байна. Евро бүсийн инфляц 1.2 хувьтай байгаа нь Төв банкных нь зорилтоос бага зэрэг доогуур үзүүлэлт болж байгаа юм.

Мөн Их Британийн Засгийн газар ЕХ-той цаашид харилцаагаа үргэлжлүүлэхийн тулд БРЕКСИТ-ийн төлбөр болох 40 тэрбум еврог төлөх бэлтгэлийг хангаж байна.

Япон. Япон улсын эдийн засаг 2017 оны эцсийн байдлаар 1.7 хувиар өслөө. Токио 2020 олимпын наадмын бэлтгэлтэй холбоотойгоор Засгийн газар зардлаа нэмэгдүүлсэн болон Японы Төв банкнаас хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын нөлөөгөөр дотоодын эрэлт сайжирсан гэж эдийн засагчид үзэж байна. Мөн 2017 оны 4 дүгээр улиралд иен чангарсан хэдий ч бараа, үйлчилгээний экспорт 10 гаруй хувиар өссөн дүнтэй байна.



Японы Засгийн газраас 2019 оны 10 дугаар сар хүртэл хэрэглээний татварыг нэмэх асуудлыг хойшшуулсантай холбоотойгоор цалин болон үнийн түвшин харьцангуй тогтвортой байхаар байна. Японы төв банкнаас инфляцын зорилтот түвшинг 2 хувьд хэвээр үлдээхээс мэдэгдсэн бөгөөд богино хугацааны бодлогын хүүгээ -0.1 хувьд, Японы Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөжийг 0 хувьд хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн байна. Улирлын нөлөөллийг арилгасан, хэрэглээний үнийн индекс 2017 оны 12 дугаар сард 101.2 (2015=100) болж, өмнөх сараас 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар өссөн байна.

ОХУ. ОХУ-ын эдийн засаг 2017 онд 1.5 хувь өсөж, сүүлийн 3 жилд анх удаа өсөлт үзүүллээ. Үүнд Европын холбооноос олон төрлийн хүнсний бүтээгдэхүүний импортыг хориглосонтой холбоотойгоор дотоодын үйлдвэрлэл сэргэсэн болон газрын тосны үнэ өсөж баррель нь 52.8 ам.долларт хүрсэн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс 2015 оны 8 дугаар сараас саарсан байна. ОХУ-ын бонд, үнэт цаасны төлөв бусад шилжилтийн эдийн засагтай болон газрын тосонд суурилсан эдийн засагтай оруулдтай харьцуулахад харьцангуй сайн байгаа тул төв банк бодлогын хүүгээ бууруулах нөхцөл бүрдэж байна.

БНХАУ. БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор ДНБ-ий өсөлт (зэрэгцүүлэх үнээр) 2017 онд 6.9 хувь болсон байна. Хэрэглээний үнийн индекс 2017 оны 12 дугаар сард 104.5 (2015=100) болж, өмнөх сараас 0.3 пунктээр өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 11 сард 3,759.8 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 911.1 (20.9 хувь) тэрбум ам.доллараар буурсан байна.

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн их хурал 2018.03.19-нд эхэлж, 2018 онд тавьж буй эдийн засгийн зорилтуудыг танилцуулсан. Үүнд ДНБ-ий бодит өсөлтийг 6.9 хувьд, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 2.6 хувьд барих, батлан хамгаалахын зардлыг 8 хувиар өсгөхөөр болсон байна. Түүнчлэн БНХАУ 2018 онд нүүрс олборлолтоо 150 сая тн, гангийн үйлдвэрлэлийг 30 сая тонноор бууруулах болсныг зарласан байна.

4.2 ГОЛЛОХ АШИГТ МАЛТМАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

Зэс. Дэлхийн зэсийн нийт хэрэглээ 2017 онд 1.4 хувиар өссөн бол 2018 онд 2.7 хувиар өснө гэж шинжээчид төсөөлж байна.

Хүснэгт 16. Цэвэршуулсэн зэсийн эрэлт, нийлүүлэлт /мянган тонн/

	2015	2016	2017	2018	2019
Үйлдвэрлэл	23,030	23,307	23,539	24,148	24,759
Хэрэглээ	22,893	23,412	23,733	24,378	24,978
Баланс	137	(105)	(194)	(230)	(219)

Эх үүсвэр: Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

Зэсийн нийт хэрэглээний тэн хагасыг эзэлдэг БНХАУ-ын эрчим хүч, барилгын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтуудтай холбоотойгоор зэсийн эрэлт нэмэгдэхээр байгаа нь ийнхүү таамаглахад хүргэжээ.

Хүснэгт 17. Дэлхийн зэсийн хэрэглээ /мянган тонн/

	2015	2016	2017	2018	2019
БНХАУ	11,353	11,642	11,923	12,328	12,711
Европ	3,338	3,357	3,423	3,458	3,520
АНУ	1,796	1,811	1,781	1,834	1,869
Япон	997	973	991	1,001	1,011
БНСУ	705	759	656	681	695
Латин Америк	622	672	718	739	757
Энэтхэг	491	499	482	517	556
Тайван	471	507	501	516	526
Бусад	3,120	3,191	3,258	3,304	3,333
Нийт	22,893	23,412	23,733	24,378	24,978

Эх үүсвэр: Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

Хүснэгт 18. Дэлхийн зэсийн нийлүүлэлт /мянган тонн/

	2015	2016	2017	2018	2019
БНХАУ	7,964	8,436	8,889	9,423	9,819
Европ	2,744	2,681	2,762	2,789	2,803
Чили	2,688	2,613	2,430	2,410	2,434
Япон	1,483	1,553	1,476	1,484	1,510
АНУ	1,141	1,221	1,069	1,069	1,079
ОХУ	876	876	867	867	867
Бусад	6,134	5,927	6,046	6,106	6,247
Нийт	23,030	23,307	23,539	24,148	24,759

Эх үүсвэр: Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

Алт. Дэлхийн хамгийн том алт олборлогч БНХАУ-ын Засгийн газраас алтны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үр ашиг багатай, жижиг уурхайнуудыг хаах шийдвэр гаргаад байгаа нь алтны нийлүүлэлтийн өсөлт саарахад хүргэж байна.

Хүснэгт 19. Алтны эрэлт, нийлүүлэлт /мянган тонн/

	2015	2016	2017	2018	2019
Үйлдвэрлэл	4,301	4,589	4,451	4,554	4,605
Эрэлт	4,886	4,362	4,072	4,240	3,916
Баланс	-565	226	379	314	689

Эх үүсвэр: Дэлхийн алтны зөвлөл (WGC), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

Төв банкуудын худалдан авах алтны хэмжээ, жижиглэн хөрөнгө оруулалтууд өсөх төлөвтэй байгаа ба бусад салбарын алтны эрэлт тогтвортой байхаар байгаа нь 2018 онд алтны нийт эрэлтийг 4.1 хувиар өсгөхөөр байна. Нөгөө талдаа дэлхийн улс төрд тодорхой бус байдлууд нэмэгдэж байгаагаас хөрөнгө оруулагчид алтанд хөрөнгөө байршуулах сонирхол нэмэгдэж байна.

Нүурс. Дэлхийн дийлэнх орнууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх Парисын хэлэлцээрт нэгдэн орж байгаа бөгөөд энэ нь цаашид дэлхийн нүүрсний хэрэглээг бууруулах хандлагатай байна.

Хүснэгт 20. Нүүрсний эрэлт, нийлүүлэлт /мянган тонн/

	2015	2016	2017	2018	2019
Үйлдвэрлэл	7,502	7,187	7,350	7,370	7,403
Эрэлт	7,608	7,457	7,489	7,451	7,408
Баланс	-106	-270	-139	-81	-5

Эх үүсвэр: Эрчим хүчиний мэдээллийн алба (EIA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

Монгол Улсын нүүрсний гол худалдан авагч БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2018 онд бага зэрэг буурахаар байна. БНХАУ агаарын бохирдолтой тэмцэх зорилгоор хүнд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авч эхлээд байгаа билээ.

Хүснэгт 21. Нүүрсний хэрэглээ /сая тонн/

	2015	2016	2017	2018	2019
БНХАУ	3,658	3,600	3,614	3,560	3,507
Энэтхэг	931	965	994	1,022	1,048
АНУ	727	666	656	649	635
ОХУ	237	224	229	233	238
ХБНГУ	234	224	217	210	204
Япон	190	190	188	187	185
Өмнөд Африк	175	178	180	182	183
БНСҮ	133	127	130	130	131
Польш	134	134	132	130	128
Австрали	132	131	131	131	130
Бусад	1,057	1,018	1,018	1,017	1,019
Нийт	7,608	7,457	7,489	7,451	7,408

Эх үүсвэр: Эрчим хүчиний мэдээллийн алба (EIA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хэмжээ 2017 онд 69.9 сая тн-д хүрсэн бөгөөд энэ нь өнгөрсөн оноос 17.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

БНХАУ 2017 онд нийт 69.9 сая тн коксжих нүүрс импортолсны 44 хувийг Австрали, 38 хувийг Монгол, 7 хувийг ОХУ, 6 хувийг Канад, 4 хувийг АНУ, 1 хувийг Индонези улсаас тус тус импортолсон байна.

2017 онд нийт 514.5 сая тн коксжих нүүрсний эрэлт үүссэн бол үүний 513.1 сая тонныг дотоодын олборлолт болон импортоор хангаж 1.4 сая тн коксжих нүүрсний хомсдолтой байжээ.

Газрын тос. Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага /OECD/-ын гишүүн биш орнуудын газрын тосны хэрэглээ 2018-2019 онуудад нэмэгдэх төлөвтэй байгаагаас шалтгаалж, дэлхийн нийт газрын тосны хэрэглээ 2018 онд 1.8 хувиар, 2019 онд 1.6 хувиар тус тус өсөхөөр байна.

Хүснэгт 22. Газрын тосны хэрэглээ /сая баррель, өдөр/

	2015	2016	2017	2018	2019
АНУ	24.6	24.7	24.9	25.0	25.1
Европ	13.8	14.1	14.4	14.6	14.6
Номхон далайн орнууд	8.1	8.1	8.2	8.1	8.2
Нийт ЭЗХАХБ*-ын гишүүн орнууд	46.4	46.9	47.4	47.7	47.9
/OECD/					
Тусгаар Улсуудын Хамтын нөхөрлөлийн улсууд	4.6	4.7	4.7	4.8	4.9
БНХАУ	11.6	11.8	12.5	13.0	13.4
Бусад Азийн орнууд	12.4	12.9	13.3	13.6	14.1
Латин Америк	6.7	6.6	6.6	6.7	6.9
Ойрхи Дорнод	8.4	8.3	8.3	8.5	8.7
Африк	4.3	4.3	4.3	4.5	4.6
ЭЗХАХБ-ын гишүүн биш Европын орнууд	0.7	0.7	0.7	0.8	0.8
Нийт ЭЗХАХБ*-ын гишүүн биш орнууд	48.6	49.3	50.4	51.8	53.2
Нийт дүн	95.0	96.2	97.8	99.5	101.2

*Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага /OECD/ Эх үүсвэр: Олон улсын энергийн агентлаг (IEA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

ОПЕК-ийн гишүүн болон гишүүн биш улс орнуудын үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой нэмэгдэх хандлагатай байна. ОПЕК-ийн гишүүн орнуудын үйлдвэрлэлийн хэмжээ 2018 онд 0.8 хувиар, 2019 онд 3.2 хувиар өсөж байгаа бол ОПЕК-ийн гишүүн биш орнуудын үйлдвэрлэл 2018 онд 3.5 хувиар, 2019 онд 0.5 хувиар тус тус өсөхөөр байна. Газрын тосны дэлхийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2018-2019 онд дунджаар 2 хувиар өсөхөөр байна.

Хүснэгт 23. Газрын тосны үйлдвэрлэл /сая баррель, өдөр/

	2015	2016	2017	2018	2019
ОПЕК газрын тос	31.4	33.6	32.4	32.5	33.8
ОПЕК байгалийн хий	6.6	6.8	6.9	7.1	7.0
Нийт ОПЕК	37.9	40.3	39.2	39.6	40.8
Австрали	0.4	0.4	0.3	0.3	0.3

Колумб	1.0	0.9	0.9	0.9	0.9
Малайз	0.7	0.7	0.7	0.7	0.7
Бусад Африкийн орнууд	1.4	1.0	1.1	1.2	1.2
Бусад	53.0	51.4	52.9	54.7	55.1
Нийт ОПЕК-ийн гишүүн биш орнууд	56.4	54.4	55.8	57.8	58.1
Боловсруулалтын ашиг	2.2	2.3	2.3	2.3	2.3
Нийт дүн	96.6	97.0	97.4	99.7	101.3

Эх үүсвэр: Олон улсын энергийн агентлаг (IEA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

Хүснэгт 24. Газрын тосны эрэлт, нийлүүлэлт /сая баррель, өдөр/

	2015	2016	2017	2018	2019
Үйлдвэрлэл	96.6	97.0	97.4	99.7	101.3
Хэрэглээ	95.0	96.2	97.8	99.5	101.2
Баланс	1.6	0.8	-0.4	0.2	0.1

Эх үүсвэр: Олон улсын энергийн агентлаг (IEA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл нь Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт, 123 бодлогын арга хэмжээг тусгаснаас гадна зорилт, арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг мөн тусгасан.

Салбарын яамд, агентлагуудаас ирүүлсэн арга хэмжээний саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа бодлогын зорилт, арга хэмжээг улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 20 зорилт 123 арга хэмжээний хүрээнд нийтдээ 8 их наяд 619.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 78.3 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 1 их наяд 800.3 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 5 их наяд 172.8 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 568.3 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.

ЗУРГАА. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 25. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017*	2018**	2019***	2020***	2021***
ДНБ, оны үнээр (тэрбум төгрөг)	22227.1	23134.1	23,935.9	27,167.4	30,662.0	34,714.4	39,040.3	42,788.6
Нэг хүнд ногдох ДНБ (мян.төгрөг)	7501.3	7642.9	7,747.9	8,624.9	9,543.6	10,310.9	11,346.1	12,191.7
ДНБ-ий бодит өсөлт (хувь)	7.9	2.4	1.2	5.1	5.0	8.0	6.0	6.0
Үүл уурхайн салбарын бодит өсөлт	19.4	14.1	0.2	-6.9	1.0	6.3	3.0	10.1
Үүл уурхайн бус салбарын бодит өсөлт	5.0	0.0	1.6	9.1	6.1	8.4	6.8	4.9
Хэрэглээний үнийн өсөлт (оны эцэст)	11.0	1.9	1.1	6.4	7.8	8.0	8.0	8.0

* Урьдчилсан гүйцэтгэл

** Хүлээгдэж буй гүйцэтгэл

***Төсөөлөл

--ooOoo--

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-ЫН ЧУУЛГАН, БАЙНГЫН ХОРООДЫН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ ҮЕД ОРОЛЦОХ АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Албан тушаал	Нэрс
1	Сангийн сайд	Ч.Хүрэлбаатар
2	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Н.Цэрэнбат
3	Гадаад харилцааны сайд	Д.Цогтбаатар
4	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Ц.Нямдорж
5	Батлан хамгаалахын сайд	Н.Энхболд
6	Барилга, хот байгуулалтын сайд	Х.Баделхан
7	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Ц.Цогзолмаа
8	Зам, тээврийн хөгжлийн сайд	Ж.Бат-Эрдэнэ
9	Уул уурхай, хунд үйлдвэрийн сайд	Д.Сумъяабазар
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	С.Чинзориг
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Б.Батзориг
12	Эрүүл мэндийн сайд	Д.Сарангэрэл
13	Эрчим хүчний сайд	Ц.Даваасүрэн
14	Монголбанкны Ерөнхийлөгч	Н.Баяртайхан
15	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	С.Даваасүрэн
16	Үндэсний аудитын газрын дарга	Д.Хүрэлбаатар
17	Үндэсний статистикийн хорооны дарга	А.Ариунзаяа
18	Үндэсний хөгжлийн газрын дарга	Б.Баяртайхан
19	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга	Б.Чинбат
20	Онцгой байдлын ерөнхий газрын дарга	Т.Бадрал
21	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга	Н.Цагаанхүү
22	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга	Ц.Ням-Осор
23	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газрын дарга	Б.Лхагва
24	Стандарт, хэмжил зүйн газрын дарга	Г.Гантөмөр
25	Сангийн дэд сайд	Х.Булгантуяа
26	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	С.Наранцогт
27	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга	Ц.Цэнгэл
28	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга	Д.Даваасүрэн
29	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Г.Баясгалан
30	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга	Х.Батбилэг
31	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
32	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Л.Цэдэвсүрэн

33	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Ж.Бат-Эрдэнэ
34	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Г.Нандинжаргал
35	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	Г.Өнөрбаяр
36	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Энхбат
37	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Э.Содномжамц
38	Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга	З.Мэндсайхан
39	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга	Г.Батхүрэл
40	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Ж.Ганбат
41	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга	И.Батхүү
42	Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга	М.Батхуяг
43	Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга	Г.Түvdэндорж
44	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга	Э.Алтанзул
45	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын Макро эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга	Н.Энхбаяр
46	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн	Х.Оюунцэцэг
47	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн	С.Сүхдэлгэр
48	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн	Л.Түвшинжаргал
49	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн	Д.Очирваань
50	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн	Б.Мөнгөнцацral
51	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын гэрээт ажилтан	Э.Билгүүн
52	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн	Ж.Ганбаяр
53	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн	Т.Дэлгэрнаран
54	Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн	З.Баярхүү

---оо---